

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ
/ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

2018.12.28

№	Агуулга	Зорилтын тоо	Хэрэгжилтийн явц					Хувь
			100	70	40	0	Үнэлэх боломжгүй	
1	ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ - НИЙГМИЙН ХӨГЖИЛ	39	31	7	1	-	-	93,0%
2	ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ - ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ	42	39	3	-	-	-	97,8%
3	ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	17	15	2	-	-	-	96,4%
4	ЖАРГАЛТАЙ ОРЧИН - НОГООН ХӨГЖИЛ	10	9	1	-	-	-	97,0%
5	ЖАРГАЛТАЙ ИРГЭН - НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ	33	29	4	-	-	-	96,3%
Дүн		141	123	17	1	-	-	95,9%

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгэний хувь
1. ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ-НИЙГМИЙН ХӨГЖИЛ							
1.1 ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ							
1	1.1.1 Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, иргэний бүртгэл мэдээллийн технологийг боловсронгуй болгох “Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	1. Халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулж, эрт илрүүлэг, үзлэг оношилгоог эрчимжүүлэн, тархалтыг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.	ЭМТ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Халдварт өвчнийг бууруулах чиглэлээр тайлант хугацаанд “Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Дархлаа сайжруулах цэгэн иллэг”, “Гар тогтмол угаацгаая” сургалтыг цэцэрлэгийн 4209 хүүхдэд, ерөнхий боловсролын сургуулийн 3393 сурагчдад, 1063 эцэг эхэд сургалт зохион байгуулж, 4400 ширхэг сурталчилгааны материал зөвлөмж өгч тараасан. Сүрьеэтэй тэмцэх” дэлхийн өдрийн хүрээнд дүүргийн 1-3, 4-5, 6, 7, 9, 10-р хорооны иргэдэд “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” сэдэвт 5 өдрийн сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. Сурталчилгаанд нийт 350 иргэнийг хамруулсан. “Ариун цэврийн байгууламжаа сайжруулах CLTS” аргачлалд нийт 189 иргэд өрхийг хамруулснаас 76 өрх ариун цэврийн байгууламжийг сайжруулах ажлуудыг хийж байна. Харин өрхийн ус, орчны эрүүл ахуй ба ариун цэвэр “Гэр үнэлгээ” аргачлалд нийт 85 иргэд хамрагдсанаас 41 иргэн стандартын шаардлага хангасан “Цагаан өнгөтэй” усны сав өөрөө худалдаж авах амлалт өгсөн. НЭМГ, ЧДЭМТ-өөс “Орчны бохирдол хөрсний бохирдол”-той холбоотой 6 төрлийн 864 ширхэг гарын авлага, 3 төрлийн 120 гаруй зурагт хуудас, Харшлаас урьдчилан сэргийлэх 2 төрлийн 670 ширхэг		100	100		

		<p>гарын авлага ашиглан нийт 1600 гаруй иргэдэд эрүүл мэндийн тэр дундаа хөрс, ариун цэврийн байгууламж, орчны эрүүл мэндийн чиглэлээр цогц мэдээлэл өгч ажилласан. ӨРХИЙН УС, ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙ БА АРИУН ЦЭВЭР” гэр үнэлгээ аргачлалаар дүүргийн 7-19 дүгээр хороо бүрээс айл өрхийн ахуйн ариун цэврээс үүдэлтэй халдварт өвчнүүдэд өртөх эрсдэлтэй, зан үйлээ өөрчлөх шаардлагатай, ариун цэврийн байгууламж нь стандартын шаардлага хангахгүй 20 өрх нийт 260 өрхийг сонгож “ӨРХИЙН УС, ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙ БА АРИУН ЦЭВЭР”-ийг сайжруулах гэр үнэлгээний асуумж болон сургалтад нийт 3 удаа хамруулан зөвлөмж өгч ажиллан 65 өрхөд стандартад нийцсэн усны сав, эрүүл ахуйн багцыг олгосон. Халдварт өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, тархалтыг багасгах зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Илрүүл эмчил сэргийл бид өрх бүрд хүрч ажиллана" эрүүл мэндийн төслийг хэрэгжүүлж байна. “Илрүүл, эмчил, сэргийл” төслийн хүрээнд СУИС-ийн салбар 6 сургууль, 1 ахлах сургууль, дотуур байрны 1131 оюутан сурагч, Ерөнхий боловсролын 7 сургуулийн нийт 3552 багш, ажилчид, сурагчид, 2 байгууллагын нийт 229 ажилтан, албан хаагч, 1 асрамжийн газрын 44 хүүхэд, Цэрэг татлагын цэргийн насны залуус 174, үзлэг хамруулан нийт 5130 иргэнд сүрьеэ өвчний эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээг хийж 17 өвчлөл илрүүлэн эмчилгээнд бүрэн хамрууллаа. Үүнээс оношийн ангиллаар түрхэц эерэг халдвартай тохиолдол 3, сөрөг 12, олон эмд тэсвэртэй 1, бусад эмд тэсвэртэй 1 сүрьеэ илэрсэн байна. Төслийн хүрээнд Бөмбөгөр, Хүчит шонхор, Нарантуул 2 зах дээр нийт 753 хүнд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан бөгөөд сэжигтэй тохиолдол илрээгүй. Шэжид Дүг ӨЭМТ нь Сүрьеэгийн илрүүлэг шинжилгээнд салбар дундын оролцоог нэмэгдүүлэх аяны хүрээнд 12 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Албадан саатуулах төв, Албан бус насан туршийн боловсролын төв, 220 цэцэрлэг, 12-р хороо, Нийслэлийн хот тохижилт үйлчилгээний газар гэсэн 5 байгууллагын 107 ажилчныг цээжийг гэрэлд харах шинжилгээнд хамруулж сэжигтэй 3 тохиолдлыг илрүүлэн хяналтад авсан.</p> <p>Халдварт бус өвчний чиглэлээр Эрүүл мэндийн төв, дүүргийн харьяа төрийн өмчийн 15 сургууль, 29 цэцэрлэг, 16 ӨЭМТ-ийн дунд 2018 оны 1 дүгээр сарын 24-өөс 3 дугаар сарын 4-ны хооронд “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлье” үйл ажиллагааны хүрээнд “Миний гэр-аюулгүй орчин” сэдэвт аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд 9598 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа явуулсан. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны /15-39 нас/ нээлтийн үйл ажиллагааг өдөрлөг хэлбэрээр зохион байгуулж эрт илрүүлгийн шинжилгээнд нийт 170 хүнийг хамруулж С вирустэй 6 хүн, В вирустэй 12 хүнийг</p>		
--	--	---	--	--

		<p>илрүүлж, дотор, халдвартын эмчийн үзлэг хийн, цусны даралт, биеийн жингийн индексийг тодорхойлж зөвлөгөө өгч нийт 2854 ширхэг гарын авлага материал тараан сурталчилсан. Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн 2 дахь шатны элэгний В, С вирусийн эрт илрүүлгийн оношлуурын тендер зарлагдан, оношлуурыг хүлээн авч дүүргийн 1-19 дүгээр хороодын ӨЭМТ-үүдэд хуваарийн дагуу тарааснаар эрт илрүүлэлт, эмчилгээ хэвийн явагдаж байна. Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн цахим болон ӨЭМТ-үүдийн шинжилгээ авах, ЭМТ-д илгээх талаар чадавхжуулах сургалтыг Эрүүл мэндийн яамнаас нийт 2 удаа авч ЭМТ, ӨЭМТ-үүдийн нийт 38 эмч, ЭМНА, мэргэжилтнүүд хамрагдсан. НЗДТГ, НЭМГ, Оном сан хамтран Цусны даралтаа хянаж сурцгаая уриан дор “Цусны даралт ихсэлттэй тэмцэх Дэлхийн өдөр”-ийг Сүхбаатарын талбай дээр зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд даралт үзэх-258, мобайл технологийн аппарат ашиглан зүрхний бичлэг хийх 48, зүрх судасны эмчийн үзлэг-65, биеийн жингийн индекс тодорхойлох, төвийн таргалалт хэмжилт-112, архи тамхины хэрэглээ зөвлөгөө-51, эрүүл мэндийн сурталчилгаа-нийт792 хүнийг хамруулан ажилласан. “Дэлхийн тамхигүй өдөр”-ийн угтан дүүргийн ЭМТ-ийн Сэтгэц-наркологиын кабинет, Өсвөр үеийн кабинетууд хамтран дүүргийн ЕБС-ын эмч бүлгэмүүдийн дунд “Донтолтоос сэргийлэх нь” аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд ЕБ-ын 24, 37, 57, 117, 61, 17-р сургуулиуд идэвхтэй оролцож бага ангид “Ухаалаг утас ба дэлгэцийн донтолт” сэдвээр 475 хүүхэд, дунд болон ахлах ангид “Архи, тамхи мансууруулах бодисын хор уршиг”, “Цахим гадуурхал” сэдвээр нийт 855 сурагчийг хамруулан сургалт зохион байгуулсан. “Дэлхийн гепатитын өдөр”-ийн хүрээнд Сүхбаатарын талбайд болсон өдөрлөгөөр эрүүл мэндийн даатгал төлөх боломжгүй 156 иргэнд В, С вирусын илрүүлэг хийгдэн В вирустэй 18 хүн, С вирустэй 30 хүн шинээр илэрсэн.</p>					
		<p>2. Мэдээлэл технологийн дэвшилд тулгуурлан анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгана.</p>	ЭМТ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		<p>Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12, 17 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологийн багц нийлүүлээд байгаа бол дахин 45,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 хороонд мобайл технологийн багц нийлэхээр ажлын тендерийг зарлаад байна. Дүүргийн 19</p>	100	100			

	<p>хороодын 16 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд E-HEALTH програм хангамж бүрэн нэвтэрч Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс Эрүүл мэндийн төврүү үзлэгийн цаг захиалга өгч байна. 19 хороодын 16 өрхийн эрүүл мэндийн төвд E-health цахим систем нэвтэрснээр ЭМТ болон ӨЭМТ хамтран хүн амын санг үүсгэж байна. 2018 оны 09 сарын 17-ны байдлаар 107222 хүн амын мэдээллийн сан үүсээд байна. Чингэлтэй дүүргийн хэмжээнд “Active Directory Domain Control” системийг нэвтрүүлэх ажил дуусах шатандаа явж байна. ADDC системд тулгуурлан цахим мэдээллийн аюулгүй байдлыг бий болгож мэдээллийн сүлжээ, системийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Дүүргийн ЭМТ болон Өвөр Монголын Өөртөө Засах орны Олон улсын монгол эмнэлгийн хамтын ажиллагааны хүрээнд үндсэн болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг зохион байгуулж, дүүргийн ЭМТ-ийн төв салбарын сургалтын өрөөнд телемедициний иж бүрэн тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад оруулсан.</p>					
	<p>3. Эмч, эмнэлгийн ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг чадваржуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.</p>	ЭМТ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газар, АШУҮИС хоорондын хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн 15 сувилагч “Өрхийн сувилахуй” мэргэжлийн сургалтад хамрагдаж мэргэшлийн үнэмлэх гардаж авсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах туршлага судлах, уламжлалт анагаахын шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээний хуралд ЭМТ-ийн эмч мэргэжилтнүүдийг оролцуулах, хүний нөөцийг чадавхжуулахаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Олон улсын Монгол эмнэлэгт ЭМТ-ийн даргаар удирдуулсан баг 4 хоногийн хугацаатай ажилласан. Цаашид хүүхдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ялангуяа хүйтэн сэрүүний улиралд ханиад томуу, уушгины хатгаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, монгол уламжлалт анагаах ухааны эмчилгээ, тархины саажилт, тархины цус харвалтын дараах сэргээн засах эмчилгээ, хөдөлмөр засал, дотрын өвчнүүдийн уламжлалт эмчилгээний алсын зайн оношилгоог хийх талаар хамтран ажиллахаар болсон. ОХУ-ын Эрхүүгийн АУИС-д 14 хоногийн хугацаатайгаар ЭМТ-ийн дотор, мэдрэл, дүрс оношилгооны</p>				100	100

	<p>чиглэлээр нарийн мэргэжлийн 4 эмч мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. Мөн Тайваний Юань Рун эмнэлэгт шүд, рентгений чиглэлээр ЭМТ-ийн 2 эмч мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. Төрөлжсөн нарийн мэргэжлийн MRI 6 сарын сургалтад 1 их эмч, хүүхдийн мэдрэл судлалын 6 сарын сургалтад хүүхдийн 1 их эмч, Хүүхдийн хоол боловсруулах судлалын 6 сарын сургалтад хүүхдийн 1 их эмч, хүүхдийн мэдрэл судлалын 3 сарын сургалтад 1 сувилахуйн арга зүйч, хүүхэд судлалын 3 сарын сургалтад хүүхдийн 1 сувилагч, эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэлт судлалын 3 сарын сургалтад 1 сувилагч, ЭХО-ны сургалтад 2 эмч, тархвар судлалын сургалтад 1 эмч, мэс заслын сувилахуйн сургалтад 1 сувилагч, Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын 1 жилийн сургалтад дотрын 1 их эмч хамрагдсан. Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн Улсын их сургууль, Тэгш хамруулах боловсролын бүсийн төв, Өвөрбайгалийн хязгаарын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Нийгэм-Эрүүл мэндийн сэргээн заслын “Росток” төвтэй хамтран ажиллах түншлэлийн гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тархины саажилтын тулгуур хөдөлгөөний тогтолцооны эмгэгийн үед хөдөлгөөн байрлалын мэдрэхүйг засах хөдөлгөөн заслын шинэ технологи “Адели” эмчилгээний өмсгөл, “Атлант” хийт өмсгөл, морин заслын эмчилгээг Монгол Улсад нэвтрүүлэхтэй холбогдуулан дүүргийн Эрүүл мэндийн төвийн сэргээн заслын мэргэжлийн эмч нарыг тус эмчилгээний арга зүйд сургах сургалтыг 06 дугаар сарын 11-ээс 06 дугаар сарын 13-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед өндөр ачаалалтай ажилласан 57 эмч эмнэлэгийн ажилтанд 5,7 сая төгрөг, ӨЭМТ-ийн гүйцэтгэлийн гэрээний үнэлгээгээр А, В дүгнэгдсэн ӨЭМТ-дэд 27,8 сая төгрөгийн урамшууллыг тус тус олголоо. Тайваны ЭМ-ийн холбооны шугамаар хүрэлцэн ирсэн Цэргийн нэгдсэн эмнэлэг (Tri-Service General Hospital), Юн Руаны нэгдсэн эмнэлэг,(Yuan Rung General Hospital) Тайчуны ахмад дайчдын нэгдсэн эмнэлэг (Taichung Veterans General Hospital) удирдлага, төлөөлөгчидтэй дүүргийн ЭМТ-ийн дарга болон удирдлагын төлөөлөл хүний нөөцийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор тус эмнэлгүүдтэй 2018-2021 онд хамтран ажиллах талаар харилцан ярилцаж санал солилцлоо. Цаашид эдгээр эмнэлгүүдэд эмч, сувилагч, НЭМ-ийн мэргэжлийн хүмүүсийг сургахаар тохиролцсон бөгөөд хамгийн гол шалгуур болох англи хэл, мэргэжлийн англи хэлний мэдлэгтэй ажилтнуудаас сонгон шалгаруулж, баг болгон явуулахаар боллоо. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах сарын хүрээнд “Бид хэзээд бэлхэн” сэдвийн хүрээнд амралт, өдөрлөгийн арга хэмжээг зохион</p>		
--	---	--	--

		<p>байгуулсан. Уг өдөрлөгийн хүрээнд шинээр орсон ажилтнуудыг хооронд нь танилцуулах, залуу ажилтнуудын урлаг спортын авьяас чадварын нээн илрүүлэх, багаар ажиллах чадварын дээшлүүлэхэд чиглэсэн. Мөн Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан цол тэмдгээр 3 хүн, ЭМЯ-ны Жуух бичиг болон НЭМГ-ын Тэргүүний ажилтан, Хүндэт өргөмжлөл, дүүргийн ЗДТГ-н Хүндэт өргөмжлөлөөр 3 хүн, Хөдөлмөрийн алдар тэмдгээр 5 хүн шагнагдсан. Сүрьеэ, ХДХВ/ДОХ/БЗДХ-ын эрт илрүүлгийг нэмэгдүүлж, зорилтот иргэдийг эмчилгээ, оношилгоонд бүрэн хамруулах, урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх зорилгоор “Илрүүл, Эмчил, Сэргийл, Бид өрх бүрд хүрч ажиллана” зорилтот төслийн хүрээнд дүүргийн төсвийн 185,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эрт илрүүлгийн зөөврийн Portable X-Ry wireless Detector Mobi Rad50 маркийн дүрс оношилгооны тоног төхөөрөмж, 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүрьеэ, ХДХВ/ДОХ/БЗДХ кабинетад шаардлагатай тоног төхөөрөмж, 94,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мобайл технологийн багц тоног төхөөрөмж Эрүүл мэндийн төвд олголоо.</p>					
		<p>4. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	ЭМТ, НХХ	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	100%		
		<p>Дүүргийн төсвийн 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Эрүүл мэнд-2020” хөтөлбөрийн хүрээнд эмнэлгийн байгууллагын материаллаг орчин сайжруулахаар дүүргийн ЭМТ болон ӨЭМТ-үүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай зөөврийн кварц, лабораторийн шилэн хөргөгч, УВЧ шарлагын аппарат, бэлгийн замын халдварт өвчин илрүүлэх тест, урвалж хэрэгслээр тус тус хангалаа. НЭМГ, Оном сангаас хамтран “Эрүүл зүрх-Эрүүл Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд ӨЭМТ-ийн 71 эмч, 65 сувилагч, 15 ЭМНА, 58 ЭМ-ийн СДИ-үүдийг “Эрүүл амьдрах зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах, үйл ажиллагааг хянах дүгнэлт өгөх нь” сэдэвт сургалтад хамруулж бэлтгэгдсэн ба ӨЭМТ-үүдэд эмчийн тоогоор цусны даралт хэмжих сүүлийн үеийн 75 ширхэг аппаратыг гардуулж өгсөн. Гамшгийн үеийн бэлэн байдлыг сайжруулах зорилгоор ӨЭМТ-ийн эмч, сувилагч нарт гамшиг, эрэмбэлэн ангилалт, анхны тусламжийн сургалтад 50 эмчийг хамруулж, тэднээр нийт ажилтнуудад мэдлэг, чадвар олгох ажлын байрны сургалтыг явуулсан. 2018 оны 6, 9, 10 дугаар сард ӨЭМТ бүрд явагдах урьдчилан сэргийлэх ӨЭМТ болон ЭМТ хамтарсан нарийн мэргэжлийн үзлэгийн хуваарийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ӨМӨЗО-ын Олон Улсын Монгол</p>			100	100	

		эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу Хүүхдийн амбулаторид дүүргийн 16-19-р хороодын харьяа давхардсан тоогоор нийт 443 иргэнд үнэ төлбөргүй үзлэг зөвлөгөөг зохион байгуулсан. Үзлэгт хамрагдсан иргэдийн ихэнх нь ахмад настнууд байсан ба үзлэг зөвлөгөөний дараа үнэ төлбөргүй уламжлалт эмчилгээний тан өгсөн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2 Өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологийн багц /зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, дүрс оношилгооны аппарат, урвалж тест гэх мэт/ олголоо.					
		5. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сайн дурын үйл ажиллагаатай аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэдийн үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжин хамтран ажиллана.	ЭМТ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Дүүргийн хэмжээнд нийт 134 ЭМССТ нар 16 ӨЭМТ-үүдэд ажиллаж 2018 оны эхний 9 сарын байдлаар 18 сургалт, 6 нээлттэй хаалганы өдөрт оролцож давхардсан тоогоор 35400 орчим иргэдэд хүрч эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг хийж ажилласан. Эрүүл мэндийн сайн санааны туслагч нар “Сургагч багш”-ийн нийт 4 удаагийн сургалтаар давхардсан тоогоор нийт 206 ЭМССТ нар сургалтад хамрагдсан байна. ЭМД сангийн “Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх” сургагч багшаар бэлтгэгдсэн 1-19-р хорооны ӨЭМТ-үүдийн 80 ЭМССТ нар 2018 оны 9 сарын байдлаар Томуу томуу төст өвчний чиглэлээр 18 үйл ажиллагаанд 11250 иргэн, Агаарын бохирдлын чиглэлээр 25 сургалт, сурталчилгаа нийт 3250 иргэн, Эмийн зохистой хэрэглээний чиглэлээр 12 үйл ажиллагаа нийт 1570 хүнийг тус тус хамруулсан. Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Орон нутаг ариун цэврийн асуудлаа өөрсдөө шийдэх нь” сургалтад дүүргийн 12 “Эрүүл мэндийн сайн санааны туслагч” хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн. НЭМГ-аас "Гэмтэл согог судлалын үндэсний төв"-д "Ахмад настныг осол гэмтлээс сэргийлэх нь" сэдэвт сургалтад ӨЭМТ-үүдийн нийт 60 ЭМССТ нар хамрагдсан. Эрүүл зүрх-Эрүүл Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд “Артерийн гипертензийн оношилгоо, хянах дүгнэлт өгөх” сэдэвт сургалтад дүүргийн 16 ӨЭМТ-үүдийн нийт 58 Эрүүл мэндийн сайн санааны туслагч нарыг хамруулсан. 2018 оны Эрүүл мэндийг дээдлэгч өрх, иргэний материалыг хүлээн авч НЭМГ-т хүргүүлсэн.			100	100	
2	1.1.2 Дүүргийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүүхдийн эмнэлэг,	1. Дүүргийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүүхдийн эмнэлэг, яаралтай түргэн тусламжийн төв, Эмчилгээ	ЭМТ, НХХ	Барилгын ажлын явц хувиар	50%		

	<p>яаралтай түргэн тусламжийн төв, Амбулатори-2-ийн барилгыг барихад хамтран ажиллана.</p>	<p>оношилгооны төв, жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг эхлүүлнэ.</p>					
3	<p>1.1.3 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.</p>	<p>1. Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулна.</p> <p>Дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 32 эмчид “Менингококкт халдвар, салхинцэцэг өвчний эмнэлзүй, илрэх шинж тэмдэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт”, “Салхинцэцэг өвчний үеийн голомтын арга хэмжээ, урьдчилан сэргийлэлт”, “Нийслэлийн хэмжээнд хийгдсэн менингококкт халдварын үеийн эрсдлийн үнэлгээг танилцуулах”, “ЭМС-ын 37 дугаар тушаал”, “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж” сэдвүүдээр эрүүл мэндийн төвийн халдвартын эмч, халдвар судлагч нар сургалт зохион байгуулсан. Сургуулийн эмч нар өөрсдийн сургуулийн сурагчдад сургалт мэдээлэл явуулахдаа хорт зуршлаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг тогтмол өгч хэвшсэн. “Дэлхийн тамхигүй өдөр”-ийн угтан дүүргийн Эрүүл мэндийн төвийн Сэтгэц наркологийн кабинет, Өсвөр үеийн кабинетууд хамтран дүүргийн ЕБС-ын эмч бүлгэмүүдийн дунд “Донтолтоос сэргийлэх нь” аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд 24, 37, 57, 117, 61, 17-р сургуулиуд идэвхтэй оролцож бага ангид “Ухаалаг утас ба дэлгэцийн донтолт” сэдвээр 475 хүүхэд, дунд болон ахлах ангид “Архи, тамхи мансууруулах бодисын хор уршиг”, “Цахим гадуурхал” сэдвээр нийт 855 сурагчийг хамруулан сургалт зохион байгуулсан. ЕБС-ын Эмч бүлгэмийн сурагчдын дунд “Цахим гадуурхал” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарлан шилдгүүдийг тодрууллаа. “Эрүүл залуус” аяны хүрээнд дүүргийн харьяа СУИС, УБЭИС, ЭАУИС, Шинэ Иргэншил МСҮТ-ийн нийт 420 оюутанд “Тамхинаас гарах хүсэл төрүүлэх, хорт зуршлыг хаях нь” сэдвээр сургалтыг зохион</p>	ЭМТ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	100	100

		байгуулсан.					
		2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.	ЭМТ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Тайлант хугацаанд 519 удаагийн сургалтыг 26606 хүнийг хамруулж, 306 төрлийн давхардсан тоогоор 60535 ширхэг ЭМСС-ны материал тараасан. Эрүүл мэндийн өдөрлөгийг 91 удаа зохион байгуулан нийт 26546 хүнийг хамруулсан. Нийт 25 удаагийн аян давхардсан тоогоор 25722 хүнийг хамруулсан. Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр Агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх чиглэлээр 17 удаагийн эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааг зохион байгуулж нийт 8712 хүнийг хамруулан ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, БНСУ-ын Бусан хот хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 10 дугаар сарын 1-ний өдөр дүүргийн 12 дугаар хорооны “Шижиддүг” Өрхийн эрүүл мэндийн төвд Бусан хотын эмч нар үнэ төлбөргүй үзлэг, оношилгоо хийсэн. Бусан хотын 46 эмч, сувилагч дүүргийн 450 гаруй иргэнд уламжлал, мэдрэл, дотор, нүд, нярайн үзлэг, оношилгоог үнэ төлбөргүй хийж үйлчилсэн байна.			100	100	
		1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх олон төрөлт уралдаан, тэмцээн зохион байгуулна.	БТСХ, НХХ	Зохион байгуулагдсан тэмцээн, хамрагдсан хүний тоо	100%		
4	1.1.4 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна.	Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг үндэсний бөх, самба бөх, жүдо бөх, сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, шатар, зуун буудалт даам, Чөлөөт бөх, гимнастик, цэцэрлэгийн хүүхдүүдийн уран сайхны гимнастик, хөл бөмбөг, хөнгөн атлетик гэсэн 20 төрлөөр зохион байгуулж 192 байгууллагын 4847 тамирчдыг хамрууллаа. Дүүргийн өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багш ажилтан албан хаагчдын дунд спортын 8 төрөлт тэмцээн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 4 тэмцээн, ахмадын 6 төрөлт тэмцээн, залуучуудын 7 төрөлт тэмцээн. Спортлог гэр бүл шалгаруулах болзолт уралдаан, Үндэсний спортын VI их наадмын Ширээний шагайн, шагайн харваан тэмцээн, Чингэлтэй фестиваль ажил танилцуулах арга хэмжээ нийт 98 төрлийн тэмцээн зохион байгуулж 3548 байгууллагын 61258 тамирчин хамрагдлаа. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафон			100	100	

		2018 олон улсын гүйлтэд нэгдэцгээ” Цом аялуулах аяныг 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 12-ны өдрүүдэд Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хороод дэргэдэх хэлтэс албад, хороод болон дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, аж ахуйн нэгж байгууллагуудаар 5 ширхэг цом аялуулж нийт 92 байгууллагаар аялсан бөгөөд 5450 иргэдийг шивэлтэд бүртгүүлж 2419 иргэдийг баталгаажуулан хамрууллаа. Чингэлтэй дүүргийн өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулагдаж буй ИРГЭД БОЛОН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ХӨДӨЛГӨӨНИЙ ХОМСДОЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ “ ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨНИЙ СУРГАЛТАД ” 99 байгууллагын нийт 675 албан хаагч, багш, ажилчдад хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх арга зүйн зөвлөгөө өгч, сургалт явууллаа. Монгол улсын ерөнхийлөгчийн 53-р зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчид болон сургуулийн сурагчдаас 88 байгууллагын 19540 иргэдийг сорилд хамруулж холбогдох сайтад шивж орууллаа.					
5	1.1.5 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулан, Залуучуудын шигшээ багийг хөгжүүлнэ.	1. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулж уралдаан тэмцээнд оролцох нөхцөл бололцоогоор хангана.	БТСХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг тамирчид жилийн эцсийн байдлаар 89 удаагийн уралдаан тэмцээнд оролцож нэрэмжит тэмцээнээс алтан медаль 36, мөнгөн медаль 46, хүрэл медаль 51, хотын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 37, мөнгөн медаль 24, хүрэл медаль 31, улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 37, мөнгөн медаль 45, хүрэл медаль 45, олон улсын тэмцээнээс алтан медаль 22, мөнгөн медаль 26, хүрэл медаль 26, Тивийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 8, мөнгөн медаль 2, хүрэл медаль 1, Олимпын их наадмаас 1 мөнгөн медаль хүртэн нийт 434 багц медаль хүртсэн амжилт үзүүлээд байна.				100	100
		2. Залуучуудын шигшээ багийг байгуулж, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулна.	БТСХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Дүүргийн залуучуудын анхан шат, бүсийн аварга, дүүргийн аварга шалгаруулах				70	70

		тэмцээнүүдийг 7 төрлөөр зохион байгуулахаар хуваарь батлагдан, анхан шатны тэмцээн, бүсийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж дууссан.					
6	1.1.6 Дүүрэгт баригдаж буй 1000 хүний суудалтай спорт цогцолбор, 61 дүгээр сургуулийн спорт заалны ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.	1. Дүүрэгт баригдаж буй 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	БТСХ, НХХ	Барилгын ажлын явц хувиар	70%		
		Дүүргийн усан бассейн мөсөн гулгуурын талбай бүхий 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгын техникийн нөхцөлүүдийг шинэчлэн гаргуулсан ба 2018 онд 1 тэрбум төгрөг улсын төсөвт суусан. Барилга угсралтын ажил А, Б, В Блок дүүргэлтийн ажил 90% дотор, ханын өрлөгийн ажил 85%, шаврын ажил 75%, цонх бүрэн суугдаад байна. Мөн цахилгааны газардуулагч хийгдсэн. Цогцолбор Б Блок Дээврийн 20 см зузаантай сэндвич хавтан 100% хийгдсэн. Б блокийн гадна фасад 75% хийгдэж байна.				100	100
		2. Дүүргийн 61 дүгээр сургуулийн спорт заалны барилгын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	БХ, НХХ	Барилгын ажлын явц хувиар	100%		
		БСШУСЯ, Барилгын хөгжлийн төв, дүүрэг, сургууль, зургийн зохиогч, гүйцэтгэгч компанийн төлөөллийг оролцуулан өргөтгөсөн хурлыг 2 удаа зохион байгуулж гүйцэтгэгч компанид чанаргүй хийсэн ажлыг дахин засварлах хугацаатай үүрэг даалгавар өгсөн бөгөөд БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон Барилга хөгжлийн төвөөс холбогдох албаны хүмүүсийн бүрэлдэхүүнтэй ажлыг хэсэг дахин ажиллаж дараагийн шатны арга хэмжээг буюу гэрээг цуцлах, шаардлага хангахгүй ажлыг дахин гүйцэтгүүлэх, шаардлага биелүүлээгүй тохиолдолд шүүхэд хандахаар болсон хэдий ч дахин хуучин гүйцэтгэгч “Байт мүүн лайт” ХХК-аар гүйцэтгүүлэхээр боллоо.				40	40
1.2 БОЛОВСРОЛ, СОЁЛ							
7	1.2.1 Шинээр сургууль, цэцэрлэг барих, өргөтгөх замаар цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх “Жаргалтай үрс” төслийг хэрэгжүүлнэ.	1. 11 дүгээр хорооны цэцэрлэгийн барилга, 19 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна.	БХ, НХХ	Барилгын ажлын явц хувиар	70%		
		11 дүгээр хорооны 175 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг “ Big Mongolia ” ХХК гүйцэтгэж дуусган байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисс ажиллаад байгаа бол 19 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг “ Грийн Ресурс ” ХХК компани гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгснөөр 3-р хорооны 250 гаруй хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших нөхцөл бүрдсэн. Мөн 11 дүгээр хороонд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 175 хүүхдийн хүчин				100	100

	чадалтай цэцэрлэгийн барилга барихаар 6 нэгж талбарын газар бүрэн чөлөөлсөн бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Ноён Трейд” ХХК шалгараад байна.				
	2. Шаардлагатай сургууль, цэцэрлэгүүдэд өргөтгөл барих, буулган шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	БХ, НХХ	Барилгын ажлын явц, хувиар	30%	
	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4, 33, 43 дугаар цэцэрлэгийг буулган шинэчлэх, 5, 23, 24, 50 дугаар сургууль, 74, 103 дугаар цэцэрлэгүүдэд өргөтгөлийн барилга барихаар батлагдсан бөгөөд 4 дүгээр цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг “Олон тоосго” ХХК, 33 дугаар цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг “Ус орчин” ХХК тус тус гүйцэтгэж суурийн ажил хийгдэж байгаа бол 43 дугаар цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг “Өсөх урам” ХХК гүйцэтгэж 2 дугаар давхрын краказ цутгалтын ажил хийгдэж байна. Мөн 74 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр “Грин ресурс” ХХК, 103 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр “Глобал рост” ХХК тус тус шалгаран суурийн болон 1 давхрын краказ цутгалтын ажил хийгдлээ. 23 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг “Грин ресурс” ХХК гүйцэтгэж суурийн ажлыг хийгээд байгаа бол 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг “Голомт констракшн” ХХК, 24 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг “Грейт маннинг” ХХК тус тус гүйцэтгэхээр болоод байгаа бол 50 дугаар сургуулиудын өргөтгөлийн барилгын тендер тус тус зарлагдсан байна. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 18 дугаар цэцэрлэгийг буулган шинэчлэх ажил бүрэн дуусаж ашиглалтад орууллаа. Тус цэцэрлэгт одоогоор 356 хүүхэд сурч хөгжиж байна.				100
	3. Шаардлагатай цэцэрлэгүүдэд нэмэлт бүлгийн байр барина, 155 дугаар цэцэрлэгийн нэмэлт бүлгийн байрыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлана.	БХ, НХХ	Барилгын ажлын явц, хувиар	30%	
	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 43 дугаар цэцэрлэгийн барилгыг буулган шинэчлэх болсонтой холбогдуулан тус цэцэрлэгт дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан нэмэлт бүлгийн байрыг 174 дүгээр цэцэрлэгт шилжүүлэн барьснаар 17 дугаар хорооны 70 гаруй хүүхэд цэцэрлэгт хамрагдах боломжийг бүрдүүллээ. 155 дугаар цэцэрлэгийн нэмэлт бүлгийн байрыг хүүхдийн цэцэрлэгийн				70

		зориулалтаар засварлах зураг, төсвийн ажлыг гүйцэтгээд байна. Одоогоор төсөв шийдвэрлэгдээгүй байна.				
		4. Нэн шаардлагатай хороодод шинээр бага сургууль барих ажлыг эхлүүлнэ.	БХ, НХХ	Барилгын ажлын явц, хувиар	30%	
		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12, 14 дүгээр хороонд баригдах бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын газрыг бүрэн чөлөөлөн нийслэлийн Засаг даргын 2018 оны А/593 дугаар захирамжаар Нийслэлийн Боловсролын газарт эзэмшүүлсэн бөгөөд барилга угсралтын ажлын тендерийн үнэлгээний ажил хийгдэж байна. 12 дугаар хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолборт 8000 кв.м, 14 дүгээр хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолборт 9000 кв.м газар олгогдсон байна. 12 дугаар хорооны 180 хүүхдийн суудалтай бага сургууль, 120 хүүхдийн ортой цэцэрлэгийн цогцолборын барилга угсралтын ажлыг "Хан-Аттрибут" ХХК, 14 дүгээр хорооны сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга угсралтын "Адамант" ХХК тус тус гүйцэтгэхээр ажлыг эхлүүлээд байна. Мөн Японы засгийн буцалтгүй тусламжаар 7 дугаар хороонд дэлхийн жишигт нийцсэн ерөнхий боловсролын сургууль байгуулахаар суурийн ажлыг эхлүүлээд байна. Тус ажлыг "МУХА" ХХК гүйцэтгэж байна.			100	100
		1. Багш нэг бүрийн заах арга зүй, ур чадварыг хөгжүүлж, сургалтын сайн технологи, хүүхэд нэг бүрийг хөгжүүлж буй сайн туршлагаудыг нэвтрүүлнэ.	БХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
8	1.2.2 Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого чиглэлийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх "Чингэлтэйн боловсрол" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багш нарын 14 багийг байгуулан ахлагч нараар нь сургуулийн захирлууд ажиллаж байгаа ба дүүргийн Засаг дарга бүх мэргэжлийн багуудыг хүлээн авч уулзсан. Тус мэргэжлийн баг бүхэн багш нарынхаа ур чадвар, заах арга зүйг дээшлүүлэх, дүүргийн нэгдсэн сургалтын хөтөлбөртэй болох, сурагчдынхаа хөгжилд онцгой анхаарах зэрэг олон ажлыг төлөвлөн хийж хэрэгжүүлж байна. Мэргэжлийн багийг байгуулан ажилласнаар хувь багшийг үнэлэхээс илүү багийн үйл ажиллагааг дэмжсэн ажил болж байна. Дүүргийн цэцэрлэгүүд хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор "Цэгээр наадъя" төсөлт ажлыг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд "СӨБ-ын шинэчлэл" ТББ-ын зөвлөх багш нар төсөлд хамрагддаг цэцэрлэгийн багш нарт зөвлөн тусалж, явцын үнэлгээ хийж нэгж байгууллага дээр ажиллаж байна. Төрийн өмчийн 29 цэцэрлэгийн 30 арга зүйч нар "СӨБ-ын байгууллагын өөрийн үнэлгээ-судалгааны арга зүй" сэдэвт сургалтад хамрагдлаа. Сургалтын менежерүүдийн			100	100

	<p>ажлын төлөвлөлт хийх, манлайлах чадварыг нэмэгдүүлэх, багш, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх ажлыг чиглүүлэн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, сургалтын менежерүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “ХАМТДАА ХӨГЖБЕ” уралдаан, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Уралдаанд бага анги хариуцсан 10 сургалтын менежер, дунд анги хариуцсан 6 сургалтын менежер нийт 16 сургалтын менежер оролцлоо. Чингэлтэй дүүргийн цэцэрлэгийн удирдлага, багш нарыг ажлын байранд нь хөгжүүлэх, шаардлагатай зөвлөгөө дэмжлэгийг үзүүлэх, харилцан суралцаж, хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор боловсролын хэлтсийн мэргэжилтэн, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нараас бүрдсэн 30 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөн туслах багийг цэцэрлэгүүдэд ажиллууллаа. Тус баг 6 чиглэлээр 25 цэцэрлэгийн 147 эрхлэгч, арга зүйч, багш нарыг хамруулан зөвлөн туслах үйлчилгээг цэцэрлэг бүр дээр нь очиж үзүүллээ. НБГ-аас зохион байгуулсан “Гэрийн нөхцөлд бага насны хүүхдийг хөгжүүлэх тоглоомын арга зүй” уралдаанд Чингэлтэй дүүргийн цэцэрлэгүүдээс 5, 102, 222 дугаар цэцэрлэгийн тоглоом шалгарч технологийн санд бүртгэгдсэн. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй цэцэрлэгт хамрагдах боломжгүй байгаа 3-5 насны хүүхдийн эцэг эхэд зориулсан “Бага насны хүүхдийг хөгжүүлэх зайны сургалтын багц боловсруулах” төслийн хүрээнд энэхүү уралдааныг зохион байгуулсан. Дүүргийн цэцэрлэгүүд хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор "Цэгээр наадъя" төсөлт ажлыг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд "СӨБ-ын шинэчлэл" ТББ-ын зөвлөх багш нар төсөлд хамрагддаг цэцэрлэгийн багш нарт зөвлөн тусалж, явцын үнэлгээ хийж нэгж байгууллага дээр ажиллаж байна. Төрийн өмчийн 29 цэцэрлэгийн 30 арга зүйч нар "СӨБ-ын байгууллагын өөрийн үнэлгээ судалгааны арга зүй" сэдэвт сургалтад хамрагдлаа. Дүүргийн ИТХТэргүүлэгчдийн 2016 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх “Сайн хичээл, хүүхэд хөгжүүлэх сайн үйл ажиллагаа”-ны чанар, хүртээмж, хүүхэд нэг бүрийн Сурлага-Хөгжил-Төлөвшилтийн ахиц, амжилтаар индексийн урамшуулал олгох ажлын бүсийн шатны шалгаруулалтыг зохион байгуулаад байна. Суралцагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх, математикийн сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэн, багш нарын хамтын ажиллагааг дэмжих”, сургалтын үйл ажиллагаанд эцэг эх, олон нийт, төр, төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах зорилгоор “ОЮУНЛАГ ЧИНГЭЛТЭЙЧҮҮД” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус төслийн хүрээнд Олонлог төв сургуультай хамтран математикийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг 3 шатлалтай зохион байгуулж нийт багш нараа хамруулаад байна. 2017-2018 оны хичээлийн жилд 1-3</p>		
--	--	--	--

		<p>дахь жилдээ ажиллаж байгаа “Хайлааст” ОНХХ-т хамрагддаг 17, 49, 72, 37, 139, 140, 117 дугаар сургуулийн багш нарын дунд 4 модуль сургалтыг амжилттай зохион байгууллаа. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сайн хичээл, хүүхэд хөгжүүлэх сайн үйл ажиллагаа”-ны чанар, хүртээмж, хүүхэд нэг бүрийн Сурлага-Хөгжил-Төлөвшилтийн ахиц, амжилтаар индексийн мөнгөн урамшуулалд 110 багш оролцохоор материал ирүүлснээс 2 дугаар шатанд 88 багшийг шалгаруулан урамшуулал олгохоор болоод байна.</p>				
	<p>2. Хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжин “Өв тэгш-Оюунлаг-Бүтээгч Монгол хүүхэд” төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа зохион байгуулна.</p>	<p>БХ, НХХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100%</p>		
		<p>“Өв тэгш-Оюунлаг-Бүтээгч Монгол хүүхэд” ажлын хүрээнд математикийн сургалтын чанарыг сайжруулахаар “Ирээдүйн эзэн-Оюунлаг Чингэлтэйчүүд” математикийн 200 бодлого бодох уралдааныг 6-11 дүгээр сурагчдын дунд зарлан 3-р шатыг явуулаад байна. 12 дугаар ангийн сурагчдаас элсэлтийн ерөнхий шалгалтаа амжилттай өгөх бэлтгэл ажлыг хангах үүднээс мэргэжлийн хичээлээр СОРИЛГО шалгалтыг 3 удаа зохион байгуулсан. Мөн тус төслийн хүрээнд Олонлог төв сургуультай хамтран “Олонлог эгзэ” сургуулийг түшиглэн оюуны өндөр чадамжтай 80 сурагчдыг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудаас сонгон шалгаруулж мэдээлэл, технологийн чиглэлээр гүнзгийрүүлэн бэлтгэж байна.</p> <p>Эх орончдын өдрийг угтан ахлах ангийн сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан, дунд ахлах ангийн сурагчдын дунд Монгол бичгийн уран болон бийрэн бичлэгийн уралдааныг зарлан дүгнэсэн ба 70 гаруй уран бичлэгийн бүтээлээс 1-р байр 1, 2-р байр 2, 3-р байр 3, тусгай байр 10-ыг шалгаруулж урамшуулсан. Эсээ бичлэгийн уралдаанд ахлах ангийн 3850 орчим сурагч оролцож шилдгүүдээ шалгаруулсан. Цэрэг спортын “Дөл тэмцээнийг төрийн өмчийн 12 сургуулийн дунд 2 үе шаттайгаар зохион байгуулж, эхний шатанд сургуулийн түвшинд 3000 гаруй сурагч оролцож, шалгарсан 300 гаруй сурагч 2-р шатанд өрсөлдөж шилдгүүдээ тодруулан эхний 2 байранд орсон 50 сурагчийг ОХУ-ын Улан-Удэ хотод аялах эрхээр шагнасан. Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн бүх сурагч уншсан байх номын жагсаалтыг гаргаж анги тус бүрээр төрөл бүрийн уралдаан тэмцээн, олон талт арга хэмжээг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Бага насны хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөн зөв соёлтой оролцох далыг бага наснаас эзэмшүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг “Ногоон</p>			<p>100</p>	<p>100</p>

		<p>гэрэл цагаан шугам-2018” тэмцээний дүүргийн түвшинд 25 цэцэрлэгийн 300 өсвөрийн зохицуулагч нар оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорьсноос 33 дугаар цэцэрлэг тэргүүн байр, удаах байруудад 155, 70 дугаар цэцэрлэг шалгарлаа. Нийслэлийн тэмцээнд 33-р цэцэрлэг амжилттай оролцож нийслэлийн хошой аварга баг боллоо. “Сургуулийн өмнөх боловсролын шинэчлэл” ТББ-тай хамтран “Цэгээр наадъя” төсөлт ажлыг цэцэрлэгүүдэд 3 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Уг төсөлт ажил нь цэгээр холбон зураг зурах, зургаараа дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлдэг давуу талтай. Энэхүү төслийн хүрээнд 1300 гаруй хүүхдийн хөгжилд анхааран ажилласан байна. 2017-2018 оны хичээлийн жилд цэцэрлэгүүдийн дунд “Бид бүгдээрээ дуучин” төсөлт ажлыг хэрэгжүүлж дүгнэх ажлыг 2018.05.08-14-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус төсөлт ажлын 1-р шатанд 29 цэцэрлэгийн 7890 хүүхэд хамрагдсан бол дүүргийн түвшний буюу 2-р шатанд 29 цэцэрлэгийн 29 найрал дууны хамтлагийн 1015 хүүхэд хамрагдаж шилдгүүдээ тодрууллаа.</p> <p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар БНСУ-ын Инчон хотын Ёнсу дүүрэгтэй найрсаг хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Сурагч солилцооны хөтөлбөр”-өөр сурлагаараа бусдыгаа манлайлсан 19 сурагч, 3 багш 8 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд Ёнсү дүүрэгтэй танилцсан юм. Сурагчдыг Ёнсү дүүрэгт байх хугацаанд тус дүүргийн Засаг дарга Го Нам Сэок хүлээн авч уулзан, дүүргийнхээ талаар болон боловсролын салбарт баримталж буй бодлогыг танилцуулсан байна. Мөн Солонгос сурагчдын урлагийн тоглолтыг үзэж, сонирхон, сургалтын орчинтой танилцуулсан бол Ёнсү дүүргийн 15 сурагч, 3 багш Монгол Улсад айлчлан Монголын байгаль, уламжлалт ёс заншил, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаатай танилцан авьяаслаг хүүхдүүдийн тоглолтыг үзэж сонирхсон.</p>					
		<p>3. Сургалтын материаллаг бааз, орчин нөхцөлийг сайжруулах, анги танхим кабинетийг шинээр байгуулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</p>	БХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		<p>Дүүргийн төсвийн 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулиудад 3d принтер бүхий “РОБОТИК” төслийг хэрэгжүүлэх ажлыг “Эм Ти Эм Жи” ХХК гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулаад байна. Тус төслийн хүрээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын 12 сургуульд 3d принтер болон түүнтэй холбогдох эд материалаар хангахаар ажиллаж байна. Мөн дүүргийн төсвийн 50,0 сая, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 19,8 сая төгрөгийн хөрөнгө</p>	100	100			

		<p>оруулалтаар 102, 108, 74 дүгээр цэцэрлэгүүдэд шаардлагатай гал тогооны тоног төхөөрөмж олгох ажлыг гүйцэтгээд байна. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан болон дүүргийн төсвийн 220,0 сая хөрөнгө оруулалтаар 23 дугаар сургуульд баригдах номын сангийн өргөтгөлийн барилга угсралтын ажил, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 57 дугаар сургуулийн спорт заалны засварын ажлын дээврийн хэсэгчилсэн засвар, цонх, тааз, шалны цутгалтын ажил хийгдээд байна. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 60,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 24 дүгээр сургуулийн спорт заалны засварын ажлыг “Энх Төгс Тэмүүлэн” ХХК гүйцэтгэж ажлаа бүрэн дуусгасан.</p>					
		<p>4. Дүүргийн нутаг дэвсгэрт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна, дотно орчныг камерын хяналттай бүс болгоно.</p>	<p>БХ, НХХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100%</p>		
		<p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчныг сайжруулах камержуулах, замын хөдөлгөөний аюулгүй үйл ажиллагааг хангах үүднээс дүүргийн Замын цагдаагийн хэлтэс, Цагдаагийн 1, 2-р хэлтэс, мэргэжлийн хяналтын хэлтсийн хамтарсан ажлын хэсэг бүх сургууль, цэцэрлэгийн гадна болон дотор орчинтой танилцаж дүгнэлт гарган дүүргийн ИТХ болон бусад дээд шатны байгууллагуудад уламжилсан. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн үе шаттайгаар асуудлыг шийдвэрлэхээр болоод байна. 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн дотор тал, анги танхимд 323 камер байгаагаас 271 нь бүрэн ажиллагаатай, гадна талд 82 камер байгаагаас 50 нь бүрэн ажиллаж байна. Цаашид сургуулийн дотор анги танхимд 323, гадна талд 87 камер, салаалагч болон хадгалах төхөөрөмж 115 шаардлагатай байна. 112 дугаар сургуулиас бусад сургуулиуд тодорхой хэмжээгээр камержсан боловч хүчин чадал харилцан адилгүй, зарим сургуулийн камерын бичлэг хадгалах хугацаа богино байна.</p>			<p>70</p>	<p>70</p>	
		<p>5. Ерөнхий боловсролын сургуульд жишиг эмнэлгийн тусламж үйлчилгээний кабинет байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	<p>БХ, НХХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>30%</p>		
		<p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 24, 37, 39, 72, 49 дүгээр сургуулиудад жишиг эмчийн өргөөг байгуулж, тавилга, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг “Аркосис” ХХК, “Мөнхөд трэйд” ХХК тус тус гүйцэтгэн 29 ширхэг тавилга, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.</p>			<p>100</p>	<p>100</p>	

		6. Сургалтын үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг бүхий л талаар дэмжин ажиллана.	БХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Эцэг эхийн үйл ажиллагааг бүх талаар дэмжих “Чингэлтэй-444” санаачилгын 3 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд эцэг эхчүүдэд төрөл бүрийн сургалт, өдөрлөг зохион байгуулж байгууллагынхаа эрүүл ахуй, хоол хүнс, сургалтын орчин, сургалтын чанар, үр дүнг танилцуулах, мөн спорт урлаг, соёлын төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн байна. Мөн дүүргийн “Боловсролын салбарын эцэг эхийн нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд 5 төрөлт спортын арга хэмжээг 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Мөн 2017-2018 оны хичээлийн жилд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, эрдмийн баярыг 5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 15-ны өдрүүдэд сургууль, цэцэрлэг тус бүр дээр амжилттай зохион байгуулагдлаа.				100	100
		7. Албан бус насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	БХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		2017-2018 оны хичээлийн жилд тус төвийн 7 бүлэгт 126 сурагч бага, суурь бүрэн дунд боловсрол эзэмшихээр 3 сургууль болон албан бус насан туршийн боловсролын төвийн байранд хичээллэж байгаа бөгөөд энэ хичээлийн жилд 12-р ангийг 25 сурагч, 9 дүгээр ангийг 26 сурагч төгсөж дараагийн шатны сургуульд хамрагдах боломжтой боллоо. Тус сургалтын төв нь амьдрах ухаан, гэр бүлийн, иргэний, гоо зүй-мэдрэмжийн боловсрол олгох хөтөлбөрөөр хичээллэж байна. Мөн тус төвийн багш нар нь дүүргийнхээ иргэдэд компьютер, англи хэл, гар урлалын дугуйланг хичээллүүлж ний 100 гаруй иргэдийг хамруулсан байна. “Дэлхийн Зөн” ОУБ-ын “Чингэлтэй”, “Хайлааст” ОНХХ-тэй хамтран өөрийн номын сандаа хандиваар ном авч сургалтдаа хэрэглэж байна. 2018 оны “Өрхийн хөгжлийн дэмжих жил” болгосонтой холбогдуулан иргэдийн боловсролын түвшин дээшлүүлэх чиглэлд дүүргийн хороод болон ЕБС-иудтай хамтран ажиллаж амьдрах ухааны сургалтад иргэдийг хамруулан зохион байгуулж байна. 2018-2019 оны хичээлийн жилд тус төвийн 7 бүлэгт 131 сурагч бага, суурь бүрэн дунд боловсрол эзэмшихээр 3 сургууль болон төвийн байранд хичээллэж байна.				70	70
9	1.2.3 Орон нутгийн	1. Дүүргийн Соёлын төвийн үйл	Соёлын	Үйл	100%		

хэрэгцээ шаардлагатай уялдуулан дүүргийн нутаг дэвсгэрт Соёлын ордон байгуулж, соёлын төвийн үйл ажиллагааг дэмжинэ.	ажиллагааг дэмжин, иргэдэд соёлын олон талт үйлчилгээг үзүүлнэ.	төв, НХХ	ажиллагааны хэрэгжилт, хувиар		
	Дүүргийн соёлын төвд хүүхэд залуусын авьяас билгийг нээн хөгжүүлэх, иргэдэд соёл урлагаар үйлчлэх, нийтийн соёлыг түгээх, үндэсний урлаг, өв соёлоо сурталчлан таниулах зорилгоор дууны дугуйланд 11, төгөлдөр хуурын дугуйланд 5, морин хуурын дугуйланд 47 нийт 63 хүүхдийг хичээллүүлж байна. Соёлын төвийн дэргэдэх ахмадын “Дөрвөн цаг” хамтлагийн уран бүтээлчдийн ардын болон харилцаа дууны тоглолт Улаанбаатар чуулгын концертын их танхимд болж, тоглолтыг дүүргийн 19 хороодын ахмадууд болон иргэд үзэж сонирхлоо. Мөн “Ар жанчивлан”, “Энх саран” зэрэг амралтын газрууд, Төв аймгийн Лүн, Баянчандмань зэрэг сумдад уран бүтээлийн тайлан тоглолтоо хүргэж ажилласан ардын урлагийн өв санг сурталчлан ажиллаа. Бид сайн сайханд дагуулна уриан дор зохион байгуулагдсан “Чингэлтэй фестиваль”-ийн иргэн тайзан дээр уран бүтээлчдийн тоглолт, 1-19 дүгээр хорооны иргэдийн урлагийн тоглолтыг зохион байгуулсан. “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМ”-ыг улсын хэмжээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас зохион байгуулсан наадамд амжилттай оролцож МУСТА цол тэмдгээр 1, Тэргүүний Ардын Авьяастан тэмдгээр 1, БСШУСЯ-ны Хүндэт Жуух Бичгээр 1 оролцогч тус тус шагнууллаа.			100	100
	2. Үндэсний соёл урлагийг нийтэд сурталчлан таниулах, соёлын салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Соёлын төв, ХБТХАХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт харилцан ашигтай хамтран ажиллаж, иргэдэд эрүүл мэнд, боловсрол, соёлын хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хороодын Засаг даргын Ажлын алба, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын төлөөлөл Хэнтий аймгийн Баян-Овоо суманд “Түншлэл” үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, тус сумын соёлын төвтэй хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Хамтын ажиллагааны гэрээнд сумын сурагчдад морин хуур, хөөмийн сургалтыг явуулах, багш нарын мэргэжил боловсролоо дээшлүүлэх, харилцан ашигтай урлаг, уран сайхны олон талт арга хэмжээг зохион байгуулах зэрэг ажлууд зохион байгуулахаар төлөвлөн тусгалаа. Түүнчлэн Чингэлтэй дүүргийн Соёлын төв, Хэнтий аймгийн “Хан Хэнтий”			100	100	

		<p>чуулга, Баян-Овоо сумын Соёлын төвийн уран бүтээлчдийн хамтарсан урлагийн тоглолтыг зохион байгууллаа. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Саха Улсын Хангаласски дүүрэгтэй байгуулсан санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд найрсаг хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, харилцан туршлага судлах, үндэсний өв соёл, ёс заншлаа сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Покровск хотын 1 дүгээр дунд сургууль, 61 дүгээр дунд сургуулийн хамтарсан Монгол ардын дуу, бүжгийн тоглолтыг Покровск хотноо зохион байгууллаа. Чингэлтэй дүүргийн соёлын төвийн дэргэдэх “Дөмөн” хамтлаг БНХАУ-ын Сияан хотод зохион байгуулагдсан “Торгоны зам”-ын дагуух улс орнуудын телевизүүдийн форумд оролцож 5 хоногийн турш үндэсний урлаг, уламжлалт соёлоо олон улсад сурталчлан таниулсан. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт харилцан ашигтай хамтран ажиллаж, иргэдэд эрүүл мэнд, боловсрол, соёлын хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор болон “ТҮНШЛЭЛ-2018” хамтын ажиллагааны хүрээнд Дүүргийн Соёлын Төвийн хамт олон Хэнтий аймгийн Баян-Овоо суманд зочилж тус сумын Соёлын төвийн уран бүтээлчидтэй хамтарсан тоглолтыг Баян-Овоо сумын иргэд оршин суугчдад өргөн барьсан.</p>					
10	<p>1.2.4 Иргэдийн хөгжлийг бүх талаар дэмжсэн "Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>1. "Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>НХХ, СТ, ХНӨ, БХ</p>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>	<p>100</p>	<p>100</p>
		<p>"Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт 23 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Соёлын төв, Хүүхдийн номын өргөө, Боловсролын хэлтэс хамтран сурагчдын ном унших хүсэл сонирхлыг өрнүүлэх, оюун сэтгэхүйгээ хөгжүүлэх, танин мэдэх чадвар, авьяас билгийг нээн хөгжүүлэх зорилгоор "Миний ном-Миний хобби" уралдааныг 2 дахь жилдээ богино өгүүллэг хэлбэрээр ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Тус уралдааны 1-р шатны шалгаруулалтыг уянгын, хошин, адал явдалт гэх мэт сэдвүүдээр эх орноороо бахархсан, өв соёл, ёс заншлаа дээдэлсэн, хүүхэд багачуудын дунд мартагдаж буй ахуйн соёлыг сэргээсэн, эцэг эх, ахмад үеэ хүндэлсэн, орчин цагт хүүхэд багачуудад аюул заналхийлэл учруулж буй олон талт асуудлуудыг тусгасан 40 гаруй бүтээлээс шүүгчид хэлэлцэн шилдэг 8 зохиолыг 2 дугаар шатанд шалгаруулаад байна. Тус уралдаанд 11 сургуулийн 53 сурагчид хамрагдлаа. Энэ удаагийн тэмцээний шилдэг найман бүтээлийг мэргэжлийн жүжигчний ангийн оюутан сурагчид уншиж, толилуулсан нь бүтээлийг амилуулж, үзэгчид төдийгүй зохиолч сурагчдын сэтгэлд хүргэж чадсанаараа онцлогтой</p>					

	<p>байлаа. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийнхээ 3200 эхчүүд, эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлэн “Тандаа хайртай шүү, ээжээ” урлагийн тоглолтыг өргөн барьж, “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн нээлтийг зохион байгууллаа. Чингэлтэй дүүргийн 138-р бага сургуульд “Номтой богц” явуулын номын сангийн үйлчилгээг хүргэлээ. Тус сургуулийн сурагчдад зориулан бага ангийн хүүхдүүдийн сонирхдог үлгэр, уран зохиол, танин мэдэхүйн 50 ширхэг номоор үйлчиллээ. Хүүхдийн номын өргөөнд зохион байгуулдаг “Үлгэрийн цаг”, “Кино цаг”, “Зохиолч уншигчдын уулзалт”, “Би хэн бэ?” ярилцлагын цаг, “Жаргалан” эрүүл мэндийн сургалт зөвлөгөөний цаг, “Сайн жаал” сургалтын цаг, “Усаа хайрлан гамная”, “Мод тарих ямар ашиг тустай вэ?”, “Байгаль орчноо хайрлан хамгаалъя” зэрэг үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 1500 гаруй хүүхэд багачууд хамрагдсан байна. Хүүхдийн номын өргөөгөөр 2018 онд нийт 8000 гаруй хүүхэд багачууд үйлчлүүлснээс 859 сурагч уншигчийн карт шинээр нээлгүүлсэн байна. “Бидний бахархал” хүүхдийн ардын урлагийн наадмыг 12 дахь жилдээ зохион байгууллаа. Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар, Нийслэлийн Соёл Урлагийн Газар, Улсын Драммын Эрдмийн Театр, Соёл, урлагийн их сургууль, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтран зохион байгуулсан театрын ирээдүйн үзэгчдийг бэлтгэх, үзэгчийн соёлыг төлөвшүүлэх, соёл, урлагийн боловсрол олгох зорилгоор зарласан “БИДНИЙ ТЕАТР” жүжгийн уралдаанд Ф.Шиллерийн зохиол “Хар санаа - Хайр сэтгэл” жүжгээр амжилттай оролцсон. Соёл Урлагийн Их сургуультай хамтран “Бид сайн сайханд дагуулна” уриан дор соёл урлагаар дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, амьдралын нийтлэг соёлыг төлөвшүүлэх, үндэсний ес, заншил, соёл урлаг, өвийг сурталчлан таниулах зорилгоор “ЧИНГЭЛТЭЙ ФЕСТИВАЛЬ” арга хэмжээг “Амар байна уу, та?” сэдвийн хүрээнд 5 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. “Чингэлтэй фестиваль”-ийн үйл ажиллагааны баярын жагсаалд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн шилдэг хүүхэд, багш, ажилтан, дүүргийн удирдлагууд, гадаад дотоодын зочид төлөөлөгчид, 1-19 дүгээр хорооны иргэд, төрийн албан хаагчид, өсвөрийн шигшээ багийн тамирчид, Соёл урлагийн их сургуулийн багш оюутан, Монгол нохой сонирхогчдын холбооны төлөөлөл нийт 6500 гаруй хүн оролцсон бол Тусгаар тогтнолын талбай, хүнсний нэгдүгээр дэлгүүрийн уулзвар, 5 дугаар сургууль, СУИС гэсэн 4 цэгт тайз засан иргэдийг соёл урлагийн үйлчилгээнд хамрууллаа. Дүүргийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ний өдрийн А/623 дугаар захирамжаар ОУ-ын Хүүхдийн баярын өдөр, Хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийг байгуулан ажиллалаа. Тус</p>		
--	---	--	--

		ажлын хүрээнд хороо бүрд Хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлж зорилтот бүлгийн 6284 хүүхдэд гарын бэлгийг гардуулсан. Мөн нэгдсэн баярыг 06 дугаар сарын 01-ний өдөр Тусгаар тогтнолын талбайд зохион байгууллаа. Үйл ажиллагааны үеэр дүүргийн сургууль, цэцэрлэгийн тэргүүний хүүхэд багачуудын болон соёлын төвийн дуу, бүжгийн дугуйлангийн хүүхдүүдийн урлагийн тоглолт, “Өнчин цагаан ботго” дуулалт бүжгийн жүжиг, “Лоолойгийн найзууд” урлагийн үзүүлбэрийг тус тус хүүхэд багачуудад сонирхууллаа.					
11	1.2.5 Залуучууд, өсвөр үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Хөгжлийн төв” байгуулж, олон талт үйл ажиллагаа явуулна.	1. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжин олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.	ГБХЗХХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	70	70
		Залуучуудын хөгжлийн төвийг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр дүүрэг бүрд байгуулсан бөгөөд залуучуудад амьдрах ухааны сургалт явуулах танхим, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө, компьютерын өрөө, номын сан, шатар даам тоглох танхим зэрэг залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжих боломжтой байхаар тохижуулагдаж, интернэт орчин, тоног төхөөрөмж, ном, гарын авлагаар иж бүрэн хангагдсан. Төвийн хөгжмийн сургалт, компьютерын сургалт болон бусад үйл ажиллагаанд гуравдугаар улирлын байдлаар нийт 850 гаруй иргэн үйлчлүүлж, хүүхэд, залуучууд, эцэг, эхчүүд рүү чиглэсэн 22 үйл ажиллагаагаар 5120 иргэнд сургалт сурталчилгаа, амьдрах ухааны сургалтыг зохион байгуулж, ганцаарчилсан сэтгэл зүйн үйлчилгээг 63 хүүхдэд, 67 насанд хүрэгчдэд, бүлгийн зөвлөгөөг 82 иргэнд үзүүлсэн байна. Мөн Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Хайлааст” ОНХХ, ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургуулиудтай хамтран Хүүхдийн эрх, хамгааллын талаарх хууль, Залуучуудын хөгжлийг хангах тухай хууль, сургууль орчин дахь хүүхэд хамгаалал, цахим орчин дахь гэмт хэрэг, архи, тамхи, мансууруулах бодис, хорт зуршил болон сэтгэл зүйн сэдвийн хүрээнд 3800 гаруй хүүхэд, залууст сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна. Мөн иргэд залуучуудад компьютерын анхан болон дунд шатны сургалтыг явуулж сургалтад анхан шатны 296 хүн, дунд шатанд 134 иргэд нийт 430 хүнд, дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвтэй хамтран 9, 10, 12-р хорооны зорилтод бүлгийн иргэдийн гадаад хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилготой англи хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулж 24 иргэн тус тус хамрууллаа. Мөн залуучуудын оролцоог дэмжиж соёл урлаг, спортоор дамжуулан залуучуудын хөгжлийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд дүүргийн ААН Байгууллагуудтай хамтран ажиллаж, “Оч”					

		ширээний теннисний клуб, даваа баасан ням гаригуудад 4000-2000 төгрөг "Од" фитнес клуб 7 хоног бүр 50%-ийн /70.000-35000 мянган төгрөг/ хөнгөлөлттэй үнээр залуучуудад үйлчилж, 1-19 дүгээр хорооны зорилтот бүлгийн 23 залууг хамрууллаа. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар"-аас санаачлан Нийслэлийн боловсролын газар, Юнител групп хамтран "ИРЭЭДҮЙН ЭЗЭД" мэргэжил сонголтын аяныг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж байна. Энэхүү аянд 03 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 5, 17, 23, 24, 37, 39, 49, 50, 57, 61, 72, 117 дугаар сургуулийн ахлах ангийн 2250 сурагчийг хамруулж, судалгаанд хамрууллаа. Дүүргийн 8,10,12,17,19 дүгээр хороон дээр залуучуудын бүлэг байгуулан залуучуудын хөгжлийг дэмжих хууль болон залуучуудын оролцоог хэрхэн хангаж тогтмол эрчимтэй үйл ажиллагаа зохион байгуулах тал дээр зөвлөгөө өгч ажиллаж байна. Залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл болон залуучууд тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор Дүүргийн Залуучуудын зөвлөл, 1-19 хороодын залуучуудын зөвлөлийн гишүүдийн дунд "Цэвэр агаар, эрүүл ирээдүй" арга хэмжээ зохион байгуулж нийт 46 залуучууд хамрагдаж Богд ууланд нэг өдрийн явган аялал хийв.					
1.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ							
	1.3.1 Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг дэмжин төсөл хөтөлбөрийн хүрээнд асаргаа төвийн ажлыг барилгын ажлыг эхлүүлнэ.	1. Ахмадын амралт сувиллын материаллаг баазыг бэхжүүлж, ахмадуудад үйлчлэх урлаг соёлын танхимтай болгоно.	АХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
12		Тус дүүргийн 7 дугаар хороонд 7, 8, 9, 10, 11 дүгээр хорооны иргэд үйлчлэх, 14 дүгээр хороонд 12, 13, 14, 15 дугаар хорооны иргэд үйлчлэх хүүхэд, залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заалны цогцолбор барих ажлыг "Тэргүүн чансаа" ХХК, "Баян могод" ХХК тус тус гүйцэтгэж суурийн ажлыг эхлүүлээд байгаа бол 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 16, 17, 18, 19 дүгээр хорооны иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заалны цогцолбор байгуулан бүрэн ашиглалтад оруулаад байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Ногоон булан" ахмадын амралт сувиллын газрыг шинэчлэн байгуулахаар зураг төсвийн ажлыг гүйцэтгэж, засварын ажлын тендерийг зарласан. Нийслэлийн төсвийн 50,0 төгрөгийн хөрөнгөөр дүүргийн 9 дүгээр хорооны хуучин өрхийн эмнэлгийн барилгыг "Ахмадын өргөө" болгон гадна фасад засвар, дотор			100	100	

		засварыг “Мекон” ХХК засварлаж дуусгасан.				
13	1.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.	1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, гарц, шат, хаалга, бие засах газрын стандартыг мөрдүүлэн ажиллана.	НХХ, ХХҮХ, ААНБ-ууд	Стандартын дагуу шинээр хийгдсэн зам, гарц хаалга, бие засах газрын тоогоор	50%	
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Жаргалтай амьдрал-жаргалтай үрс” төслийн хүрээнд дүүргийн 12 ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орц, гарц, ариун цэврийн өрөөг засварлахаар зураг төсвийн ажил хийгдсэн. Нийслэлийн төсвийн 60,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 17 дугаар сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гадна орц, гарц, үүдний хаалга, 1 давхрын 00, 3 давхарт хананы бариул зэргийг хийж гүйцэтгэсэн. Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Азийн сангийн хэрэгжүүлж байгаа Хотын Засаглалыг сайжруулах төслийн хүрээнд дүүргийн 16 хорооны цогцолбор байрны үүдний хэсэгт 18,0 сая төгрөгний төсөвтэй Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу шат бий болгох ажлыг “Мөлүү хээр” ХХК хийж дууссан. Гадна өнгөлгөөний ажил хүйтэнд хийгдэх боломжгүй тул ирэх хавар үргэлжлүүлнэ.			100	100
		2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжин олон талт үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	НХХ, ХХҮХ, ТББ-ууд	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд татан оролцуулах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт тэмцээнийг суугаа волейбол, шатар, ширээний теннис, нисдэг тавгийн төрлөөр зохион байгуулж, нийт 81 иргэн хамрагдан тэмцээний төрөл тус бүрээр шилдгүүдийг шалгарууллаа. Мөн тэдний сэтгэл санааг дэмжих зорилгоор “Нийгэмд үйлчилдэг” ТБ Байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх зэрэг 12 иргэнийг Өвөрхангай аймгийн Хархорин сумын “Эрдэнэзуу хийд”-тэй танилцуулах, бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамруулах ажлыг 2018 оны 05 дугаар сарын 25-27-ний өдрүүдэд зохион байгууллаа.			100	100
		3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн	НХХ,	Үйл	100%	

		<p>боловсролд тэгш хамран сургах, эрүүл мэнд халамжийн хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>	<p>ХХҮХ, ТББ-ууд</p>	<p>ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>			
		<p>Чингэлтэй дүүргийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд 217, цэцэрлэгт 41 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч хөгжиж байгаа бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн Төсвийн шууд захирагчтай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээнд Улсын Их Хурлын 2017 оны 46 дугаар тогтоол, “Чингэлтэйн боловсрол-2020” дүүргийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах чиглэлээр тойрог харгалзахгүйгээр суралцуулж хөгжүүлэх, тэдэнд зориулсан орчин бүрдүүлэх заалт тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн энэ онд дүүргийн төсвийн хөрөнгөөр “Жаргалтай үрс-Жаргалтай амьдрал” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах төслийг батлан хэрэгжүүлж ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын орчин бүрдүүлэх, түшиц сургууль, цэцэрлэг байгуулахаар болж сургуулийн орчин бүрдүүлэлтийн талаар зураг төсөл хийгдэж байна. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/198 дугаар захирамжаар байгуулагдсан дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй Хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 7 хоног бүрийн мягмар гарагт тогтмол хуралдуулж, хөгжлийн бэрхшээлтэй нийт 301 хүүхдийг байнгын асаргаа тогтоож, халамжийн үйлчилгээнд хамруулж, 19 хүүхдийг сургууль, цэцэрлэгт зуучилсан байна. Оросын Холбооны Улсын Өвөр байгалийн Улсын их сургууль, Тэгш хамруулах боловсролын бүсийн төв, Өвөр байгалийн хязгаарын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Нийгэм-Эрүүл мэндийн сэргээн заслын “Росток” төвтэй хамтран ажиллах түншлэлийн гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тархины саажилтын тулгуур хөдөлгөөний тогтолцооны эмгэгийн үед хөдөлгөөн байрлалын мэдрэхүйг засах хөдөлгөөн заслын шинэ технологи “Адели” эмчилгээний өмсгөл, “Атлант” хийт өмсгөл, морин заслын эмчилгээг Монгол Улсад нэвтрүүлэн, дүүргийн Эрүүл мэндийн төвийн сэргээн заслын мэргэжлийн эмч нарыг тус эмчилгээний арга зүйд сурган Адели-8ш, Атланта 10ш өмсгөлтэйгөөр сэргээн засах эмчилгээг эхлүүлээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагч, тэр дундаа ээжүүдийн стресс бухимдлыг тайлах, харилцаа, хандлагыг өөрчлөх, идэвхжүүлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бууруулах зорилготой “Зөв сэтгэл-Зөв хандлага” сэдэвт лекц, бясалгалыг “Эрдэнэ зуу хийд”-ийн хамба лам Х.Баасансүрэнтэй</p>			<p>100</p>	<p>100</p>	

		хамтран зохион байгууллаа. Лекц бясалгал 2018 оны 05 сарын 10, 11 өдрүүдэд зохион байгуулагдаж 1-19 дүгээр хорооны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч, хороодын нийгмийн ажилтнууд зэрэг 90 хүн хамрууллаа. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/198 дугаар захирамжаар байгуулагдсан дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй Хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 7 хоног бүрийн мягмар гарагт тогтмол хуралдуулж, хөгжлийн бэрхшээлтэй нийт 301 хүүхдийг байнгын асаргаа тогтоож, халамжийн үйлчилгээнд хамруулж, 19 хүүхдийг сургууль, цэцэрлэгт зуучилсан байна.					
14	1.3.3 Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, нийгмийн халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	1. Нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, ил тод хүргэнэ.	ХХҮХ, НХХ, ТББ-ууд	Үйлчилгээ авсан иргэдийн тоогоор	100%		
		Нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй, ил тод хүргэн ажиллаж, Нийгмийн халамжийн тэтгэвэрт-2399 хүнд 4.226.903.800 төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэмж-3237 хүнд 2.402.251.455 төгрөг, Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж- 2706 хүнд 1.708.255.030 төгрөг, Ахмад настны тусламж, хөнгөлөлт-15623 хүнд 2.153.846.679 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж- 6006 хүнд 840.692.418 төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 416 хүнд 140.687.740, Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй олгох тэтгэмж-4328 хүнд 756.974.750 төгрөг, Нийгмийн эмзэг бүлэгт Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд- 13465 хүнд 1.808.391.696 төгрөгийг үйлчилгээнд тус тус хамруулав. Алдар цолтой ахмад настанд төрөөс олгож буй мөнгөн тусламж-176 хүнд 373.844.000 төгрөг, Алдарт эхийн одонгийн тэтгэмж-8615 хүнд 1.172.160.000 төгрөг, Насны хишиг-7209 хүнд 1.115.560.000 төгрөг, Цалинтай ээж-9302 хүнд 4.510.878.000төгрөг, өрх толгойлсон эх, эцэг-179 хүнд 162.720.000 төгрөгийн үйлчилгээнд 111985 хүнд 7.339.487.200 төгрөгийг тус тус хамруулан ажиллалаа.				100	100
15	1.3.4 Хүн амын хөгжлийг дэмжсэн гэр бүлд зөвлөн туслах, зорилтот бүлэг рүү чиглэсэн халамж үйлчилгээг дэмжсэн төслүүдийг	1. Зорилтот бүлгийн өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч өрх болгох багц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	ХХҮХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр дүүргийн Засаг даргын 2018 оны А/158				70	70

хэрэгжүүлнэ.	<p>дугаар захирамжаар “Хүн амын хөгжлийн асуудлаарх Орон нутгийн салбар хороо”-г байгуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны оноог үндэслэн хөтөлбөрт хамруулах нийт 530 өрхийг сонгож, хороодын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, сонгогдсон 530 зорилтот өрхийн 240 иргэнийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад, 53 иргэнийг байнгын ажлын байранд, 31 иргэнийг нийтийг хамарсан ажилд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт-18 иргэн, амьдрах ухааны сургалт-52 иргэн, мэргэжил олгох сургалт-11 иргэн, гэр бүлийн боловсрол олгох сургалт-58 иргэн, сөрөг зан үйл хандлага өөрчлөх сургалт-59 иргэн, улсын бүртгэлийн үйлчилгээг -27 иргэнд тус тус үзүүлж, 3 өрхийг гэр оронтой болгосон.</p>					
	2. Хүн амын хөгжил, гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээний чиглэлээр төсөл хэрэгжүүлэх иргэн, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	НХХ, ГБХЗХХ	Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоор	2-3 ТББ-ыг дэмжинэ.		
	<p>Дэлхийн Зөн Монгол ОУ-ын байгууллагын “Чингэлтэй-ОНХХөтөлбөр”, “Хайлааст-ОНХХөтөлбөр”-үүдтэй хамтран зорилтот бүлгийн өрх, иргэдийг чадваржуулах, дэмжин туслах зорилготой “Гэрээр айлчлагч аргачлал” төслийг 7-19 дүгээр хороодын нийт 105 өрхийн 500 гаруй хүнийг хамруулан хэрэгжүүлж байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-г хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-н сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 1-19 хорооны 182 хэсгийн ахлагч 94,7 хувьтай хамрагдаж, гэрээр айлчлах аргачлал, судалгааны асуумжийг бөглөх аргачлалд суралцаж, гэрээр айлчлагчаар бэлтгэгдсэн. Дүүргийн хэмжээнд “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-н “Асуулгын хуудас”-г 1500 өрхөөс авч Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн. Судалгаанд хамрагдсан 1500 өрхөөс хүрч ажиллах шаардлагатай 270 өрхийг квотын дагуу зорилтот бүлгийн гэр бүлийн бүтэц, хэв маяг болон насны бүтцээс хамаарсан ангиллын дагуу сонгон авч, Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, гэр бүлийн гишүүдийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах ажлыг зохион байгуулж байна. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Шидэт толь” ТББ-тай хамтран 3 өрхөд сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээг хуваарийн дагуу хүргэж, 3 иргэн</p>	100	100			

		хамрагдсан. Гэрээр айлчлагч хөтөлбөрийн хүрээнд 13 дугаар хороо "БИД НЭГ ГЭР БҮЛ- ЭРҮҮЛ АМЬДРАЛ" сарын аяныг зохион байгууллаа. Хорооны иргэд, цогц төгсөлтийн аргачлал болон гэрээр айлчлагч төсөл хөтөлбөрт хамрагдсан зорилтот өрхийн 75 иргэд оролцсон.				
		3. Өрхийн хэрэгцээ, чадавх, санал санаачилгыг дэмжин эмзэг бүлгийн өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.	ГБХЗХХ, НХХ, ТББ-ууд	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	30%	
		Өрхийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан өрх толгойлсон /эцэг/ эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, зорилтот бүлгийн нийт 394 иргэн дүүргийн Засаг даргад хандаж тусламж, дэмжлэг хүссэн өргөдөл, хүсэлт ирүүлснээс “Нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу 233 иргэний өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн. Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй нийт 136 иргэнд албан бичгээр хариу өгсөн ба одоогоор 25 иргэний өргөдөл судлагдаж байна.			100	100
		1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийг хангах чиглэлээр олон талт үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	ГБХЗХХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
16	1.3.5 Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, оюун ухаан, авъяас билэг, бие бялдар, ур чадварыг нь хөгжүүлэхэд чиглэсэн “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, төрийн болоод төрийн бус байгууллагатай хамтран сар бүр гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, аз жаргалтай гэр бүл, эцэг, эхийн оролцоо, үүрэг хариуцлага зэрэг сэдвүүдийн хүрээнд 25 үйл ажиллагаагаар 2185 эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулсан нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 оныг үндэсний хэмжээнд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”-ын жил болгон зарлаж дүүргийн 1-19 дүгээр хорооны иргэд, хүүхэд, залуучуудад “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтыг 21 удаа зохион байгуулж дээрх сургалтад нийт 585 иргэн хамрагдсан. Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Хайлааст” ОНХХ-тэй хамтран ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургуулиудын хүүхэд багачууд, оюутан залууст Хүүхдийн эрх, хамгааллын талаарх хууль, Залуучуудын хөгжлийг хангах тухай хууль, сургууль орчин дахь хүүхэд хамгаалал, цахим орчин дахь гэмт хэрэг, архи, тамхи, мансууруулах бодис, хорт зуршил болон сэтгэл зүйн сэдвийн хүрээнд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж 2600 гаруй хүүхэд, залуусыг хамрууллаа. “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох Олон Улсын өдөр”-ийг			100	100

		<p>тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын Газар, Гэмт хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлын Зохицуулах Салбар зөвлөл, Дэлхийн Зөн Монгол" ОУ-ын байгууллага хамтран "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг хамтдаа" 1 сарын аяныг өрнүүлж ажиллалаа. Аяны хүрээнд "Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооё" уриан дор Ерөнхий боловсролын 12 сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдыг хамруулсан "Хүүхэд хамгаалал" өртөөчилсөн сургалтад 2000 гаруй хүүхдийг, багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг, эхчүүдэд чиглэсэн "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалтад 400 гаруй иргэнийг хамруулж, "Хүүхэд хамгаалал ба бидний оролцоо" сэдэвт илтгэлийн уралдааныг зарлаж 26 хүүхэд илтгэлээ хэлэлцүүлж, "Хүүхэд хамгаалал ба бидний оролцоо" хүүхдийн чуулганд 250 гаруй хүүхдэд хамрагдаж, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа "Сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор" 110 дугаар сургуулийн сурагчдын дунд "Гэр бүлдээ бичих миний захидал" гар зургийн уралдаан зарлан "Сэтгэлийн оч" арга хэмжээг тус тус зохион байгуулан нийт 2732 хүнийг хамруулан ажиллалаа. "Хүүхдийн урлагийн бага наадам"-ыг зохион байгуулж, наадамд 5, 23, 24, 39, 57, 61 дүгээр сургуулийн нийт 115 хүүхэд, багш нарын хамт оролцсон. "Хүүхдийн урлагийн их наадам"-ын 2 дугаар шатанд 39,57,24, 61 дүгээр сургуулиуд тэргүүлж, Үндэсний их баяр наадмын хүндэтгэлийн тоглолтод оролцох эрхтэй болсон. Нийслэлийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар, JCI ОУББ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс хамтран "Нэг цэцэг нэг дэлхий" аян зохион байгуулсан. Аяны хүрээнд нийслэлийн дүүрэг тус бүрээс 5 сургуулийг сонгож, ЕБС-ийн анги танхимд цэцэг тарих, тарьсан цэцгээ бусад сургуулиудад бэлэглэх үйл ажиллагаа зохион байгуулагдсан. Чингэлтэй дүүргээс 72, 17, 49, 39, 57, 50 дугаар сургуулийн нийт 1500 хүүхэд, нийгмийн ажилтнууд, анги удирдсан багш нарын хамт оролцов. "Цагаан нуга" ОУ-ын хүүхэд, гэр бүлийн зуслантай 2016 оноос эхлэн 3 дахь жилдээ хамтран ажиллаж, хороодын зорилтот бүлгийн болон дүүрэг, хороодын ажилтан албан хаагчдын хүүхдүүдийг зусланд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Энэ онд ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн оролцооны байгууллагын хүүхдүүдийг дэмжин, 15 сургуулийн 16 төрлийн клуб, бүлгэмийн 225 хүүхэд, дүүрэг, хорооны ажилтан албан хаагчдын 75 хүүхэд, нийт 300 хүүхдийг энэхүү зуслангийн 2 ээлжид хамрууллаа.</p>					
		<p>2. Хүүхдийн номын өргөөг түшиглэн зөөврийн номын санг ажиллуулна.</p>	<p>ХНӨ, НХХ, БХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>		

		<p>Дүүргийн ерөнхий боловсролын 138 дугаар бага сургуулийн сурагчдад “Номтой богц” зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж, бага ангийн хүүхдүүдийн сонирхдог үлгэр, уран зохиол, танин мэдэхүйн 50 ширхэг номоор үйлчиллээ. Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурагчдын ном унших сэдэл тэмүүлэл төрүүлэх, бүтээлчээр унших арга зүйг дээшлүүлэх, зохиолын өнгө аясыг мэдэрч бусдад өгүүлэх, хэл яриаг хөгжүүлэх, уран яруу унших чадварыг нээн хөгжүүлэх, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэх, бие биенээсээ суралцах, тэдний идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, дэмжиж урамшуулах зорилгоор “Үлгэрч хүүхэд” тэмцээн амжилттай зохион байгууллаа. Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн нийт 16 сургуулийн сурагч оролцсон байна.</p>	70	70		
	3. Хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс хамгаалах “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, дэмжин ажиллана	ГБХЗХХ, НХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		<p>Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран JICA, Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр 2015-2018 оны хооронд хэрэгжүүлж байгаа “Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Архангай аймгийн Батцэнгэл, Хайрхан, Эрдэнэбулган сумын 4 хамтарсан багийн гишүүд, нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн 6 хамтарсан багийн гишүүд дүүргийн 9, 10 дугаар хорооны хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцах, харилцан туршлага судлах, мэдээлэл солилцох, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх зорилготой уулзалтыг зохион байгууллаа. Дүүргийн “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийн хүрээнд Шинжлэх Ухаан Технологийн Их сургуультай хамтран “Өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах дарамт дээрэлхэлд, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэднийг эрүүл аюулгүй орчинд өсөн хөгжихөд орон нутгийн нөөц боломжийг илрүүлэх нь” сэдвээр хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах сургалтыг зохион байгуулж 90 хүн хамрагдсан. Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагын “Чингэлтэй-Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр”-тэй хамтран 7-12 дугаар хороодын хамтарсан багийн гишүүдийн чадавхыг сайжруулах, мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа хамтран төлөвлөх уулзалтыг зохион байгуулж 45 хүн хамрагдсан. Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, ДЗМОУБ-ын “Чингэлтэй” ОНХХ, Хайлааст” ОНХХ-тэй хамтран дүүргийн 1-19 дүгээр хороодын Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын чиглэлээр зөвлөлдөх уулзалт,</p>		100	100	

		<p>сургалтыг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Уулзалтаар 2018 онд хамтарсан багийг ажлын байран дээр нь чадавхжуулах, кейс менежмент, үр дүнд суурилсан тайлагналт, нөхцөл байдлын үнэлгээ хийх, бүртгэлийг сайжруулах, маягтуудыг бөглөх аргачлалд суралцах, дүүргийнхээ холбон зуучлах үйлчилгээний хөгжилд анхаарах, гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөр, хүмүүжлийн эерэг аргын аян зэрэг цаашид хамтран явуулах арга хэмжээнүүдийн талаар санал солилцож уулзалт, хэлэлцүүлэгт нийт 66 хүн хамрагдав. Дүүргийн 9 дүгээр хорооны Хамтарсан багаас “Хамтарсан багийн туршлага солилцох уулзалт өдөрлөг”-ийг зохион байгуулж, 1-19 дүгээр хороодын хамтарсан багуудын нийт 70 хүн хамрагдлаа. Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулж буй хамтарсан багийн ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах, хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, арга зүй, харилцан туршлага солилцох, шилдэг хамтарсан баг шалгаруулах “Асуудал ба шийдэл” аяны хүрээнд Чингэлтэй дүүргийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Чингэлтэй дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэс, 19 хороотой хамтран хэсгийн ахлагч нарт Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг эрт илрүүлэх, мэдээлэгдэх байдлыг нэмэгдүүлэх, нууцлалыг хадгалах, мэдээллийн үнэн зөв байдалд дүн шинжилгээ хийх, мэдээллийг хүлээн авах, мэдээлэх чиглэлээр 2 төрлийн сургалтыг 05 сарын 07-оос 05 сарын 16-ны хооронд 5 удаа зохион байгуулж, 155 хэсгийн ахлагч буюу нийт хэсгийн ахлагчийн 79 хувь нь хамрагдлаа. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий хороодын хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих тухай дүүргийн Засаг даргын 2018 оны А/233 дугаар захирамжийг гаргаж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын тушаалаар хороо тус бүрд улиралд 150 мянган төгрөгийн тээврийн болон шуудан холбооны зардлыг олгож байхаар шийдвэрлэж, олгож эхэлсэн.</p>					
2. ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ							
2.1 ЭДИЙН ЗАСАГ							
17	2.1.1 Монгол Улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн	1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил, тод нээлттэй	СТСХ, ТХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		

бие даасан байдлыг бэхжүүлэн, захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.	байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.					
	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх, татвар хураалтыг сайжруулах, татварын дутуу төлөлтийг барагдуулах талаар үе шаттай ажлуудыг зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын 2018 оны А/13 дугаар захирамж гарч дэс дараалсан арга хэмжээ авч ажилласнаар 9 дүгээр сарын байдлаар 57233 тээврийн хэрэгсэл татварт хамрагдахаас 40352 хамрагдаж, тээврийн хэрэгслийн татварт хамрагдалт 70,5 хувьтай, АТБӨЯХАТатвар 85,9 хувийн, агаарын бохирдлын төлбөр 86,1 хувийн, автозам ашигласны төлбөр 89,5 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 2018 оны эхний 11 сарын 15-ны өдрийн байдлаар улсын төсөвт 68.188,6 сая төгрөг төвлөрөхөөс 72.936,5 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 107,0 хувийн, нийслэлийн төсөвт 70.183,7 сая төгрөг төвлөрөхөөс 60.262,0 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 86,0 хувийн, орон нутгийн төсөвт 58.559,5 сая төгрөг төвлөрөхөөс 50.811,8 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 86,8 хувийн тус тус биелэлттэй ажилласан.				100	100
	2. Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийн, зардал бууруулах, төсвийн сахилга хариуцлага, дүүргийн төсвийн байгууллагуудын орлого, зарлага хөрөнгө оруулалтын ажил болон хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.	СТСХ, ДАА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, 2015 оны 230 дугаар тогтоолын хүрээнд төсөвт байгууллагын санхүүжилтийн эрх болон холбогдох зардлуудыг өдөр тутам үндсэн баримтаар хянан, гүйцэтгэлээр нь олгох ажлыг хийж гүйцэтгэсэн. Төсвийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай дүүргийн Засаг даргын 2018 оны А/13 дугаар тогтоолыг нийт төсөвт байгууллагуудад хүргүүлж, өдөр тутмын гүйлгээ, сар тутмын мэдээ гүйцэтгэлийг шалгах замаар хяналт тавьж ажилласан. Дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг хянан хүлээн авч нэгтгэснээр төсвийн зардлыг бууруулах оновчтой аргыг олоход шаардлагатай судалгааны суурь баазыг нэмэгдүүлсэн. Тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн төсөвт байгууллагуудын хангамж, эд хогшил, урсгал засварын 2017 оны бэлтгэн				100	100	

		<p>нийлүүлэгч байгууллагуудын судалгааг гаргасан. Дүүргийн 2018 оны батлагдсан төсөвт тусгагдсан гэрэл цахилгаан, халаалт дулаан, цэвэр бохир усны үнэ, тариф тооцооллын үндэслэлийг үндсэн нэгжид зааварчлах, хянан шалгах ажлууд хийгдсэн. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дүүргийн хэмжээнд төсвөөс гаргаж байсан гар утасны зардлын санхүүжилтийг зогсоож, 1 өдөр явах авто машины шатахууны зардлыг 40 км-ээс хэтрүүлэхгүй байхаар тооцсон. Барилгын төсөв зохиох дүрэм, ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181 дүгээр тушаал, НИТХТ-ийн 2009 оны 62 дугаар тогтоол болон бусад шийдвэрт үндэслэн нэгж гэрэлтүүлгийн ашиглалтын зардлын өртгийн тооцоолол хийсэн. Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт хийх журам, цаашид төсвийн төлөвлөлтийг сайжруулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад анхаарч ажиллах тухай албан бичгийг 56 төсөвт байгууллагад хүргүүлж ажилласан.</p>				
	<p>3. Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төсвийн захирагч, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт семинар зохион байгуулж, мэдээллээр хангана.</p>	<p>СТСХ, ММНБИ, НБХС, СБ-ууд</p>	<p>Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо</p>	<p>100%</p>		
		<p>Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн ажилтан нарын мэдлэг боловсролыг системтэйгээр дээшлүүлэх сургалтын 2018 оны нэгдсэн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх, бэлтгэл зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн. Дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Дотоод аудитын албатай хамтран ажилласнаар 2018 оны эхний 2 сарын гүйцэтгэлд шалгалт хийсэн. Уг шалгалтад орон нутгийн 7, тусгай зориулалтын шилжүүлгийн 45, нийт 52 төсөвт байгууллагууд хамрагдсан ба хуулийн шаардлага хангаагүй 6 байгууллагад “Албан шаардлага” өгч, 46 байгууллагад “Зөвлөмж” хүргүүлэн ажилласан. Дүүргийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх цаашид авах арга хэмжээний талаар зохион байгуулах ажлын чиглэл, түүний үр дүнгийн талаар Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарын 2018 оны ээлжит нэгдсэн сургалт-зөвлөгөөнийг 2018 оны</p>	<p>100</p>	<p>100</p>		

		<p>4 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” боловсруулах арга зүй, санхүүгийн тайлангийн аудит хийлгэхэд анхаарах асуудлаарх сэдэвт нэгдсэн сургалтыг 2018 оны 5-р сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгууллаа. Дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын Эд хариуцагч нарт “Хоол, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт ба хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зохистой дадал, хадгалалт, хамгаалалтын стандартын агуулга”, Эд хариуцагчийн эрх, үүргийн дүрэм түүний агуулга, эд хариуцагчийн тухай ойлголт, “Маягт заавар батлах тухай” Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын агуулга, хөтлөх аргачлалын талаарх нэгдсэн сургалт зөвлөгөөнийг 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Нэгдсэн сургалт зөвлөгөөнд төсөвт байгууллагуудын 55 эд хариуцагч нар оролцлоо. Дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудад 2018 онд хийх зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах ажлын нэгдсэн удирдамжийг боловсруулан 2017 онд нэмэлт бүлгээр ашиглалтад орсон 221, 222-р цэцэрлэг, 117-р сургууль зэрэг төсөвт байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг гүйцэтгэж, шалган зааварчлах хуудсаар цаашдын ажлын чиглэлийг өгч ажиллалаа.</p>					
		<p>4. Улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээний уялдааг ханган, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж, олон нийтийг мэдээллээр хангана.</p>	<p>СТСХ, ДАА, ХБТХАХ, ХААА</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>		
		<p>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2018 онд санхүүжих 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн гэрээ байгуулан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 100 хувь дууссан бөгөөд хөрөнгө оруулалтын ажлын холбогдох материалыг үндэслэн гэрээг дүгнэж, гүйцэтгэлээр 326,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгон хяналт тавин ажилласан. Дүүрэгт Улс, нийслэлийн болон дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалт, тохижилтын ажлуудын мэдээллийг дүүргийн chingeltei.gov.mn сайтаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлж ажилласан. Мөн Нийслэлийн Засаг даргын 2018 оны 03</p>			<p>100</p>	<p>100</p>	

		<p>дугаар сарын 29-ний өдрийн А/268 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэлд хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын бүртгэл хяналтын “OPEN.ULAANBAATAR.MN” цахим системд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 6,2 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий төсөл арга хэмжээ, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 487,3 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 28 төсөл арга хэмжээ, нийслэлийн Засаг даргаас дүүрэгт эрх шилжиж ирсэн нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн 569,1 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 11 төсөл арга хэмжээ, мөн дүүрэгт эрх шилжсэн нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 140,0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 1 төсөл арга хэмжээ, нийт 7,4 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 60 төсөл арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулсан. Ингэснээр Иргэд өөрийн дүүрэг, хороондоо хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын талаар холбогдох мэдээллийг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран шуурхай, бодитойгоор хүлээн авах, мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлсэн.</p>					
		<p>5. Дүүргийн орон нутгийн төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд, ОНӨААТҮГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилт, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.</p>	СТСХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		<p>Чингэлтэй дүүргийн “Шилэн дансны мэдээлэл” самбарын доторх тоон болон график, диаграммын хүснэгтэн мэдээллийг сар бүр сольж, иргэд, олон нийтэд мэдээллийг ил тод, нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар, иргэд, олон нийтэд мэдээллэж ажиллалаа. Мөн дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 75 төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарын өргөтгөсөн семинарыг Дотоод аудитын албатай хамтран 2018 оны 3 дугаар сард зохион байгуулан, “Төсөвт байгууллагуудын 2017 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн шалгалтын дүн, цаашид анхаарах асуудал”-ыг хэлэлцүүлэн, тодорхой үүрэг чиглэлээр ханган ажилласан байна. Дүүргийн төсвийн орлого, нэгдсэн зарлага, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, тэгшитгэл, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгдсэн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн зарлагын нэгдсэн гүйцэтгэлүүдийг тоон болон график, диаграммын хүснэгтэн мэдээллийг сар бүр улсын шилэн дансны нэгдсэн сайтад хугацаанд нь оруулж, иргэд, олон нийтэд мэдээллийн ил тод, нээлттэй,</p>			100	100	

		ойлгомжтой, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллалаа.				
		6. Улс, нийслэл, дүүргийн төсвөөс санхүүжигдэх төсөл, арга хэмжээний уялдааг ханган, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд тавих хяналтыг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хийнэ.	СТСХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгөөс эрх шилжиж ирсэн 1 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Мөн нийслэлийн төсөв болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас худалдан авах ажиллагааны эрх шилжсэн 12 төсөл арга хэмжээнээс 12 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчийн хяналт гүйцэтгэх холбогдох байгууллагуудад материалыг хүргүүлэн хяналт тавин ажиллалаа. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд санхүүжих 51 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, үнэлгээний хорооны зөвлөмж дүгнэлтийг үндэслэн гэрээ байгуулан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлын холбогдох материалыг үндэслэн гэрээг дүгнэж, гүйцэтгэлээр 4,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон хяналт тавин ажилласан. ар тогтоолоор Иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулж, тухайн хорооны иргэд өөрсдийн хороонд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын явц, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.			100	100
18	2.1.2 Дүүргийн өмч хөрөнгийн ашиглалтын менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.	1. Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг хагас, бүтэн жилээр явуулж, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулна.	СТСХ, НӨХГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Дүүргийн өмчийн цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбайн ашиглалт хамгаалалтыг дүүргийн тохижилт үйлчилгээний компанид гэрээгээр хариуцуулан арчлалт, хамгаалалт, сэргээн засварлалтыг тухай бүр хийн ажиллаж, шаардлагатай барилга байгууламжуудыг аж ахуй нэгж, албан байгууллага, төрийн бус байгууллага, иргэнд ашиглалт хамгаалалтыг хариуцуулан ажилласан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан 69 төсөл арга хэмжээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж дууссан 27 төсөл арга хэмжээ нийт 96 төсөл арга хэмжээний орон нутгийн өмчид хүлээн авч бүртгэх			100	100

		<p>ажлын хэсэг хүлээн авч холбогдох байгууллагын өмч, бүртгэлд тусгах ажлыг зохион байгууллаа. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 39 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/385 дугаар захирамжийг үндэслэн Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 238 дугаартай Хөрөнгө бүртгэх тухай тушаалаар дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 12 дугаар хорооны Жишиг өрхийн эмнэлгийн барилгыг дүүргийн өмчид бүртгэсэн. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/713 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2017 оны А/685 дугаар захирамжаар Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэн санхүүгийн тайланд тусгах, болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх зохион байгуулах бүхий ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах дахин үнэлгээнд хамрагдах төсөвт байгууллагуудад үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын бэлтгэлийг хэрхэн хангах тухай зөвлөмж, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээний гарын авлагыг хүргүүлэн ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/424 дүгээр тушаалаар Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлыг 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 28-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөн, тооллогын бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.</p>					
19	<p>2.1.3 Дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн гадаад орнуудын сайн туршлагыг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>1. Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэн шинээр хамтын ажиллагаа тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд улс орнуудын сайн туршлагаас нэвтрүүлнэ.</p>	ХБТХАХ, СТСХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		<p>Гадаадын улс орон, хот, дүүрэгтэй шинээр хамтын ажиллагаа тогтоох хүрээнд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доан Тхи Хыөнг-ийг дүүргийн Засаг дарга хүлээн авч уулзан тус улсын Хо Ши Мин хотын аль нэгэн дүүрэгтэй жижиг дунд үйлдвэрлэл, боловсрол, аялал жуулчлал, нийгэм эдийн засгийн болон бусад салбар чиглэлийн хамтын ажиллагаа тогтоох тал дээр санал солилцов. Гадаад улс орнуудын сайн туршлагаас нэвтрүүлэх болон дүүргийн “Өрхийн хөгжлийг дэмжих жил” –ийн хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын “Чөлөөт худалдааны бүс”-ийн үйл ажиллагаатай танилцах, дүүргийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах, боломжийг судлах зорилгоор албаны хүмүүс гадаад албан томилолтоор ажиллаж, улмаар үүний үр дүнд 2018 оны 01 дүгээр сарын 10-</p>			100	100	

		<p>17-ны өдрүүдэд тус хотод зохион байгуулагдсан “Хятад-Монголын Цагаан сарын үзэсгэлэн”-нд дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, бараа бүтээгдэхүүн борлуулан харилцан туршлага солилцсон. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Япон улсын Нийгата мужийн Госен хотод томилолтоор ажиллан сурагч солилцоо хөтөлбөрийг хэрэгжүүлэх, саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлд туршлага судалж ирсэн. Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотын Синжан дүүргийн Засаг даргын урилгаар гэр хорооллын дахин төлөвлөлтийн чиглэлээр туршлага судлах, гэр хорооллын дахин төлөвлөлт, хог боловсруулалт, ногоон байгууламж болон бусад салбар дахь харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилго бүхий Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ахлуулсан баг 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд албан томилолтоор ажилласан. Томилолтын хугацаанд Синжан дүүргээс санаачлан хэрэгжүүлж байгаа дахин төлөвлөлт, хог ангилан боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй танилцаж, туршлага судалсан. БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Ордос хотын ажил мэргэжлийн дээд зэргийн дунд сургуулийн зочид төлөөлөгчдийг дүүргийн Засаг дарга хүлээн авч, багш солилцооны төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах, туршлага судлах, сайн технологи, арга зүйг орон нутагтаа нутагшуулахаар санал солилцсон. Тус ажлын үр дүнд дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын монгол хэлний судлагдахууны баг БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Ордос хотын ажил мэргэжлийн дээд зэргийн дунд сургуульд зочилж, туршлага солилцсон. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монголын Үндэсний Хүмүүнлэгийн хороо болон Бүгд Найрамдах Итали улсын “Глобал Тема” олон улсын хүмүүнлэгийн байгууллага хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Санамж бичгийн хүрээнд талууд ажлын байр нэмэгдүүлэх, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, орон сууцжуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж хамтран ажиллана. Мөн Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор спортын салбар болон бусад салбаруудад хамтран ажиллахаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.</p>					
		<p>2. Дүүргийн гадаад харилцааны бодлогын баримт бичгийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар</p>	ХБТХАХ	Боловсруулах баримт бичгийн явц хувиар	100%		

		батлуулан хэрэгжүүлнэ.					
		Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан холбогдох зүйл заалтын дагуу Чингэлтэй дүүргийн гадаад харилцааны нэгдсэн бодлогын баримт бичгийг иргэд олон нийтээр хэлэлцүүлж, иргэдээс гарсан саналыг баримт бичигт тусгах зорилгоор “Нээлттэй хэлэлцүүлэг”-ийг 1-19 дүгээр хороодын “Иргэний танхим”-д зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт нийт 350-400 иргэн хамрагдаж хөтөлбөрүүдэд тусгах санал хүсэлтээ илэрхийллээ. Иргэдээс гарсан санал, хүсэлтийг хуульд нийцүүлэн бодлогын баримт бичигт тусган, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулахаар дүүргийн Засаг даргын 2018 оны 1/988 тоот албан бичгээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад өргөн мэдүүлж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 29 дүгээр тогтоолоор хэлэлцүүлэн батлуулсан.			100	100	
20	2.1.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгож, “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлэн, сонгон шалгаруулалтын ил тод байдал, иргэд олон нийтийн оролцоог хангана.	1. Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй мэдээллэнэ.	XAAA	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 08 дугаар тогтоол, дүүргийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2018 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу тус дүүрэгт 2018 онд Улс, нийслэл, дүүргийн төсөв, Нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан болон дүүргийн төсвийн хөрөнгөөр 2017-2018 онд он дамжуулан хэрэгжүүлэх нийт 11 192 622 100 төгрөгийн төсөвт өртөг бүхий 94 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулан ажиллалаа. Мөн Чингэлтэй дүүрэгт 2018 онд хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг гарган дүүргийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн дагуу Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлэн ажиллалаа. Мөн бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг chingeltei.gov.mn, өдөр тутмын хэвлэл “Засгийн газрын мэдээ” сонинд олон нийтэд ил тод, нээлттэйгээр хэвлэн мэдээлж ажиллалаа.			100	100	
		2. Тендерт оролцогчдын мэдээллийн	XAAA	Үйл	100%		

		санг бий болгож, тендертэй холбоотой мэдээллийг ил тодоор мэдээллэн худалдан авах ажиллагааны зарчмыг баримтлан тендер шалгаруулалтыг зохион байгуулна.		ажиллагааны хэрэгжилт, хувиар			
		Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмын хүрээнд дүүрэгт хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд орж ажиллах захиалагч, иргэн, Төрийн бус байгууллагын төлөөллийг бүрдүүлэн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ олгох сургалтыг 2018 оны 02 сарын 03-05 ны өдрүүдэд зохион байгуулан иргэний төлөөлөл 9, захиалагчийн төлөөлөл 9, мэргэжлийн байгууллагын төлөөлөл 1, нийт 19 хүн хамрагдсанаас 9 хүн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ гэрчилгээ авсан. Мөн үнэлгээний хороонд орж ажиллах иргэний төлөөллийг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 10 тоот тогтоолоор батлуулан ажиллалаа. Төсвийн сахилга хариуцлагыг чангатган төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ажлын хүрээнд Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер зохион байгуулах" журмын дагуу нийт 1 990 286 800 төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 төсөл хөтөлбөр, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn цахим хуудсаар зохион байгуулан ажиллалаа. Тендерт оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор ханган тендерийн урилгыг цаг тухай бүр дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудаст байршуулж, нээлттэй тендерийн урилгыг өдөр тутмын "Монголын үнэн" сонинд нийтлүүлж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллалаа. Тайлант хугацаанд өдөр тутмын сонинд 10, дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудсанд нийт 69, www.tender.gov.mn цахим хуудсанд 32 тендерийн урилгыг нийтлүүлээд байна. Мөн www.shilendans.gov.mn цахим хуудсанд дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг нийтлүүлэн, худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг сар бүрийн 08-ны дотор байршуулан хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.			100	100	
21	2.1.5 Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг	1. Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал	ЭМНДХ	Даатгалд хамрагдагсдын тоогоор	100%		

<p>хангах хүрээнд хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p>					
	<p>Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогчийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулан ажилласны дүнд оны эхнээс шинээр 405 ажил олгогч, 1825 даатгуулагчийг хамруулж, шимтгэл тооцох цалингийн сан 1245.3 сая төгрөгөөр нэмэгдлээ. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Бөмбөгөр”, “Алтжин бөмбөгөр”, “Юмт бөмбөгөр”, “Хүчит шонхор”, “Хүчит шонхор-2”, “Нарантуул-2”, “Теди”, “Victoria”, “Цэцэг” худалдааны төвүүдэд давхардсан тоогоор 13 удаа өдөрлөг зохион байгуулснаар сайн дурын нийгмийн даатгалд 156, эрүүл мэндийн даатгалд 221 нийт 377 даатгуулагчдыг шинээр хамрууллаа. Нийгмийн даатгалын санд 2018 оны 10 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 182479.29 сая төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 190908.35 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөт зорилтоо 104.6 %-иар биелүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн орлого 30688.28 сая төгрөгөөр буюу 19.1 %-иар өслөө. Заавал даатгуулагчийн тоо өмнөх оныхоос 3338 даатгуулагчаар, ажил олгогчийн тоо 405 ажил олгогчоор нэмэгдсэн байна. Улаанбаатар цахилгаан түгээх ТӨУҮГ-ын харьяа Зуслангийн цахилгаан түгээх сүлжээний ажилтан албан хаагчид, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лабораторийн лаборант, мэргэжилтнүүд, 4 дүгээр цэцэрлэгийн багш ажилтан, Цагдаагийн ерөнхий газрын Тусгай ажиллагааны газрын алба хаагчид зэрэг нийт 20 гаруй ажил олгогчдын 1905 даатгуулагчдад нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах сургалт, өдөрлөгийг зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/32 дугаар захирамжаар батлагдсан хуваарийн дагуу дүүргийн 1-19 дүгээр хороодод "Нээлттэй өдөрлөг-Нэг цонхны үйлчилгээ" өдөрлөгийг зохион байгуулж, 469 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгснөөр 16 иргэн өндөр насны болон тахир дутуугийн тэтгэврээ шинээр тогтоолгон авсан. Мөн 4172 иргэн даатгуулагчид нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, ярилцлага хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан.</p>				100	100
	<p>2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж төлөх үйлчилгээг арилжааны банкны ухаалаг үйлчилгээ ашиглан төлөх ажлыг зохион байгуулна.</p>	ЭМНДХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
<p>Нийгмийн даатгалын шимтгэлийг Хаан банкны ухаалаг үйлчилгээ ашиглан төлөх ажлыг хэвшүүлж, Хаан банкаар үйлчлүүлж нийгмийн даатгалын шимтгэлээ төлдөг</p>				100	100	

		аж ахуйн нэгж байгууллага, иргэд 100 хувь ухаалаг үйлчилгээ ашиглан төлж байна. Төрийн банк, Хаан банкны ухаалаг үйлчилгээ ашиглан төлөгдөж байгаа нийгмийн даатгалын шимтгэл нийгмийн даатгалын сангийн нийт орлогын 52.4 хувийг эзэлж байна. Давхардсан тоогоор Хаан банкаар 11624 иргэн, Төрийн банкаар 16171 иргэн нийгмийн даатгалын шимтгэлээ банкны цахим, ухаалаг үйлчилгээг ашиглан төлсөн байна. Нийгмийн даатгалын салбарын хүрээнд Цахим үйлчилгээг хөгжүүлэх жил болгон зарлаж, энэ ажлын хүрээнд нийт 27 байгууллагын 2400 ажилтанд нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан нийт 1520 ажилтан, албан хаагчид Нийгмийн даатгалын аппликейшнийг гар утсандаа суулгах ажлыг зохион байгууллаа.					
22	2.1.6 Статистикийн тоон мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг сайжруулж, үнэн зөв байдлыг ханган, мэдээ судалгааны хамрах хүрээг өргөжүүлнэ.	1. Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр Статистикийн эмхэтгэл, нийгэм, эдийн засгийн танилцуулгыг сар, улирал, жилээр гаргаж иргэн аж ахуйн нэгж байгууллагуудыг мэдээллээр хангана.	СтХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Дүүргийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хийгдэх жилийн эмхэтгэлийг 2014-2017 оны динамик үзүүлэлтүүдээр 16 бүлэг 66 хуудас бүхий эмхэтгэл гаргаж 4 ширхэг хэвлүүлсэн. Дүүргийн нийгэм, эдийн засгийн танилцуулгыг дүүргийн хэлтэс албад, захиргааны болон албан ёсны статистик мэдээллийг оруулан сар бүр эмхэтгэн нэгтгэж Нийслэлийн Статистикийн газар, дүүргийн цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр ханган ажиллалаа.				100	100
		2. Хүн ам, өрхийн мэдээллийн санг баяжуулж, оршин суугчдын аюулгүй байдлын судалгаа, орон сууцны хангамж нөхцөл байдлын судалгаа, хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн судалгааг тодотгон шинэчилнэ.	СтХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Хүн ам, өрхийн мэдээллийн санд бүртгүүлээгүй шинээр төрсөн 1144 хүүхдээс 1112 хүүхдийн мэдээллийг бүрэн оруулсан. Байршил тодорхойлоогүй 1256 өрхөөс 1153 өрхийн байршлыг бүрэн тодорхойлж засварлав. Програмын алдаа 85421 байснаас 83160 алдааны мэдээллийг засварлаж, дүүргийн дүнгээр 97,4%-н гүйцэтгэлтэй байна. “Оршин суугчдын аюулгүй байдлын судалгаа”, “Орон сууцны хангамж нөхцөл байдлын судалгаа”, “хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”				100	100

		зэрэг 7 төрлийн судалгаа, танилцуулга бэлэн болж www.ubstat.mn цахим хуудсаар тархаасан.				
23	2.1.7 Монгол Улсын Татварын тухай болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын өр барагдуулалтыг ер стандартад хүргэж, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, татварын бааз суурийг өргөтгөнө.	1. Нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийслэл хотын албан татварын хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, иргэдийн татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	ТХ, СТСХ, МХХ, ЦХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		<p>Дүүргийн хэмжээнд тайлант хугацаанд Нийслэл хотын албан татвар төлөгчөөр шинээр 35 ААНэгж бүртгэгдэж, 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 837,314.9 мян.төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байна. Бараа үйлчилгээ эрхэлж, худалдан борлуулагч хувь хүн хуулийн этгээдийн НӨАТУС-д холбогдсон эсэхэд хяналт шалгалт хийх ажлын хүрээнд 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт торго, бөс бараа, алт мөнгөн эдлэлийн худалдаа эрхлэгч иргэн АА Нэгжийг түүврийн аргаар сонгон Монгол улсын стандартын шаардлага хангасан төхөөрөмж ашиглаж буй эсэх, төлбөрийн баримт хэвлэж буй эсэхийг шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллалаа. Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, валют арилжааны чиглэлээр үйл ажиллалаа эрхэлдэг татвар төлөгчдөд шалгалт хийж, Татварын албаны бүртгэл мэдээллийн системд холбогдоогүй, төлбөрийн баримт олгоогүй 23 татвар төлөгчдөд шаардлага хүргүүлэн, 6 татвар төлөгчийг төлбөрийн баримт олгоогүй үндэслэлээр 900,000.00 төгрөгийн шийтгэл оногдуулан прокурорын байгууллагаар хянуулсан. Сар бүр татварын тооцооллын судалгаагаар өр барагдуулах хүрэх түвшин тооцож байцаагч бүрд ялгамжтай хуваарилан ажилласнаар өр, дутуу барагдуулалт 10 дугаар сарын 31-ний байдлаар урьд оны өрийн барагдуулалт 56,1 %-тай , тайлант оны өрийн барагдуулалт 85,4%-тай тус тус барагдсан байна. Татварын ерөнхий хуулийн 13-р зүйлийн 13.6, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2-т заасан үүргээ биелүүлээгүй, улсын бүртгэлд оршин суухаар бүртгэгдсэн, хаяг байршилдаа байдаггүй, шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийг мэдэгдээгүй, оршин суугаа газар нь тодорхой бус, өртэй эрэн сурвалжлах тогтоолтой 15 ААН-ийн дэлгэрэнгүй судалгааг гарган, хаяг байршлыг тогтоох, өр төлүүлэх, шүүхэд нэхэмжлэх ажлыг хэрэгжүүлэхээр дүүргийн цагдаагийн 1,2 дугаар хэлтэстэй хамтран ажиллах албан бичиг хүргүүлээд байна. Тайлант хугацаанд ТЕГазрын тусгай дугаарын 1800-1288 утсанд ирсэн е-баримт олгоогүй тухай нийт 294 өргөдлийн мөрөөр ажиллаж, е-баримтыг нөхөн олгуулах, торгох зэрэг арга хэмжээ авч бүрэн шийдвэрлэсэн.</p>				100

		2. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй томоохон зах, худалдааны төвүүдийг татварын албаны “Нэгдсэн ба хэрэглэгчийн систем”-д холбон бүртгэлжүүлнэ.	ТХ, СТСХ, ХХҮХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		"Гар утасны худалдаа эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийг татварт хамрагдуулах, НӨАТУС-н хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын удирдамж"-ийг боловсруулан хэрэгжүүлж байна. Уг удирдамжийн дагуу 2018 оны 05 дугаар сарын 02-ноос 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд “Теди” худалдааны төвд гар утасны худалдаа эрхлэгчдийг НӨАТУС-д холбох удирдамжит ажлыг зохион байгууллаа. Үүнд: Тус худалдааны төвд гар утасны худалдаа эрхлэгч болон гар утасны засварын худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн татвар төлөгчийн бүртгэл, тооллогыг шинэчлэн хийх, НӨАТУС-д холбогдсон эсэхэд хяналт тавьж, НӨАТУС-д холбогдоогүй иргэн, ААНэгжид НӨАТ-ын хуулийн талаар сургалт явуулж, зөвлөгөө өгөх, НӨАТУС-д холбогдох талаар мэдэгдэл болон шаардлага хүргүүлэх, заасан хугацаанд шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээг авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний дүнд Теди худалдааны төвд үйл ажиллагаа эрхлэгч 385 хувь хүн хуулийн этгээдийг НӨАТУС-д бүрэн хамруулаад байна.				100	100
2.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ							
		1. Ажил олоход хүндрэлтэй, сургууль завсардсан иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг үзүүлж, 1000 иргэнийг ажлын байранд зуучилна.	ХХҮХ, НХХ	Ажилд зуучилсан иргэдийн тоогоор	50%		
24	2.2.1 Дотоодын ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй ашиглаж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн жилд 2000-аас доошгүй мэргэжилтэй ажилчдыг сургаж, хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангана.	Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй байгаа болон зорилтот бүлгийн иргэдтэй ганцаарчилсан уулзалт хийж, өөрсдийнх нь онцлогт нийцсэн ажил, мэргэжлийн сонголт, чадвар, чадавхыг тодорхойлон хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллалаа. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд нийт 4239 иргэн хамрагдсанаас ганцаарчилсан зөвлөгөөнд 1282, бүлгийн сургалтад 2950 иргэн хамрагдсан. Ажил хайгч 1450 иргэн, 124 ажил олгогч, 456 шинэ ажлын байрыг бүртгэж, 1286 ажлын байрны захиалгыг авч, 1008 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.				100	100
		2. Ажил, мэргэжилгүй иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн болон давтан	ХХҮХ, НХХ	Сургалтад хамрагдсан иргэдийн	50%		

		сургалтад хамруулах замаар ажилгүйдлийг бууруулан, ажлын байрыг нэмэгдүүлнэ.		тоогоор			
		Ажил идэвхтэй хайж хандсан иргэдийг бүртгэн авч, ажил олгогч байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг хүсэл сонирхол, дадлага туршлага, ур чадварыг нь харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн тохирох ажлын байранд холбон зуучлах үйлчилгээг үзүүлснээр 1450 иргэнийг ажил хайгч иргэний бүртгэл Хөдөлмөрийн зах зээл-2 маягтаар бүртгэн авч, холбогдох мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн менежер программ, LMIS санд бүртгэлжүүлэн оруулсан. Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн газраас мэргэжлийн болон давтан сургалтад нийт 121 иргэн хамрагдаж, мэргэжлийн чиг баримжаа олгосон чадамжийн гэрчилгээ олгосон. Мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэдийн судалгааг нэгтгэн гаргаж 56 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан байна. Хугацаат цэргийн алба хааж халагдан ирсэн 90 гаруй залууст хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан ба 200 гаруй байгууллагын 1200 орчим нээлттэй ажлын байрыг санал болгосон. Дээрх байгууллага аж ахуйн нэгжүүдээс “Эко констракшн” ХХК, “Шилэн хийц” ХХК, “Самшил” ХХК-тай хамтран ажиллаж, цэргийн алба хааж ирсэн 62 иргэнийг ажил хайгчаар бүртгэсэн байна.			100	100	
25	2.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.	1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн байнгын ажлын байр бий болгох багц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	ХХҮХ, НХХ	Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоор	50%		
		Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих” хөтөлбөр батлагдсантай холбоотойгоор 03 дугаар сарын 12-ноос 04 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэл “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний аж ахуй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ”-г зарлаж, нийт 68 төслийг хүлээн авч, ажлын байртай танилцах ажлыг зохион байгуулснаар 46 төслийг дэмжиж, 121.500.000 төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгон, эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж ажиллаж байн. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдах хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэн судалгаанд хамрагдсанаас 9 иргэнийг мэргэжлийн сургалтад /үсчин, оёдол, тогооч, нягтлан бодогч/ хамруулсан байна.			100	100	

26	<p>2.2.3 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний “Чингэлтэй” сүлжээг өргөжүүлэн, залуу ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлнэ.</p>	<p>1. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих багц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p>	ХХҮХ, НХХ	Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоор	100%		
27	<p>2.2.4 Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>1. Нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар орон нутгийн сайн засаглалыг бэхжүүлнэ.</p>	ТЗУХ, Хороод	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	30%	100	100
		<p>Өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд дүүргийн www.chingeltei.gov.mn сайтаар дамжуулан иргэдээс нээлттэй санал асуулга явуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авсан. Нээлттэй санал асуулгад иргэд идэвхтэй хамрагдсан бөгөөд дараах 7 чиглэлээр хамгийн өндөр санал өгсөн. Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, боловсролын орчин сайжруулах, хууль, хүчний байгууллагын үйлчилгээг сайжруулах, өрхийн орлого нэмэгдүүлэх, орчны тохижилт, сургалт зохион байгуулах, газар зохион байгуулалтын чиглэлээр өгсөн саналуудыг тусгасан Өрхийн хөгжлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг 6 бүлэг 202 заалттайгаар боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн УИХ-ын гишүүдийн иргэдтэй хийсэн уулзалтаас гарсан 97 саналыг Улс, Нийслэл, дүүргийн хэмжээнд хийгдэх боломжтой гэж 3 ангилан чиглэл чиглэлээр нь холбогдох дээд байгууллагад уламжлан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллалаа.</p>					

		2. Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгож, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх санал санаачилга гаргасан аж ахуйн нэгж байгууллагыг дэмжин хамтран ажиллана.	НХХ, ХХҮХ, ЭМТ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ы хүрээнд аж, ахуйн нэгж байгууллагад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог нэвтрүүлэх, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлж, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, зөвлөн туслах чиглэлээр нийт 98 аж, ахуй нэгж байгууллагад зөвлөгөө мэдээллийг өгч, 130 гаруй инженер, техникийн ажилтан, 60 гаруй оюутан залуучуудад зөвлөн туслах чиглэлээр сургалт зохион байгуулсан. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох чиглэлээр 300 гаруй аж, ахуйн нэгж байгууллагад зурагт хуудас, гарын авлага тараах материалыг тарааж, 3.052.130 төгрөгийн зардлыг Хөдөлмөр Эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёл, хандлагыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад түгээх, төлөвшүүлэх зорилгоор дүүргийн 19 хороонд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийг байгуулсан ба салбар зөвлөлийн гишүүдэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийн талаарх ойлголт мэдлэг олгох, чадавхжуулах сургалт”-ыг зохион байгуулж, нийт 103 хүнийг хамруулсан.			70	70	
2.3 ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ							
	2.3.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “Чингэлтэйд үйлдвэрлэв” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	1. “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны төвүүдийн барааны чанарыг сайжруулж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	ХХҮХ, БИТ	Борлуулалтын орлогыг 15 хувиар нэмэгдүүлнэ.	100%		
28		“Чингэлтэйд үйлдвэрлэв” салбар дэлгүүрүүдэд 2018 оны гуравдугаар улирлын байдлаар 1-19 дүгээр хорооны 219 үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг борлуулан нийт өссөн дүнгээр 224,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Бараа бүтээгдэхүүний борлуулалтаас бэлэг дурсгалын буюу жижиг эдлэлийн түлхүүрийн оосор арьс, гар урлалын бүтээгдэхүүн 42%, Монгол үндэсний дээл хувцас 35%, морин хуур хөгжим 3%, эсгий эдлэлийн бүтээгдэхүүн 10%, бусад бүтээгдэхүүн 10% ийг тус тус эзэлж байна. Бэлэг дурсгалын дэлгүүрийн барааны			100	100	

	<p> өрөлт хураалтыг шинэчилж шинээр худалдагч авч ажиллуулсан. Зуны улиралд Go travel ХХК хамтран ажиллаж жуулчдад зөвлөгөө өгч ажилласан. Чингэлтэй дүүргийн 1-р хороо 1-р 40 мянгат 7 байрны “Чингэлтэйд үйлдвэрлэв” дэлгүүрийн өргөтгөлд 13 хорооны иргэн И.Алтантуул 15 дугаар хорооны иргэн Б.Саранбямба нарыг ажлын байраар хангаж ажиллаж байна. Дээрх 2 иргэнийг дэмжин ажилласнаар шинээр 4 ажилтантай болж дунджаар сард 400-600 мянган төгрөгийн цалинтай ажиллаж байна. 15 дугаар хорооны иргэн Б.Саранбямба нь Жонон Од ХХК–тай хамтран Англи улсын Лондон хот руу арьсан хавтас бичиг хэргийн зарим арьсан бүтээгдэхүүнийг захиалгаар нийлүүлж байна. Алтжин худалдааны төв дэх “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны төвийн салбарт 41 иргэн хамрагдаж 70,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Монгол Улсын Засгийн газар болон Герман, Швейцар, Австрали Улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг дэмжих залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг бий болгох зорилгоор дүүргийн хүн амын нягтрал ихтэй 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэдийн хэрэгцээг хангахуйц жишиг орчин бүхий ажил, мэргэжлийн мэдээллийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг нээж нэгдүгээр давхарт “ЧИНГЭЛТЭЙД ҮЙЛДВЭРЛЭВ-3” төвийг байгуулаад байна. Уг төвд 25,8 сая төгрөгийн үнэ бүхий тавилга, тоног төхөөрөмж, ном, гарын авлагаар тохижуулж, иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах соёлд сургах, хөдөлмөрлөх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны ажлуудыг хийж байна. Чингэлтэйд үйлдвэрлэв-3 салбарт 21 үйлдвэрлэгч, 8 ерөнхий боловсролын сургууль, 16 цэцэрлэгийн хүүхдүүдийн хийсэн 13 сая төгрөгийн үнэ бүхий бараа бүтээгдэхүүнийг байршуулж, 2018 оны гуравдугаар улирлын байдлаар 5.4 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. Өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцаа, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний Чингэлтэйд үйлдвэрлэв” катологийг Smart chingeltei аппликэйшнд 167 үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг байрлуулж холбоо барих утасны дугаар бараа бүтээгдэхүүний зураг хаяг байршил, борлуулалтын цэг, цахим хаяг гэх мэт мэдээллийг бүрэн оруулсан. Өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн 19 хороодын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн жижиг дунд үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор ахмад настнуудад өгч </p>		
--	---	--	--

		<p>буй гарын бэлгэнд дүүргийн жижиг дүнд үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сонгон "Чингэлтэйд үйлдвэрлэв" нэрээр гаргах ажлыг зохион байгуулсан. Дүүргийн 7 дугаар хороонд байрлах Амуу фүүдс ХХК-ны савласан сүүтэй цай, 13 дугаар хороонд байрлах Бат сежү ХХК-ны ноосон бээлий, 16 дугаар хороонд байрлах хэвлэлийн Диамонд принт ХХК-ны цаасан уутны үйлдвэрүүдийг тус тус сонгож бэлгийн багцад оруулж, дүүргийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд дээрх үйлдвэрүүдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд хүргэж сурталчлан ажилласан. Үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх, харилцаа, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Бизнес инкубатор төвийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах "ХАМТДАА ХӨГЖЬЕ" катологийн 2018 оны дугаарыг бэлтгэн гаргахаар зураг авалтын ажлыг 2018 оны 1 дүгээр улирлаас эхлүүлж үндэсний хувцас, европ, Монгол гутал, сүлжмэл бэлэн хувцас, бэлэг дурсгал гар урлал, европ хувцас, эсгий эдлэл, мод модон эдлэл сийлбэр, арьсан эдлэл, бусад гэсэн 9 бүлгээр ангилан нийт 143 үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг оруулах мөн зөвлөгөө мэдээллүүдийг багтаасан эх бэлтгэлийг бүрэн хийж дууссан. Мөн веб сайт, цахим сувгаар дамжуулан үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих ажлыг зохион байгуулж, "Бүтээлч Чингэлтэйчүүд" фэйсбүүк цахим хуудсаар дамжуулан 13 үйлдвэрлэгчийг, МҮОНРТ-ийн "Үйлдвэрлэгчийн цаг" нэвтрүүлгээр 12 үйлдвэрлэгчийг нийт 25 үйлдвэрлэгч хамруулан сурталчлан ажилласан.</p>					
		<p>2. Үндэсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг сурталчлах, туршлага солилцох, дэмжих зорилгоор дотоодын болон гадаадын орнуудад зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаануудын мэдээллийг тогтмол хүргэн оролцуулах, хамтран ажиллах, бизнесийн түншлэл тогтооход холбон зуучилна.</p>	<p>ХХҮХ, МХАҮТ, БИТ, ОУБ</p>	<p>10-с дээш удаагийн үзэсгэлэнд 200 гаруй үйлдвэрлэгч хамруулна</p>	<p>100%</p>		
		<p>Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оны 3 дугаар улирлын байдлаар дотоодын нийт 10 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 100 гаруй үйлдвэрлэгчдийг дэмжин оролцуулж, 65,8 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. Мөн гадаадын орнуудад зохион байгуулагдсан 3 удаагийн үзэсгэлэн худалдаанд 46 үйлдвэрлэгчдийг хамруулж, 67,9 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p>	<p>100</p>	<p>100</p>			

29	2.3.2 Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	1. Жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт урт хугацаатай хөрөнгө оруулалтын болон санхүүгийн зээлд хамруулж, бодлогоор дэмжин ажиллана.	ХХҮХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр тушаалаар “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих”, “Ажлын байрыг дэмжих” хөтөлбөр тус тус батлагдан хэрэгжиж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрийн мэдээллийг үйлдвэрлэгчдэд хүргэж, жижиг зээлийн төсөл боловсруулах үйлчилгээг үзүүлж байна. үйлдвэрлэгчдэд мэдээлэл хүргэх ажлын хүрээнд зарлагдсан төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг БИТ-ийн хуудсанд байршуулж, мэдээллийн самбараар дамжуулж хүргэж байна. Уг ажлын хүрээнд санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлд хамрагдах хүсэлтэй 12 иргэнд төсөл бичих үйлчилгээг үзүүлсэн. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих зээлд 43 иргэнийг хамруулж 17.5 сая, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх зээлд 19 иргэн хамрагдаж 27.0 сая, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих зээлд 16 иргэнийг хамруулж 120.0 сая, 35-аас дээш насны иргэдийг дэмжих зээлд 93 иргэн хамрагдаж 212.5 сая төгрөгийн нийт 171 иргэнийг 377 сая төгрөгийн зээлд хамруулж ажлын байрыг 350-аар нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг сайжруулсан байна. Дэлхийн Зөн олон улсын байгууллагын Чингэлтэй, Хайлааст ОНХХ-өөс Цогц төгсөлтийн аргачлалын хөтөлбөрт хамрагдаж байгаа 92 иргэнд 172,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж эд материалын дэмжлэг үзүүлсэн.				100	100
30	2.3.3 Бизнес инкубатор төвийг бүсчилсэн хэлбэрээр нэмж байгуулна.	1. Бизнес инкубатор төвийн салбаруудын үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн хөнгөлөлттэй ажлын байраар хангаж, зөөврийн ажлын байрыг нэмэгдүүлнэ.	ХХҮХ, БИТ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Бизнес инкубатор төвийн салбаруудын тоог нэмэгдүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор төв байр болон салбар байрны 2 бойжигчийн инкубаци үйлчилгээний гэрээний хугацааг дуусгавар болгон 2 бойжигчийг шинээр элсүүлэн 40-80 хувийн хөнгөлөлттэй түрээсийн үйлдвэрийн байраар ханган ажиллуулж байна. 2018 оны гуравдугаар улирлын байдлаар төв байранд 9, 11 дүгээр хорооны				100	100

		<p>хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих инкубатор төвийн байранд 1, 17 дугаар хорооны салбар байранд 1 үйлдвэрлэгч нийт өссөн дүнгээр 11 үйлдвэрлэгч шинээр бойжиж, 43 ажлын байрыг бий болгоод байна. Шинээр бүртгүүлсэн болон хуучин үйлдвэрлэгчдийн ажлын байраар хангагдахаас өмнөх мөн дараах борлуулалтад 2018 оны 09 дүгээр сарын байдлаар нөхцөл байдлын судалгаа хийсэн ба судалгаанаас үзэхэд борлуулалт 6-8 хувь нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Дүүргийн “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 30 зөөврийн ажлын байр, 2017 онд 30 зөөврийн ажлын байрыг нийлүүлж, нийт 57 үйлдвэрлэгчийг 16-25 м кв хэмжээтэй зөөврийн ажлын байраар хангаснаар үйл ажиллагаа тогтмолжиж, бүтээгдэхүүний нэр төрөл 10 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Зөөврийн ажлын байрны ашиглалт, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дотор нь үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдээс нөхцөл байдлын судалгаа, хэрэглэгчийн үнэлгээг 1, 2 дугаар улиралд хийсэн. Тайлангийн хугацаанд үйл ажиллагаа нь доголдсон 2 ажлын байрыг буцаан татан авч оронд нь 2 үйлдвэрлэгчийг шинээр сонгон шалгаруулж, ажлын байраар хангагдаад байна. Ажлын байраар хангагдсан үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ 15 хувь, борлуулалтын орлого 6 хувиар нэмэгдэн, нийт 140 байнгын ажлын байрыг бий болгосон байна. 2018 онд дахин 30 зөөврийн ажлын байрыг шинээр хийхээр төлөвлөж, зураг төслийг гаргаж, сонгон шалгаруулалтын шатанд явагдаж байна.</p>					
31	<p>2.3.4 Үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, оюуны багтаамжтай үйлдвэрлэлийг голлосон инновацийг нэвтрүүлнэ.</p>	<p>1. Инновацад суурилсан кластерын төвөөр дамжуулан жижиг, дунд өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.</p>	ХХҮХ, НҮИГ, БИТ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	30%		
		<p>Кластерын төвд хамрагддаг үйлдвэрлэл эрхлэгчид Цагаан сарын баяртай холбогдуулан Монгол үндэсний дээл, хүрэм хантаас, цамц оёх захиалга өссөн ба 2-3 оёдолчид нэг баг бүрдүүлж, хувцас эсгэх, оёх, дээл хавах, шилбэ хадах зэрэг оёдлын үйл ажиллагааг дамжлагын системээр хийж гүйцэтгэсэн нь цаг хугацаа болон эдийн засгийн хэмнэлттэй үзүүлэлт гарсан. Монгол түмний уламжлалт Сар шинийн баярыг угтан дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Нэг Архангай” төрийн бус байгууллагатай хамтран “Цагаан сарын үзэсгэлэн худалдаа 2018” үзэсгэлэн худалдааны үеэр дүүргийн Кластерын төвийн оёдолчдоор үзэсгэлэнд оролцсон</p>				100	100

		иргэдэд 250 хормогч, ханцуйвчаар буюу 1.6 сая төгрөгийн хувцсаар жигдрүүлэх ажлыг хийлгүүлсэн. Кластерын дамжлагын системийг нэвтрүүлэн ажиллаж, байгууллага аж ахуйн нэгжүүдээс оёдлын дамжлага шаардагдсан буюу олон ширхэгээр үйлдвэрлэдэг ажлын хувцасны захиалгуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Засаг даргын Тамгын газарт 512 мянган төгрөгийн өртөг бүхий сандлын бүрээс, БНСУ сурагч солилцооны хөтөлбөрөөр Монголд ирсэн 26 сурагчдад 1,2 сая төгрөгийн Монгол цамц, Одкон ХХК-ны ажилчдын хувцас 4.8 сая, Бүүдий ХХК-ны ажилчдын хувцас 6.0 сая, Япон амортизаторын ажилчдын хувцас 1.0 сая, дүүргийн Улаан загалмайн хорооны ажилчдын хувцас, форм 200 ширхэг 17.0 сая нийт 30,5 сая төгрөгийн захиалга авч хийж гүйцэтгэсэн бол бага хэмжээний захиалгат ажлын хүрээнд нийт 20.0 сая төгрөгийн ажил үйлчилгээ хийж гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна. Дүүргийн Кластерын төвд 7, 9, 10, 12, 14, 17 дугаар хорооны нийт 12 иргэн тогтмол хамрагдаж, оёдлын кластерын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.					
2.4 ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ							
32	2.4.1 Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд хэрэглэгчдийн хүнсний талаарх боловсролын түвшинг дээшлүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.	1. Хэрэглэгчийн хүнсний талаарх боловсролыг дээшлүүлэх, худалдаа үйлчилгээний байгууллагуудыг ахисан түвшинд хүргэх зорилгоор аяны хүрээнд сургалтуудыг зохион байгуулна.	ХХҮХ, ЭМТ, Хороод, мэргэжлийн холбоод	600 гаруй иргэнийг хамруулна.	100%		
		Дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 том зах, худалдааны төвүүдтэй хамтран ажиллах “САНАМЖ БИЧИГ”-ийг байгуулж, ёслолын ажиллагааг 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Хамтран ажиллах чиглэлийн хүрээнд 7 заалтын хэрэгжилтийг ханган ажиллахаар тусгасан бөгөөд хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр худалдааны төвүүдээс авч нэгтгэн жилийн эцсээр үр дүнг тооцон шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулна. Санамж бичгийн хүрээнд гуравдугаар улирлын байдлаар Эрдэнэбулган ХХК 23,4 сая төгрөгийн барилгын иж бүрэн засварын ажил, мах, ногоо, архи, ундааны тасгийг иж бүрэн шинэчлэн засварлахад 23,4 сая, агааржуулалтын системийн хэсэгчлэн засварлахад 1,2 сая төгрөгийн тус тус зарцуулан нийт 45 гаруй иргэний ажлын байрны нөхцөлийг сайжруулсан. Алтжин худалдааны төвөөс 9,2 сая төгрөгөөр гэрэлтүүлэг болон агааржуулалтын системийн засвар үйлчилгээ, мах ангилан ялгах, жижиглэн савлах өрөөг 1,6 сая төгрөгөө тус тус тохижуулан хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “ХУУЛЬ			100	100	

		<p>СУРТАЛЧЛАХ” сургалтыг Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Монголын жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн холбоо, Монголын худалдагч нарын холбоотой хамтран давхардсан тоогоор 5 удаа зохион байгуулсан. Сургалтад 7-10 дугаар хороодын 40, согтууруулах ундаа худалддаг 111, 3 удаагийн төвлөрсөн арга хэмжээний хүрээнд худалдаа эрхлэгч 55, нийт 210 гаруй аж ахуйн нэгж, иргэд хамрагдан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2017 оны А/253 дугаар захирамжаар байгуулагдсан “Засаг даргын дэргэдэх Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн хуралдаанаар дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд зуны түр худалдаа /хүнсний болон хүнсний биш барааны худалдаа, үйлчилгээ/ эрхлэхээр хүсэлт гаргасан 159 ААН, иргэдийн асуудлыг хэлэлцүүлэн зөвлөлийн гишүүдийн саналаар 4-н нэр төрлийн худалдаа үйлчилгээг 18 цэгээр гаргахаар шийдвэрлэн гарсан шийдвэрийг дүүргийн ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан. Дүүргийн ИТХТ-ийн хуралдаанаар зуны түр худалдаа үйлчилгээний асуудлыг дүүргийн тухайн онд дэвшүүлсэн Өрхийн хөгжлийг дэмжих жилийн ажилтай уялдуулан түр ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 37 байршилд зуны түр худалдаа гаргахаар шийдвэрлэснийг www.chingeltei.gov.mn сайтад байршуулан иргэдэд мэдээллийг ил тод, нээлттэй хүргэсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 126 дугаар тогтоолын дагуу “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”-ын шинэчилсэн төслийн хэлэлцүүлгийг 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдөр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын алба, Засаг даргын Тамгын газар хамтран дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Анкор” төвийн хурлын зааланд зохион байгуулсан. “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”-ын шинэчилсэн төсөлд иргэдийн саналыг тусгах зорилготой тус хэлэлцүүлэгт дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, түргэн үйлчилгээний цэг, нийтийн эзэмшлийн зам талбайд худалдаа эрхлэгчид, Сууц өмчлөгчдийн холбоод, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон иргэдийн төлөөлөл 200 гаруй хүн оролцсон.</p>					
		<p>2. Хүнсний аюулгүй байдлын хүрээнд хүнсний бөөний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд бараа бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн талаарх сургалтыг давтамжтайгаар зохион байгуулж, мэргэжил арга зүйн</p>	<p>ХХҮХ, МХХ, СХЗҮТ, мэргэжлийн н холбоод</p>	<p>200-300 гаруй иргэнийг хамруулна.</p>	<p>100%</p>		

		удирдлагаар ханган ажиллана.				
		<p>Хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Эрдэнэбулган, Алтжин, Хүчит Шонхор, Анко ХХК-ний гүйцэтгэх албан тушаалтнуудыг ШӨХТГ, НМХГ, Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбооны дэргэдэх Худалдааны академиас зохион байгуулсан сургалтад тус тус хамруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан. Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс Эрдэнэбулган ХХК дээр хүнсний худалдаа эрхлэгч 50 гаруй түрээслэгч нарт “Хүнсний аюулгүй байдлын орчин” сэдэвт сургалт, Алтжин худалдааны төв дээр Онцгой байдлын хэлтсээс “Галын аюулаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт 1 өдрийн үзүүлэх сургууль, МЖДД Холбооноос Анко худалдааны төвийн 125 гаруй хүнсний худалдаа эрхлэгч нарт “Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хадгалалт” сэдвээр тус тус давхардсан тоогоор 4-5 удаагийн сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 380 гаруй түрээслэгч нар хамрагдсан. Гуравдугаар улирлын байдлаар зах, худалдааны төвд ажилладаг нийт 2100 түрээслэгчдээс хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 810 гаруй түрээслэгчдийг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах ажил 100 хувь хийгдэж хүнсний худалдаа эрхлэгчид бүгд нэг өнгийн хувцсаар ижилсэн жигдэрсэн. Гар дээрээс ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, хороодын Засаг даргын Ажлын албатай хамтран 2018 оны 3 дугаар улиралд гар дээрээс ил задгай худалдаа эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус-3, урьдчилан сэргийлэх-2, нийт 5 удаагийн хяналт шалгалтыг ажлыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтын явцад нийт 501 зөрчил илрүүлж, 367 зөрчлийг газар дээр арилгуулсан. Мөн 137 ширхэг 191,000 төгрөгийн түргэн муудаж гэмтдэг хүнсний бүтээгдэхүүнийг хураан улсын байцаагчийн акт үйлдэн газар дээр нь устгасан. Зөрчлийн тухай хуулийн хүрээнд илэрсэн зөрчилд 900,000 төгрөгийн торгууль шийтгэврээр ноогдуулан нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй хүнсний бараа бүтээгдэхүүн худалдаалахгүй байх талаар 160 иргэнд зөвлөмж, хорооны нутаг дэвсгэрт хүнсний худалдаа эрхлүүлэхгүй байх тал дээр байнгын хяналт тавьж ажиллах талаар Хороодын Засаг дарга нарт 2 удаа албан тоот хүргүүлсэн.</p>			100	100
		3. Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор бөөний худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан мониторинг	ХХҮХ, МХХ	6 зах, худалдааны төвүүдийг хамруулна.	100%	

	<p>хийж, дүгнэлт гаргуулна.</p> <p>Нийслэлийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах сургалт, судалгаа шинжилгээний төв, хотын үйлдвэрчний эвлэлийн хороо, дүүргийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг томоохон 8 зах, худалдааны төвд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулсан. Шалгалтаар тус зах, төвүүдээр давхардсан тоогоор өдөртөө 600,000-700,000 гаруй хэрэглэгч үйлчлүүлдэг, зах, худалдааны төвүүд нь бүгд өөрийн байгууллагын онцлогт тохирсон хэрэглэгчийн булан ажиллуулж 120 гаруй иргэнээс өргөдөл, гомдол хүлээн авч хэрэглэгчээс санал хүсэлт авдаг механизмыг бүрдүүлсэн байна гэж ажлын хэсгээс дүгнэсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна. Хэрэглэгчийн санал гомдлыг ихэвчлэн зах, худалдааны төвийн эрүүл ахуйн эмч нар давхар хариуцан ажиллаж, түрээслэгч нарт холбогдох хууль, дүрмийг сурталчлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж удирдлагууддаа танилцуулдаг журам тогтож хэвшсэн байна. Дүүргийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, зах худалдааны төвүүдийн менежерүүдтэй хамтран хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор шинээр гарсан холбогдох хууль, тогтоомжийн талаар гарын авлага, зөвлөмж, зааварчилгааг боловсруулан зах, худалдааны төвүүдийн хэрэглэгчийн буланд байршуулан сурталчлах ажлыг хамтран зохион байгуулсан. Хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилтын хүрээнд түргэн үйлчилгээний цэгүүдэд 2018 оны 09 дүгээр сарын байдлаар давхардсан тоогоор нийт 4 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.</p> <p>Нийтийн орон сууц, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ойр байрлаж, иргэдийн ая тух, аюулгүй байдлыг алдагдуулж байгаа ресторан, баар, цэнгээний газруудын судалгаа гаргаж ирүүлэх тухай дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 01 дүгээр 11-ний өдрийн 3/64 дүгээр албан бичгээр дүүргийн 19 хороод руу чиглэл өгч судалгааг авч нэгтгэн нийт 86 газрын судалгааг гаргасан.</p>				100	100
	<p>4. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хүнсний талаарх боловсролын түвшин дээшлүүлэх сургалт, өдөрлөгийг зохион байгуулна.</p>	ХХҮХ, БХ, ТББ-ууд	20 сургууль, 40 цэцэрлэг хамрагдана.	100%		
	<p>Цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох зорилгоор “Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн гал тогооны үйл</p>				100	100

		<p>ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлох” ажлын удирдамжийг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан МУ-ын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, дүүрэг дэх Боловсролын хэлтэс, дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран төрийн өмчийн 29 цэцэрлэг, төрийн бус өмчийн 26 цэцэрлэг нийт 55 цэцэрлэгийн гал тогооны үйл ажиллагаатай танилцаж, үнэлгээ дүгнэлт өгч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Төрийн өмчийн 29 цэцэрлэгийн нийт 58 албан хаагч, төрийн бус өмчийн 26 цэцэрлэгийн үүсгэн байгуулагч болон тогооч, нярав нарт “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP , GHP/ болон “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратеги хэрэгжүүлэх тухай” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт болон “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зохистой дадал” нэвтрүүлэх сэдвийн хүрээнд эрүүл зохистой хооллолтын талаарх мэдлэг олгох сургалтыг цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, нярав нарт зохион байгуулж нийт 40 гаруй хүнийг хамруулсан. Цаашид цэцэрлэг болон сургууль дээр “Зохистой хооллолт” сэдвийн хүрээнд өдөрлөгийг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/58 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP, GHP/ нэвтрүүлэх нь сэдэвт сургалтыг дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 55 цэцэрлэг, төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 5, нийт 20 сургуулийн цайны газрын эздийг хамруулан зохион байгуулж, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын ажилтан ажиллагсад интерактив зөвлөмжийг танилцуулах зорилгоор дүүргийн вэб сайтад байршуулан ажиллалаа.</p>				
	<p>5. Бага насны хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохирсон шинэлэг аргаар хоол шим тэжээлийн боловсрол олгох цуврал хичээлийг бэлтгэн, цэцэрлэг, сургуулиар дамжуулан хүүхэд, багш, эцэг эхчүүдэд мэдлэг олгоно.</p>	<p>ХХҮХ, ШУТИС, ТББ-ууд</p>	<p>1 хүүхэлдэйн кино хийнэ.</p>	<p>100%</p>		
		<p>Бага насны хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохирсон хоол, шим тэжээлийн боловсрол олгох цуврал хичээл нь хүүхдийг багаас зөв хооллолтын дадал, хандлагатай болгон төлөвшүүлэх зорилготой бөгөөд нийт 10 анги хүүхэлдэйн киног хийхээр төлөвлөн хоол шим тэжээлийн мэдлэг олгох онолын хэсгийг бэлтгэсэн. Нийт 10 сэдвийн хүрээнд хүүхдэд хоол шим тэжээлийн мэдлэг олгох онолын мэдээллийг</p>	<p>70</p>	<p>70</p>		

		хүүхдийн зохиолчоор хүүхэлдэйн киноны зохиол болгон бичүүлж бэлэн болсон хүүхэлдэйн киноны зохиол дээр ШУТИС-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, БСШУС-ын яамны сайдын зөвлөх, хоолзүйч М.Пүрэвжаваар хянуулан шинжлэх ухааны үндэслэлтэй хоол шим тэжээлийн мэдлэг олгох тал дээр нь анхаарч зөвлүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар хүүхэлдэйн киноны баатруудыг зурах ажлыг хийж гүйцэтгээд байгаа бөгөөд баатрууд нь үндэсний уламжлалт ёс заншлыг өвлүүлэн хадгалуулах, хүндэтгэн дээдлэх хандлагыг төлөвшүүлэх үүднээс үндэсний хувцас, монгол дээл, гуталтай манай улсад нэн ховордож улаан номонд орсон амьтад болох Мазаалай, Үен, Аргаль, Ирвэс, Бөхөн амьтдаар дүрслэгдсэн.				
		6. Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний жишиг загвар гал тогооны үйл ажиллагааг тогтмолжуулж, тогооч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан, хүүхдийн хоолны технологи, дэглэм, шим тэжээлийн гарын авлагыг бэлтгэн гаргана.	ХХҮХ, ШУТИС, ТББ-ууд	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
		Дүүргийн 74, 108 дугаар цэцэрлэгүүдийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Чиглэл” ХХК, 102 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга дээр шинээр байгуулагдах гал тогоог “Жишиг загвар гал тогоо” болгон тохижуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах ажлын гүйцэтгэгчээр “Тулга төхөөрөмж” ХХК шалгарч ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 4 дүгээр хороонд баригдаж буй 240 хүүхдийн багтаамжтай 18 дугаар цэцэрлэгийн барилгын зураг төслийн 1 давхрын хоол үйлдвэрлэл үйлчилгээний зохион байгуулалт, технологийн урсгал шугам буруу төлөвлөгдсөн байгааг залруулан зурж, гүйцэтгэгч Шувууны хайрга ХХК-д 2 загварын хамт албан бичгээр хүргүүлэн барилгын ажлыг залруулан зургийн дагуу гүйцэтгүүлсэн.			100	100
33	2.4.2 Худалдаа үйлчилгээний салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай	1. Худалдаа, нийтийн хоолны байгууллагуудын ажилчдын дунд ажил мэргэжлийн уралдаан тэмцээн, зөвлөгөөн зохион байгуулна.	ХХҮХ, НЗАА	120 гаруй ААН, иргэнийг хамруулна.	100%	
		Тамгын газраас зохион байгуулсан “УЛААНБАТАР ФҮҮД ФЕСТИВАЛЬ-2018” арга хэмжээнд Чингэлтэй дүүргийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 10 гаруй аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан их хотын хоолны соёлыг олон нийтэд сурталчлан ажилласан. Тус фестивалийн үеэр Нийслэлийн			100	100

	<p>хамтран мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.</p>	<p>нэрийн хоол шалгаруулах тэмцээний “Улаанбаатар шөл” номинацид Чингэлтэй дүүргийн тогооч н.Отгонбаярын шөл шалгарч “Улаанбаатарын од” цомоор шагнуулсан. Мөн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын “RESTO EXPO-2018” үзэсгэлэнд оролцож хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр шинээр үйл ажиллагаа эрхлэх, салбарын хэмжээнд тавигдах стандарт, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар 30 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан.</p>				
	<p>2. Худалдаа, нийтийн хоолны салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэргэшүүлэх сургалтыг давтамжтайгаар зохион байгуулах, аттестатчиллын шалгалтад хамруулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.</p>	<p>ХХҮХ, СХЗҮТ, МХХ, Мэргэжлийн холбоод</p>	<p>4-5 удаагийн сургалт зохион байгуулна.</p>	<p>100%</p>		
		<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамжаар “Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарь болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудын ажиллах цагийн хуваарь”-ийг шинэчлэн батлахаар ажиллаж байгаа бөгөөд уг ажилтай холбогдуулан Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу худалдаа, үйлчилгээ эрхлэгчид, иргэдийг хамруулсан хэлэлцүүлгийг 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Тэнгис” кинотеатрын 3 дугаар танхимд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт 300 гаруй аж ахуй нэгж, иргэдийг хамрууллаа. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарь болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудын ажиллах цагийн хуваарийн өөрчлөлтийн тухай танилцуулж, санал асуулга явуулсан ба шинэчилсэн цагийн хуваарийн төслийг оролцогчдын 60 хувь нь дэмжиж, 40 хувь нь нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн байна. Мөн оролцогчдоос худалдаа, үйлчилгээний байгууллагууд өвөл, зуны цагийн хуваарьтай болох, баар болон караокег орон сууцнаас хамгийн багадаа 100-200 метрийн зайтай байлгах зэрэг саналууд гарсныг нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанд албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаагийн баталсан удирдамжийн дагуу “Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай”</p>	<p>100</p>	<p>100</p>		

		<p>хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн цайны газрын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийн дагуу 2018 оны 03 дугаар сард дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулиудын гал тогоонд ШУТИС, Нийслэлийн өмчийн газар, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн Боловсролын хэлтэс хамтран дүүргийн хэмжээнд төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 5 нийт 20 сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн цайны газрын үйл ажиллагаанд үзлэг шалгалтыг хийж эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилж байгаа эсэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”-ын дагуу “Үйлчилгээ эрхлэх гэрээ” байгуулан ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллийг дүүргийн www.chingeltei.gov.mn цахим сайтын үндсэн цэсэд байршуулж ажиллаж хэвшсэн. Тамхины тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан ААН, иргэдийн үйл ажиллагаанд хяналт хийж 9, 10, 12 16 дугаар хороодод байрлах 5 дэлгүүрийн үйл ажиллагааг шалгаж, дэлгүүрийн орчны байдалд үнэлэлт өгч, тамхи худалдаалах боломжтой эсэхэд дүгнэлт гарган ажлын хэсгийн хуралдаанд танилцуулж ажилласны үр дүнд Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2013 оны А/236 дугаар захирамжаар байгуулагдсан “Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах” ажлын хэсгийн хуралдааныг хуралдуулж, 10 аж ахуйн нэгжийн зөвшөөрлийг сунгаж, 3 аж ахуй нэгжид шинээр зөвшөөрөл олгосон.</p>					
		<p>3. Тэргүүний худалдаа, нийтийн хоолны байгууллага шалгаруулах, шагнаж урамшуулах, үйл ажиллагааг нь дэмжин сурталчлах ажлыг зохион байгуулна.</p>	<p>ХХҮХ, Хороод</p>	<p>Хамрагдсан ААН-ийн тоо, чанарын үзүүлэлтээр</p>	<p>100%</p>		
		<p>Сар шинийн баярыг тохиолдуулан нийслэлийн хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан малчид, тариаланчдыг шагнаж урамшуулах арга хэмжээний хүрээнд дүүргийн 19 дүгээр хорооны иргэн Б.Даринчулууныг Нийслэлийн “Шилдэг тариаланч”-аар, шалгарсан. Мөн дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2007 оноос хойш хүнс, худалдаа, алт мөнгөний дарханы үйлдвэрлэлийн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж буй “Их мөнгөн” ХХК-ны захирал З.Баттулгыг тухайн дүүргийн 60 гаруй иргэдийг байнгын ажлын байраар ханган ажиллуулж, худалдааны салбарт оруулсан хөдөлмөрийг үнэлж Чингэлтэй</p>			<p>70</p>	<p>70</p>	

		дүүргийн Хүндэт тэмдгээр шагнаж, урамшуулсан. Монгол улсад Худалдаа, үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний 97 жил, Эх үрсийн баярыг тохиолдуулан дүүргийн худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарт олон жил тогтвортой, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажилласан, бага насны хүүхдүүдийг эрүүл хоол хүнсээр хангаж, хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэн ажиллаж байгаа цэцэрлэгийн тогооч нар болон худалдаа үйлчилгээний салбарын зарим ажилтан албан хаагч нийт 30 иргэнийг Монгол Улсын Засгийн газрын шагнал “Худалдаа, үйлдвэрийн тэргүүний ажилтан” цол тэмдэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ЭДКС хими цэвэрлэгээний газрын захирал Ц.Сосорбарам, оёдолчин Д.Энхтуяа нарыг “Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулсан.					
34	2.4.3 Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцлийг бүрдүүлж, газар тариалан эрхлэгчдийг бараа бүтээгдэхүүнээ борлуулахад нь дэмжлэг үзүүлнэ.	1. Гэр хорооллын иргэдийг чанартай хүнсний ногоогоор дамжлагагүйгээр шууд хангах зорилгоор "Ногоо худалдаалах цэг" байгуулна.	ХХҮХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Хүнсний ногоо үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн газар тариалан эрхлэх хүсэлтэй болон эрхэлж буй нийт 222 иргэн 10 төрлийн 31.9 кг нарийн ногооны үрийг тараах ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж байна. Төмс, хүнсний ногооны хадгалалт, хангамжийг сайжруулах борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгох зорилгоор иргэдэд эх орны хөрсөнд ургасан, хямд чанартай төмс, хүнсний ногоо нийлүүлэх ажлын хүрээнд дүүргийн 16 дугаар хороонд байрлах ногоо худалдаалах чингэлэгт 3 иргэнийг, 18 дугаар хороонд байрлах Адра ОУБ-ын чингэлэгт 2 иргэнийг, түр ажлын байраар ханган ажиллуулж 1, 14 дүгээр хороонд байрлах Гацуурт ХХК-ны нэрийн барааны ногоо худалдаалах чингэлгээр үйлдвэрийн үнээр, шат дамжлагагүйгээр худалдаалах ажлыг тус тус зохион байгуулж ажиллалаа. Нийслэл, дүүргийн иргэдийг шинэ ургацын төмс хүнсний ногоогоор хангах зорилтын хүрээнд “Монгол ногоо төсөл”, Сэлэнгэ аймагтай хамтран “Шинэ ургацын төмс, хүнсний ногоо”-ны үзэсгэлэн худалдааг Барилгачдын талбайд зохион байгуулж, нийт 15 тариаланчдыг оролцуулж, 3 дугаар улирлын байдлаар 150 гаруй тонн хүнсний ногоо худалдаалагдсан байна.			100	100	
		2. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийг нэгтгэн бүлэг үүсгэж, ногоо тарих арга технологид сургаж, НОГООЧДЫН БҮЛЭГ	ХХҮХ, ХөХҮХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар,	100%		

		байгуулна.						
		<p>Өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд иргэдийг өрхийн орлоготой болгох, эрүүл хөрсөнд тарьсан төмс хүнсний ногоогоор хангах ажлын хүрээнд дүүргийн 8, 9, 12, 13, 15, 17, 19 дүгээр хороодод 19 ногоочдын бүлгийг байгуулан ажиллаж байна. Ногоочдын бүлэгт дүүргийн 222 иргэн хамрагдаж байгаа бөгөөд 137 иргэн байнгын ажлын байргүй иргэд байна. Ногоочдын бүлэг нь Төв аймгийн Баян чандмань суманд 20 га, СХД-ийн 21 дүгээр хороонд 1 га газарт тариалалт хийж нийт 20 га-гаас 33 тонн шар манжин, 5 тонн хүрэн манжин, 6 тонн шар лууван хураан авсан байна. АДРА олон улсын байгууллагын “Өрхийн тогтвортой тариалан” төсөлтэй хамтран “Ургацын баяр-2018” арга хэмжээг 9 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа.</p>			100	100		
35	2.4.4 Ахуй үйлчилгээний төвлөрсөн бичил төв байгуулах иргэд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, санал санаачилгыг дэмжинэ.	1. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах халуун ус, ахуйн үйлчилгээний төвүүдийн ашиглалтыг сайжруулна.	ХХҮХ, ОУБ-ууд	7, 10, 17, 18 дугаар хороодын халуун ус, ахуйн үйлчилгээний төв	80%			
		<p>Дүүргийн 10 дугаар хороонд байрлах Ахуйн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, цахилгаанд холбох асуудлыг дүүргийн төсвийн 3.6 сая төгрөгийн хөрөнгөөр шийдвэрлэж, чанар хүртээмжийг сайжруулахаар ажиллаж байна. Уг ахуйн үйлчилгээний төвд нийт 9 ажлын байранд Цахилгаан барааны засвар үйлчилгээ, Хувцас захиалга, засвар, Гэр ахуйн модон эдлэлийн засвар, Канон бичиг хэргийн үйлчилгээ, Гутал засварын үйлчилгээнүүд үйл ажиллагаа явуулж 8 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллуулж байна. Иргэдэд хүн амын ахуйн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд хувийн хэвшлийн халуун усны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг дэмжин, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллалаа. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар дүүргийн гэр хороодын нутаг дэвсгэрт нийт 44 халуун ус идэвхтэй үйл ажиллагаа явуулж, ойролцоогоор давхардсан тоогоор 51 мянга гаруй иргэд үйлчлүүлсэн байна. Дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт стандартын шаардлагад нийцсэн халуун ус, бассейн, сауны чиглэлээр ЭБО трейдинг ХХК үйл ажиллагаа явуулж эхлээд байна.</p>					100	100
		2. Олон Улсад зохион байгуулагдах үсчин гоо сайханчдын уралдаанд	ХХҮХ, НЗАА,	Үйл ажиллагааны	100%			

		дүүргээс төлөөлж оролцох үсчин гоо сайханчдыг дэмжиж ажиллана.	МҮГСХ	хэрэгжилт хувиар, тэргүүний туршлага нэвтрүүлнэ.			
		Дүүргийн Үсчин гоо сайханч, хумс засалчдын аварга шалгаруулах тэмцээнээс шалгарсан эрэгтэй 1, эмэгтэй 1, хумс засалч нийт 3 иргэнийг 2018 оны 09 дүгээр сард Филиппин улсад Ази номхон далайн орнуудын үсчин гоо сайханчдын аварга шалгаруулах олон улсын тэмцээнд дэмжин оролцуулсны дүнд Evergood салоны үсчин тус тэмцээнээс 3 дугаар байрын шагнал хүртсэн байна.				100	100
		3. Үсчин, гоо сайханчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор уралдаан тэмцээн зохион байгуулна.	ХХҮХ, МҮГСХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Монголын үсчин, гоо засалчдын холбоотой хамтран “Чингэлтэй дүүргийн аварга үсчин, гоо засалч, хумс засалчдыг шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан-2018” тэмцээнийг 6 дах жилдээ амжилттай зохион байгуулж, 5.4 сая төгрөгийг зарцуулсан. Тэмцээнд нийт 354 салоны 65 гаруй үсчин, гоо сайханч, хумс засалчид оролцож, мэргэжлийн чадвараараа өрсөлдөж, аварга үсчин, гоо засалч, хумс засалчдыг тодруулж, байр эзэлсэн үсчин гоо засалчдыг шагнаж урамшуулсан.				100	100
3. ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ-ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ							
3.1 ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА							
36	3.1.1 Улс, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г жил бүр тодотгон хэрэгжүүлнэ.	1. Дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.	ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар 15-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа. Газрын төлбөрийн орлогод 2018 онд нийт 400 сая төгрөг төвлөрүүлэхээс 381,8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 95,4 хувьтай байна. Тайлант хугацаанд дүүргийн Засаг даргын 96 удаагийн захирамжаар баталгаажих 921, нэр шилжих 869, хугацаа сунгах 634, талбай зориулалт өөрчлөх 111 нийт 2535 иргэн, хуулийн этгээдийн газар асуудлыг шийдвэрлэсэн байна.				100	100
		2. Нийтийн эзэмшлийн зам талбайд	ГА, НГА	Үйл	100%		

	зөвшөөрөлгүй тавигдсан ТҮЦ, хайс, хашаа зэргийг “Хашаа” нэгдсэн арга хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ.		ажиллагааны хэрэгжилт хувиар		
	Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй тавигдсан ТҮЦ, хайс, хашааг нүүлгэх, газрыг чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд нийт гэр хороолол зусланд 70, төвийн хэсэгт зөөврийн граж контейнер, ТҮЦ 38-ийг чөлөөлөөд байна.			100	100
	3. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг, төрийн үйлчилгээний барилга байгууламж барихад газар чөлөөлөлтийн ажлыг зохион байгуулна.	ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
	Газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөрийн хүрээнд шинээр барих барилга, байгууламж, авто замын трасст орж, нөлөөлөлд өртөж байгаа нэгж талбаруудыг чөлөөлөх ажлыг Нийслэлийн Газрын албатай хамтран хийж гүйцэтгэлээ. Үүнд: 12, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдахаар төлөвлөгдөж буй бага сургууль цэцэрлэгийн цогцолборын байршлыг тогтоож газар чөлөөлөлтийг 100% хийж гүйцэтгэсэн. Мөн 11-р хороонд баригдахаар төлөвлөгдсөн 170 ортой хүүхдийн цэцэрлэгийн газар, 11-р хороонд баригдахаар төлөвлөгдсөн Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн төвийн барилгын газар, 19-р хороо Яргайтын аманд барихаар төлөвлөгдөж байгаа өрхийн эмнэлэг болон авто замын засвар шинэчлэлт болон шинээр баригдах авто замын трасст өртөж буй газар, 7-р хороо Далан давхрын шинэ авто замаас 224-р цэцэрлэг хүртэлх шинээр баригдах авто замын трасст өртөж буй газар, 16-р хороо 139-р бага сургууль 221-р цэцэрлэгийн урд автомашины зогсоол байгуулах газар, 7-р хороо Төслийн талбарын Бичил дэд төв /сервис центр/ газар, 10-р хороо дэнжийн 32, 33-р гудамжинд баригдах Эрүүл мэндийн төвийн барилгын газар, 12-р хороо 138-р сургууль, 220-р цэцэрлэг Түшиц хана хийх газрыг тус тус бүрэн чөлөөлсөн.			100	100
	4. Сэлбэ дэд төв, Дэнжийн 1000 дэд төвийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг хамтран хэрэгжүүлнэ.	ГА, ТНААХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
	Авто зам, инженерийн шугам сүлжээний трасст орсон 114 нэгж талбараас 100 айл өрхтэй зөвшилцөлд хүрч, үүнээс 50 орчим айл өрх нөхөн олговроо авсан. Бусад			70	70

		айл өрхтэй зөвшилцөх ажил хийгдэж байна. Айл өрхүүдтэй зөвшилцөж дууссаны дараа авто зам, шугам сүлжээний ажил хийгдэж эхэлнэ. Үерийн далан сувгийн засварын ажлын гүйцэтгэгчээр “Тэнүүн инвест” ХХК, “Набсан” ХХК-иуд ажиллаж байгаа. Одоогоор Яргайтын 40, 41 дүгээр гудамжны үерийн далангийн ажлыг хийж дуусгаад байна.						
37	3.1.2 Иргэдэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх болон газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжин, газрын харилцаатай холбоотой мэдээллийг нээлттэй ил тод болгоно.	1. Газар өмчлөлийн талаар нарийвчилсан мэдээлэл бүхий сан үүсгэж, иргэд, олон нийтэд нээлттэй ил тод болгоно.	ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			
		Нийслэлийн үйлчилгээний "Оргил" нэгдсэн төв дээр Нийслэлийн газрын албаны газар өмчлөлийн хэлтэстэй хамтран Нээлттэй хаалганы өдөрлөгийг хийсэн. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт 1409 хашааны газар өмчлөгдөөгүй гэсэн судалгааг гарган 206 айлтай уулзалт хийж, материалын бүрдэл хангасан 132 иргэний асуудлыг шийдвэрлэсэн.				100	100	
		2. Иргэн бүрийг өмчтэй болгох бодлогын хүрээнд хашааны газар өмчлөл, зуслангийн газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			
		Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 101, 187 дугаар тогтоолоор батлагдсан хаягжилт, ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу дүүргийн зуслангийн амуудад газар эзэмшиж буй иргэдэд газрыг өмчлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2018 оны гуравдугаар улирлын Нийслэлийн Засаг даргын 12 удаагийн захирамжаар 1003 иргэнд газрыг нэг удаа үнэгүйгээр өмчлүүлсэн. Үүнээс хашааны газраа өмчилсөн 409, зусланд газраа өмчилсөн 591 иргэн байна.				100	100	
		3. Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй тавигдсан ТҮЦ, хайс, хашаа зэргийг чөлөөлөн байршуулах “Журмын хашаа”-г барина.	ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			
	Дүүргийн Газрын албаны журмын хашааг дүүргийн Засаг даргын 2012 оны А/152 дугаартай захирамжийн дагуу 7 хорооны нутаг дэвсгэрт 5293 м2 талбай бүхий газрын байршлыг тогтоож бүртгэлжүүлсэн.					70	70	
38	3.1.3 Дүүргийн нутаг дэвсгэрт тохилог орон сууц, амины орон сууц барих төсөл	1. Дүүргийн гэр хороодод төвлөрсөн хангамж бүхий дэд төвүүдийг байгуулах ажлын хүрээнд иргэдийн бүлгийг байгуулж, тооцоо судалгааг гаргаж,	ХБТХАХ, ТНААХ, ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			

	хэрэгжүүлэгчдийг дэмжин ажиллаж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд холбогдсон тохилог сууцнуудыг бий болгоно.	хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллана.						
		“Гэр хорооллын иргэдийн өмчлөлийн газар, амины орон сууцанд нь инженерийн болон нийгмийн дэд бүтцийг хүргэх, холбох “Дэд бүтцийн төв” барих ажил дүүргийн 7 дугаар хороонд хэрэгжиж байна. Дэд бүтцийн төв барих ажлын хүрээнд нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газартай хамтран нийт 5 удаа хорооны Иргэний танхимд иргэдтэй уулзалт зохион байгуулж, 201 нэгж талбарын айл өрхүүдэд төслөө танилцуулж, зөвшилцөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 2 айлын газрыг нөхөх олговортойгоор чөлөөлүүлэн 06 дугаар сараас төслийн хэрэгжилтийг эхлүүлсэн. 09 дүгээр сарын 18-ний өдрийн байдлаар Дэд бүтцийн төв болон Цэвэрлэх байгууламжийн барилгын хийц хийгдэж дууссан. Дүүргэлт, ханын дулаалга, цэвэр бохир усны шугам хоолойн ажлууд хийгдэж байна.					100	100
		1. Нэн шаардлагатай орон сууцны байрнуудын дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	ТНААХ, ХААА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			
39	3.1.4 Олон жил болсон орон сууцны байрнуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 50,0-тын 21 дүгээр байр, 40,0-тын 28 дугаар байрнуудын 10 хаалгыг домофон системтэй хаалгаар солих ажлыг 11,0 сая төгрөгөөр “Номен” ХХК, 3 дугаар хорооны 2 дугаар байрны дээврийн засварын ажлыг 56.8 сая төгрөгөөр “Чойсамбуу” ХХК, 3 дугаар хорооны 29 дүгээр байрны фасад засварын ажлыг 56,7 сая төгрөгөөр “ЕВG minning concrete” ХХК, 6 дугаар хорооны 41 дүгээр байрны дулаалгатай фасад засварын ажлыг 49,7 сая төгрөгөөр “Ричи ойл” ХХК, 6 дугаар хорооны 34 дүгээр байрны дээврийн засварын ажлыг 58,9 сая төгрөгөөр “Хараатын тээл” ХХК тус тус гүйцэтгэсэн. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 21 дүгээр байрны сантехникийн шугамын засварын ажлыг “Өгөөмөр бурхант” ХХК, 4 дүгээр хорооны 11,18 дугаар байрнуудын цахилгааны шугамын засварын ажлыг “Цацрах хангай “ ХХК тус тус хийж байнгын ашиглалтад оруулсан.				100	100	
	3.1.5 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг шинээр нэмэгдүүлж,	1. Гэр хороод болон нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж, сайжруулна.	ТНААХ, НХОГ	Тавигдсан гэрэлтүүлгийн тоогоор	100%			
40		Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэхээр 12, 17 дугаар хороодын 224 ширхэг гэрэлтүүлгийн зураг төсвийг “Оргилт- Од” ХХК, 16, 19 дүгээр хороодын 515 ширхэг гэрэлтүүлгийн зургийг “Жэй				100	100	

	нэгдсэн удирдлага-хяналтын системд холбоно.	Ди Эй” ХХК, нийт 739 гэрэлтүүлгийн зураг төслийг хийж бэлэн болгосон. Чингэлтэй дүүргийн гэрэлтүүлгийн ашиглагч “Соёндрийм” ХХК 369 прожуктор гэрэлтүүлгийн шонд кранштейн болон шинээр 70 вт-ын гэрэлтүүлгийн толгой 132,2 сая төгрөгөөр, 13, 14, 15, 18 дугаар хороодод нөхөн суурьлуулалтын хүрээнд 100 гэрэлтүүлэг 128,6 сая төгрөгөөр, Чингэлтэй–Хайлааст холбосон авто замаас 16 дугаар хорооны байр хүртэлх зам дагуу 9 гэрэлтүүлэг болон 17 толгой 31,1 сая төгрөгөөр тус тус хийсэн бөгөөд нийт 386 толгой солих, 109 гэрэлтүүлэг шинээр хийж, нийт 291,1 сая төгрөгийн ажил хийж гүйцэтгэсэн. 2018 онд Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 2 байршилд 61 гэрэлтүүлэг 91,7 сая төгрөгөөр, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 3 байршилд 55 гэрэлтүүлэг 90,2 сая төгрөгөөр, дүүргийн төсвийн хөрөнгөөр 11 байршилд 298 гэрэлтүүлэг 452,1 сая төгрөгөөр нийт дүүргийн хэмжээнд 51 байршилд 693 гэрэлтүүлэг 1,1 тэрбум төгрөгөөр хийгдээд байна.					
3.2 ХОТ ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЭЦ							
41	3.2.1 Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, асфальт, бетонон болон байгалийн чулуун замуудаар гэр хорооллын гол гудамжнуудыг төв замтай холбож, олон чиглэлийн зам харилцааг хөгжүүлнэ.	1. Орон сууцны хороолол дундах авто замын шинэчлэл, засварын ажлыг үргэлжлүүлэн хийнэ	ТНААХ, НЗХГ	Авто замын урт, м	1000 м2		
		Орон сууцны хороолол дундах авто замын засварын ажлыг үргэлжлүүлэн хийхээр Нийслэлийн авто замын хөгжлийн газарт 3/322 тоот албан бичгээр нийт 1597м2 нөхөөсний судалгааг хүргүүлсний дагуу “Саруул харгуй” ХХК 1000м2 нөхөөс хийж гүйцэтгэсэн.	100	100			
		2. Гэр хорооллын гол гудамжнуудыг байгалийн чулуун, бетонон болон асфальтан авто замуудаар холбох, гол замаас сургууль, цэцэрлэг, хороод руу салсан замын ажлын зураг төслийг боловсруулж, ажлыг үргэлжлүүлнэ.	ТНААХ, НЗХГ	Зураг төсөв боловсруулах ажлын явц, хувиар	4км		
Гэр хорооллын гудамжинд авто зам барих зураг төслийн ажлын хүрээнд 12, 13, 14, 19 дүгээр хороодод нийт 5 байршилд зураг төсвийн ажлын зургийн даалгавар гаргуулан зураг төсөв хийлгүүлэхээр “Ихэр мөнх”, “Эм Эн Эс Жи” ХХК-иудтай гэрээ байгуулан магадлалын ерөнхий дүгнэлт хийлгүүлэн зураг төсөв хийж дууссан. 17 дугаар хороо 103 дугаар цэцэрлэг лүү явсан авто зам, Шар хагтын ам руу явсан авто зам, Сурагчийн 49 дүгээр гудамжны авто зам, зүрх уулын гудамжны авто замуудад “Ростов” ХХК зураг төсвийн ажил хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн хөрөнгөөр 7 дугаар хороо 224-р цэцэрлэг рүү явсан 1,2 км авто замын эхний шатны 0,7 км авто замыг “Наранбулаг” ХХК гүйцэтгэж, нийслэлийн Авто	100	100					

		<p>замын хөгжлийн газраас хяналт тавин ажиллаж, ашиглалтад оруулсан. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх эрх шилжиж ирсэн ажлын хүрээнд 13, 14, 15 дугаар хороодод Нийслэлийн авто замын хөгжлийн газар 3 байршилд тендер зарлан ажлыг хийж гүйцэтгэж байна. Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК дараах байршлуудад зам, замын байгууламжийн ажил хийж гүйцэтгэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> • 16 дугаар хорооноос Чингэлтэй-Хайлаастын авто замтай холбогдох 0,65 км авто замын ажил, 14 дүгээр гудамжны хуучин бетонон 127 у/м авто зам болон 16 дугаар хорооны байр луу явсан хуучин бетонон 130 у/м авто зам, нийт 257 у/м бетонон хучилт • 15 дугаар хороо Жаргалантын 34 дүгээр гудамжнаас 18 дугаар хорооны Яргайтын 16 дугаар гудамж хүртэлх 0,68 км авто замын ажлын хүрээнд 3900м2 асфальт, бетонон хучилт 975м2, эко хавтан 275,93м2, • 17 дугаар хороо Чингэлтэйн авто замаас 103 дугаар цэцэрлэг хүртэлх авто замын ажил 300м2 байгалийн чулуу, бетонон хучилт 50м2, асфальт 1301м2, замын тэмдэг тэмдэглэгээ 9 ширхэг, замын хашлага 647 ширхэг, замын L хашлага 25,5 ширхэг, • 14 дүгээр хороо Чандмань овооны тохижилт руу явсан замыг 298,2м2 эко хавтан, 169,9м2 байгалийн чулуун замаар, • 17 дугаар хороо Баянхайрханы 2 дугаар гудамж 541 дүгээр худаг хүртэлх байгалийн чулуун замыг 134м2 байгалийн чулуу, бетонон хучилт 1258м2, 169м2 эко хавтан тус тус хийж гүйцэтгээд байна. Мөн Камел дэлгүүрийн зүүн талд орц гарц сайжруулах ажлын хүрээнд 20у/м байгалийн чулуун зам, • 18 дугаар хороо Чингэлтэй хайлаастыг холбосон авто замаас 37 дугаар сургууль хүртэлх замын эхлэл 120 у/м замын ажилд бетонон хучилт 253м2, асфальтан хучилт 698м2, • 19 дүгээр хороо, Доод салхитын 6-10 дугаар гудамж дундах авто замыг асфальтан хучилт 877м2, бетонон хучилт 1430м2, эко хавтан 177м2 талбайд тус тус хийж гүйцэтгэсэн байна. <p>Чингэлтэйн авто зам дагуу 17 дугаар хорооны орчим, цэцэрлэг сургуулийн орчныг сайжруулах, аюулгүй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд авто замын хашлага шинэчлэх, явган зам, хамгаалалтын хайс, автобусны буудлын зогсоол, сүүдрэвч, хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ хийх ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 13, 14 дүгээр хороо Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын өргөн чөлөөтэй холбогдох 0,88 км авто замын гүйцэтгэгчээр “Төгс зам” ХХК шалгаран цахилгааны шугам</p>		
--	--	---	--	--

		шилжүүлэх, улаан шугам хүлээж авах, газар чөлөөлөх ажлуудыг хийж гүйцэтгэж байна.				
42	3.2.2 Сэлбэ дэд төвийн төслийг үргэлжлүүлэн хийж дуусгахад хамтран ажиллана.	1. Сэлбэ дэд төвийн хүрээнд Нийгмийн байгууламж барих ажлын газрын асуудлыг шийдвэрлүүлнэ.	НХХ, ТНААХ, ХБТХАХ, ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	50%	
		"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн 1 дүгээр үе шатанд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих "Сэлбэ дэд төв"-ийн хүрээнд хийгдэж буй газар чөлөөлөлтийн ажилд Төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна. 09 дүгээр сарын 18-ний өдрийн байдлаар нийгмийн байгууламжийн трасст орсон 19 айлын газрыг 100% нөхөх олговортойгоор чөлөөлүүлсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Цаст констракшн" ХХК шалгарч, зөвлөмжийг Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн.			100	100
43	3.2.3 Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй бүх өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хийнэ.	1. Айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангах, хүчдэлийг сайжруулах, дэд станц, шугамын өргөтгөл шинэчлэлийг үе шаттай хийхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	ТНААХ, УБЦТС ХК	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	50%	
		Улсын төсвийн хөрөнгөөр Эрчим хүчний сайдын багц ажлын хүрээнд Нийслэлийн 5 дүүргийн 32 багц 1,6 тэрбумын санхүүжилттэй ажлаас Чингэлтэй дүүргийн 12-19 дүгээр хорооны 13 байршилд цахилгааны хүчдэл нэмэгдүүлэх багц ажлууд зарлагдан гүйцэтгэгч 7 компани шалгарч, хяналтыг Эрчим хүчний үндэсний төвөөс тавин, байнгын хүлээн авах улсын комисс ажиллаж хүлээн авсан.			100	100
44	3.2.4 Гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган шат, гүүр, ус түгээх байр барьж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	1. Гэр хороодод батлагдсан зураг төсвийн хүрээнд хөрөнгө оруулалтын ажлыг иргэдийн бүлгийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	ТНААХ, Хороод	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх иргэдийн бүлгийн ажлын 9 хорооны 13 байршилд зураг, ажлын тоо хэмжээ гарч гүйцэтгэл хийгдэж дуусан, комисс ажиллан хүлээн авсан.			100	100
		2. Хүн амыг баталгаат ундны усаар хангах, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдалд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж ажиллана.	ТНААХ, УСУГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	

		Хүн амыг баталгаат ундны усаар хангах, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдлыг хангах хүрээнд Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 19 дүгээр хорооны гүний худгийн гүйцэтгэгчээр “Оргилон дэлгэрэх” ХХК ажиллаж бүрэн ашиглалтад оруулсан. 17 дугаар хороо Баянхайрханы 7 дугаар гудамжинд гүний худаг гүйцэтгэгчээр “Уотер голд дриллинг” ХХК, 15 дугаар хороо овооны тохижилтын гүний худаг гүйцэтгэгчээр “БИММ” ХХК, 12 дугаар хороо Булгийн 15 дугаар гудамжинд гүний худаг гүйцэтгэгчээр “Топ дриллэнг” ХХК, 17 дугаар хороо Олон булагтай цэцэрлэгт хүрээлэнгийн орчим шугамын ус түгээх байрны гүйцэтгэгчээр “Шахайт ундарга” ХХК, Нийслэлийн хөрөнгөөр 12 дугаар хороо Булгийн 19 дүгээр гудамжинд зөөврийн ус түгээх байрны гүйцэтгэгчээр “Ахра” ХХК, 16 дугаар хороо согоотын 59а зөөврийн ус түгээх байр буюу 5 хороонд 7 байршилд ус түгээх байр шинээр баригдаж комисс ажиллан байнгын ашиглалтад оруулсан.			100	100
45	3.2.5 Иргэдийн эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн шинэ чиглэл бий болгох ажлыг дэмжин хамтран ажиллана.	1. Алслагдсан гэр хороодын нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх, чиглэл маршрутыг уртасгах ажлыг иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан холбогдох байгууллагад уламжлан, хамтран ажиллана.	ТНААХ, НТГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	50%	
		Нийтийн тээврийн эцсийн болон дундын зогсоолын тохижилт, орчин сайжруулах зорилгоор Нийслэлийн тээврийн газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Жэ Си Дэко ХХК байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд 2018 онд хэрэгжүүлэх жишиг автобусны буудлын саравч хийх ажлын төлөвлөгөөнд дүүргийн хэмжээнд 11 дүгээр хороо Чингэлтэйн өргөн чөлөө, 32-р тойргийн буудал, 14 дүгээр хороо Чингэлтэйн өргөн чөлөө, 5-н буудал, 19 дүгээр хороо Зуслангийн зам, Ар согоотын буудал, 19 дүгээр хороо Зуслангийн зам, Зунжин буудал зэрэг байршилд олон улсын стандартад нийцсэн жишиг буудлын саравчны угсралтыг хийж гүйцэтгэсэн. Мөн дүүргийн төсвийн хөрөнгөөр нутаг дэвсгэрийн хэмжээнд 6 чиглэлд 88 дундын болон эцсийн зогсоол байдгаас шаардлагатай байршлуудад саравч хийхээр зураг төсөв гарган байршлын судалгаа хийгдэж 4 байршилд буюу 17 хороонд 1 ширхэг, 12 дугаар хороонд 2 ширхэг, 19 дүгээр хороонд 1 ширхэг саравч байрлуулан хүлээн авсан.			100	100
4. ЖАРГАЛТАЙ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ						
4.1 БАЙГАЛЬ ОРЧИН						
46	4.1.1 Ногоон хөгжлийг	1. Агаар, хөрсний тоосжилтыг бууруулах	ТНААХ,	Зүлэгжүүлж,	37000 м2	

дэмжих замаар “Ногоон дүүрэг” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгоно.	ТҮК	хатуу хучилттай болгосон талбай м2-аар		
	Агаар, хөрсний тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг хатуу хучилттай болгох ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн “Тохижилт Үйлчилгээ” ХХК-тай хамтран 1 хороо 1, 3 дугаар байранд 819,5 м2 явган зам, 13 дугаар байранд 14,3 м2 явган зам, 18 дугаар байранд 30м2 явган зам, 19 дүгээр байранд 327,3 м2 явган зам, 18, 19, 36, 37 дугаар байрнуудын дунд 55,6м2 явган зам, 4 дүгээр хороо Анкарагийн гудамжинд байгалийн чулуун хучилт 148м2 тус тус хийгдсэн. Дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 5 дугаар хорооны явган хүний замын ажил 312м2 явган зам, 7 дугаар хороо Хувьсгалчдын Г-ийн 12, 13 дугаар гудамжинд м2 явган зам, 9 дүгээр хороо Дэнжийн 45 дугаар гудамжинд 128м2 явган зам, 171м2 эко хавтан, 17 дугаар хороо Сурагчийн 62 дугаар гудамжинд 94м2 явган зам тус тус хийгдсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 37660м2, Дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 1289,7м2, Нийслэлийн хөрөнгөөр 7520 м2 талбай нийт 14-н хороонд 51 байршилд 46376,4 м2 талбайг хатуу хучилттай болгосон. Үүнээс явган замын хавтан 13022м2, бетонон зам 6026м2, эко хавтан 4432,2м2, асфальтан хучилт 20733,9м2, байгалийн чулуу 2161,9м2 тус тус хийж гүйцэтгээд байна. Дүүргийн Анкарагийн гудамж /Байгалийн чулуун суурийн завсраар/ 80м2 зүлэг шинээр, 1-р хороо 7,8,9,10,18,19,36,37,38-р байр, 3-р хороо 5,6 байр, 4-р хороо Эрдэнэсийн арал, 6-р хорооны 26-р байрны урд талын орон сууцны хорооллын дундах бичил цэцэрлэгүүдэд 2260 м2 зүлэг нөхөн тарилт, 18-р хороо Хайлааст Чингэлтэйг холбосон замын хажуугийн Булгийн тохижилтын ажлын хүрээнд шинээр 250м2 зүлэг, нийт 2590 м2 талбайд шинээр болон нөхөн тарилт хийсэн.			100	100
	2. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэнд орчин үеийн шийдэлтэй мод бут ургуулж, арчлах, хэлбэржүүлэх ажлуудыг үргэлжлүүлнэ.	ТНААХ, ТҮК	Таригдсан мод, бутны тоогоор	100%	
Дүүргийн нийтийн эзэмшлийн болон орон сууцны хорооллын дундах бичил цэцэрлэгийн 116430м2 /давхардсан тоогоор/ зүлэгт талбайн цэвэрлэгээний ажлыг дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК-ийн ажилтнууд гүйцэтгэсэн байна. Самбуугийн гудамжинд 140ш мод, 4-р хороо Эрдэнэсийн арал бичил цэцэрлэгт 8ш				100	100

	<p>мод, Цаг уур орчны шинжилгээний газрын гадна 3ш мод, Б-8 СӨХ-ийн гадна 7ш мод, Дүүргийн эмнэлэгт 20ш мод, Анкарагийн гудамжинд 44ш мод, 5-р хороо 15, 16, 57 дугаар байрны баавгайтай цэцэрлэгт 21ш мод шохойдох, нийт 178 ш модны хэлбэржүүлэх ажилбар хийгдсэн. Нийтийн эзэмшлийн болон орон сууцны хорооллын дундах бичил цэцэрлэгийн усалгааны ажил хуваарийн дагуу хийгдэж байгаа бөгөөд нийт 2210 тонн ус зарцуулаад байна.</p> <p>Том оврын 247 ширхэг нарс модны усалгааны ажил хуваарийн дагуу хийгдэж байна. Самбуугийн гудамжны ургамлан хашлаганд 5400 ш хайлаас нөхөн, 300 ш сөөг шинээр тарьсан /голт бор, монос, гүйлс/, 1148 у/м ургамлан хашлага тайрч тэгшилж, хэлбэржүүлж, 8460м² зүлэгт талбайг бууцаар бордож, 13214ш мод, сөөгийг бордоожуулж услав. Жуулчны гудамжинд 160 ш сөөг шинээр тарьсан. Анкарагийн гудамжны 3245м² талбайн зүлэг тайралт машинаар тайрч тэгшлэв. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, “Өрхийн хөгжлийг дэмжих жил”, “Ногоон дүүрэг-Бидний оролцоо 2018” бүх нийтийн аяны хүрээнд 5 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад, хороодын ажлын алба болон төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэг, сургуульд 4000 гаруй ш мод, 152 ш бут сөөг зэргийг тарьсан. Уг арга хэмжээнд дүүргийн 36 байгууллагын 480 гаруй хүн оролцсон байна. Швейцарын хөгжлийн агентлагийн "Иргэдийн оролцоо II" төслийн хүрээнд 2018 оны 05 дугаар сарын 19-нд Шар хагтын аманд 300ш шинэс мод тарьсан. Дүүргийн 19-р хороо Чингэлтэйн Дээд салхит “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн”-д шинэс мод 200 ш тарилт хийгдсэн. Анкарагийн гудамжинд 1200 ширхэг буйлс тарих, хайлаас 2200 ш тарилтын ажил хийгдсэн. Самбуугийн гудамжинд гоёл чимэглэлийн 100 гаруй голт бор, монос тарилтын ажил хийгдсэн. Дүүргийн 17 дугаар хороо Олон булагтайн цэцэрлэгт хүрээлэнд хус 7 ш, гоёлын чиглэлээр буйлс, гүйлс 50 ш, голт бор 120 ш тарилт хийсэн. 2-р хороо 21, 22, 23 байрны дундах бичил цэцэрлэг монос 35ш, голт бор 40ш, хус 29ш, 3-р хороо 10, 11 байрны дундах бичил цэцэрлэг монос 6ш, голт бор 10ш, 3-р хороо 1,2,8,9-р байрны дундах бичил цэцэрлэгт монос 15ш, голт бор 15 ш тарилт хийсэн. Дүүргийн 17 дугаар хорооны Олон булагтайн цэцэрлэгт хүрээлэнд 18 ш улиас, 2 ш бургас, голт бор 150 ш, хус 10 ш, үхрийн нүд 50 ш тарьсан. 18-р хороо Булгийн эхийг хамгаалах ажлын хүрээнд 6ш улиас мод, шинэс мод 18ш, хайлаас 500ш, буйлс, гүйлс 315ш, шар хуайс 900ш тарьсан.</p> <p>2018 оны 03 дугаар улирлын байдлаар дүүргийн хэмжээнд 7796 гаруй ш мод, 1697 ш бут сөөг таригдсан.</p>		
--	---	--	--

		3. Байгаль хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт, сурталчилгаа явуулна.	ТНААХ, НЗАА, НБОГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			
		Хаврын "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан 14 дүгээр хорооны "Иргэний танхим"-д дүүргийн Засаг даргын Тамгын газар, ШУА-ийн Газар зүй-Геоэкологийн хүрээлэнтэй хамтран "Мод, бут сөөг тарих, арчлах" сэдэвт сургалтыг зохион байгуулж, дүүргийн 1-19 дүгээр хороодын иргэн, ААНБ-ын төлөөлөл 45 хүн сургалтад хамрагдсан. Швейцарын хөгжлийн агентлагийн "Иргэдийн оролцоо II" төслийн хүрээнд 2018 оны 05 дугаар сарын 05-аас 06-ны өдрүүдэд "Мод тарих, ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа ба иргэдийн оролцоо" сэдэвт сургалтыг зохион байгуулж 3, 17 дугаар хорооны 25 иргэн хамрагдсан. Агаар хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг хангах, мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, газар тариалан, мод үржүүлгийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих дүүргийн Засаг даргын 2018 оны А/251 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн 4-р дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Барилгачдын талбайд үзэсгэлэн зохион байгуулж 15 иргэн, аж ахуйн нэгж байгууллага оролцсон. АДРА ОУБ-ын "Тогтвортой тариалан" төсөлд хамрагддаг дүүргийн 12 иргэн үр үрслэгээний суулгац худалдаалсан.				100	100	
47	4.1.2 Аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Олимп хотхоныг байгуулна.	1. Чингэлтэй хайрхан руу чиглэсэн аяллын маршрут гарган өвөл зуны туршид амрах, үдлэх тохижсон цэгүүдийг бий болгон иргэд, жуулчлалд зориулсан бүсийг үе шаттай байгуулна.	ТНААХ, НЗАА, НБОГ	Гүйцэтгэлээр	30%			
		Чингэлтэй хайрхан уул орчмын улсын тусгай хамгаалалтын хашаажуулалтын ажлын гүйцэтгэгчээр "Бодь хангай" ХХК ажиллаж, нийт 190 ш хашаа /196 ш шон/ суулгаж дуусгасан бөгөөд комисс ажиллан хүлээж авсан.					100	100
		2. Аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Спорт цогцолборын ажлыг үргэлжлүүлнэ.	ТНААХ, НЗАА, НБОГ	Гүйцэтгэлээр	50%			
		Улсын төсвийн хөрөнгөөр дээд салхитын амны Соёл, спорт, амралт, аялал жуулчлалын барилгын ажлын гүйцэтгэгчээр Эко тогтол ХХК шалгарч, ажлыг эхлүүлсэн. Мөн улсын төсвийн хөрөнгөөр Олон улсын жишигт нийцсэн задгай хөл					70	70

		бөмбөгийн талбайн ажил эхэлсэн.					
48	4.1.3 Ногоон байгууламж, тохижилт бүхий "Эрдмийн цэцэрлэгт байгуулна. хүрээлэн"	1. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлуудыг үргэлжлүүлэн хийнэ.	ТНААХ, НЗАА, НБОГ, ТҮК	Таригдсан мод, нөхөн сэргээлтийн хувиар	50%		
		Дүүргийн 19-р хороо Чингэлтэйн Дээд салхит "Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн"-д шинэс мод 200 ш тарилт хийгдсэн. Усалгааны нөөцийн сав 1ш /10 тонн/, усжуулалтын систем 150 м суурилуулсан. 17-р хороо Шар хагтын аманд усны нөөцийн сав 2ш /1 тонн/, насос, 100 м услалтын хоолой суурилуулсан. Швейцарын хөгжлийн агентлагийн "Иргэдийн оролцоо II" төслийн хүрээнд 2018 оны 05 дугаар сарын 19-нд Шар хагтын аманд 300ш шинэс мод тарьсан.				100	100
4.2 ХОГ ХАЯГДАЛ, АГААР, ХӨРСНИЙ БОХИРДОЛ							
49	4.2.1 Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилал, боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлнэ.	1. Хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, чанарт хяналт тавьж ажиллана.	ТНААХ, ТҮК, Найши трейд	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдлын чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК, "Найши трейд" ХХК-ний 2017 оны Засаг даргын Тамгын газартай байгуулсан "Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх гэрээ"-г "БҮРЭН ХАНГАЛТТАЙ" үнэлэн гэрээг шинэчлэн байгуулж 2018 онд "Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх гэрээ"-г сунган ажиллаж байна. Мөн хог хаягдлын чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээт "Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хөгжлийн хүрээлэн" ТББ болон гэрэлтүүлэг хог хаягдлын чиглэлээр "Урагш дэвших холбоо" ТББ-ууд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн 1-19 дүгээр хорооны айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлыг цуглуулж тээвэрлэхэд Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК, "Найши трейд" ХХК 40 орчим техник, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр ханган тогтмол ачиж тээвэрлэн 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 23000 гаруй рейсээр 120000 гаруй тонн хог хаягдлыг устгалд оруулан төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны "Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай" А/14 дугаар захирамж, батлуулан батлагдсан хуваарийн дагуу цэвэрлэгээний ажил зохион байгуулагдан ажиллаж байна. Батлагдсан хуваарийн дагуу 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулсан бөгөөд дүүргийн хог хаягдлын				100	100

		үйлчилгээний байгууллагууд хамтран ажиллах гэрээний үүргийн дагуу хог цэвэрлэгээний иргэдийн бүлгийг ажиллуулж борооны ус зайлуулах шугам сүлжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн арчлалт, хамгаалалт, цэвэрлэгээг тогтмол хийлгэж хяналт тавин ажилласан. Дээрх цэвэрлэгээний ажилд давхардсан тоогоор 5000 гаруй хүн цэвэрлэгээний ажилд хамрагдан нийт 1085,311 м2 талбайд цэвэрлэгээ хийгдэн, дээрх цэвэрлэгээгээр дүүргийн хог тээвэрлэгч байгууллагууд 600 гаруй тн хог хаягдал цас мөсийг 180 гаруй рейс хийн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэн ажилласан.					
		2. Гэр хорооллын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэвэрлэгээний ажилд иргэдийн бүлгийг татан оролцуулж, тэдний үйл ажиллагааг тогтмолжуулна.	ТНААХ, ТҮК, Найши трейд	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/76 тоот тушаалаар Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК 7-16 дугаар хороо буюу 2 дугаар бүсэд 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 3 бүлэг, “Найши трейд” ХХК 3 дугаар бүс болох 17-19 дүгээр хороонд 15 хүний бүрэлдэхүүнтэй 3 бүлгийг тогтмол ажиллуулан хэвшээд байна. Чингэлтэй дүүргийн гэр хорооллын 7-19 хороонд 2 компанийн нийт иргэдийн бүлгийн 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлэг 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар түүвэр цэвэрлэгээг хийж гүйцэтгэж байна. Цэвэрлэгээний явцад гэр хорооллын гуу жалга, далан сувгийн лаг, үүсмэл хог хаягдлын цэвэрлэгээг хийн ажиллаж байна. 2018 оны гуравдугаар улирлын байдлаар цэвэрлэгээний явцад нийт 502872 м2 талбайн 701,15 тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан цэвэрлэж ачиж тээвэрлэсэн. Чингэлтэй дүүргийн хэмжээнд ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх зорилготой “Харшлын эсрэг хамтдаа” уриатай “Шарилжгүй Улаанбаатар-3” аяны хугацаанд нийт давхардсан тоогоор 608 байгууллага, 5952 хүн 700559 м2 талбайн хөл газрын ургамал /шарилж/-ыг тайрах, хадах ажлыг гүйцэтгэн 879,7 тонн шарилжийг хогийн төвлөрсөн цэгт ачиж, тээвэрлэн ажилласан.			100	100	
50	4.2.2 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. Сэргээгдэх эрчим хүчээр хангах төслүүдийг хэрэгжүүлнэ.	ТНААХ, ХБТХАХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	50%		
		Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хүрээнд Самбуугийн гудамжны ногоон байгууламжит талбай, гэр хорооллын өндөрлөг байршлууд, өндрийн шугамын доогуур туршилтаар 54 гэрэлтүүлэг хийгдсэн. Энэ ажлыг үргэлжлүүлэн			100	100	

		<p>Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийг нарны зайн гэрэлтүүлгээр солихоор судалгаа тооцооны ажил хийгдэж байна. Мөн бичил цэцэрлэгүүдийн тохижилтын ажлын хүрээнд 10 ш нарны зайн гэрэлтүүлэг 3, 12, 14, 13, 15-р хороодод байршуулаад байна.</p>				
	<p>2. Дулаалгын аян өрнүүлж, түүхий нүүрсний хэрэглээг багасгах дулаан баригчаар хангах, түүний хэрэглээг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэдтэй хамтран ажиллана.</p>	<p>ТНААХ, МХХ, НАЧА</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>50%</p>		
		<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 05/1349 тоот албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сар бүрийн 20-ны дотор хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 3/790 тоот албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын “Түүхий нүүрсийг хориглох тухай” 2018 оны 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг албан бичгээр болон hakuho1900@gmail.com цахим хаягаар Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газарт хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/764 тоот “Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамжийн хүрээнд дүүргийн гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах, утааг багасгах, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах зорилгоор “ДУЛААЛГЫН АЯН” болзолт уралдааныг 7-19 дүгээр хороодын дунд зохион байгуулсан. Энэхүү болзолт уралдаанд бусдыгаа манлайлагч хороодоор 16 дугаар хороо, 15 дугаар хороо, 11 дүгээр хороо тус тус шалгарч “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнагдсан ба 26 хэсгийн ахлагч нар болон иргэний үүргээ биелүүлж, өөрийн санаачилгаар утаагүй орчинд амьдрах нөхцөлөө бүрдүүлж, халаалт, дулаанаа цахилгаанаар, шалны халаалтаар, ЭКО тулга болон бусад орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийг авч хэрэглэж, агаарын бохирдлыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулсан нийт 26 иргэнийг "Өргөмжлөл", мөнгөн шагналаар шагналаа. Аяны хүрээнд дүүргийн 7-19 дүгээр хороодод нэг, нэг айл өрхийн амины сууцыг дулаалж, нийт 13 “Загвар өрх”-ийг бий болгосон ба хороодын Ажлын алба нийт 5508 иргэнд “Загвар өрх”-ийн талаар мэдээлэл хүргэн сурталчлан ажиллаж, 184 өрх гэр, амины сууцны халаалтаа цахилгаанаар шийдэж, 155 өрх шинээр шөнийн цахилгааны хөнгөлөлтөд</p>			<p>100</p>	<p>100</p>

	<p>хамрагдсан байна. Мөн 9 дүгээр хорооны нэг өрх аяны хүрээнд утаа гаргахгүй яндангүй болж, дулаанаа иж бүрэн цахилгаанаар шийдсэн. Улаанбаатар Цэвэр агаар төслөөс дүүргийн 7-р хорооны иргэдэд байшингаа дулаалсны үр дүн, ач холбогдлыг мэдээлэх уулзалт зохион байгуулсан ба дэд бүтцийн төв (Service center) төсөлд хамрагдаж, цэвэр бохир усны асуудлаа шийдэж байгаа 194 өрхийн төлөөлөл оролцсон. Дүүргийн 7-р хорооны гадаа талбай болон иргэний танхимд “Дулаалга аян-2”-ын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, дулаалгын материал тус бүрийг танилцуулж, гэрээ хийхэд бүрдүүлэх материал, эко зээл авах зөвлөмж, хэрхэн яаж дулаалах зөвлөгөө, дулаалгын ажлын туршлагыг танилцуулсан бөгөөд нийт 70 гаруй өрхүүд хамрагдсан. 7-р хорооны “Дэд бүтцийн төв” барих хэсгийн айл өрхүүдээс “Дулаалга аян-2”-т оролцох хүсэлтээ илэрхийлж, бүртгүүлсэн 81 өрх байгаагаас гэрээ байгуулаагүй 45 өрх, гэрээ байгуулсан төлбөрөө төлөөгүй 15 өрх, гэрээ байгуулж төлбөрөө төлж 21 өрх дулаалга хийлгээд байна. Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал захирамж А/04-А/19, Нийслэлийн Засаг даргын А/17 тоот захирамж, НМХГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд дүүргийн 1-18 хороонд 23 улсын /ахлах/ байцаагч нар хяналт тавьж нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 1592 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зурагт хуудас, мэдэгдэх хуудас тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Тус ажлын хүрээнд 1-19 дүгээр хорооны 19 Засаг дарга, 160 хэсгийн ахлагч, 950 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Агаарын бохирдлыг бууруулахад Таны оролцоо”, түүнд хяналт тавих салбарын сургалтыг тус тус зохион байгуулж, 9 телевизэд 3 удаагийн давтамжтай сэрэмжлүүлэг болон хийж байгаа ажлаа сурталчилсан. Зөрчил арилгуулах улсын ахлах байцаагчийн “Агаарын бохирдол, хөрсний бохирдлыг бууруулах, гадна өнгө үзэмжээ сайжруулах” зэрэг 5 заалт бүхий албан шаардлага 220, дүгнэлт 4, акт 7 гаргаж, торгууль 1440,0 ногдуулсан байна. Шалгалтын үр дүнд: 191 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цахилгаанд, хэсгийн халаалтад 8, төвлөрсөн шугамд 12 байгууллагыг холбуулсан. 12 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн зуухаа авч сайжруулсан зуухаар сольсон байна. Мөн дүүргийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хорооны хуучин 190 м2 5 өрөө барилгыг “Агаарын бохирдлыг бууруулах мэдээллийн нэгдсэн төв” болгон засварлаж, ашиглалтад оруулсан. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/398 дугаар захирамж, Бага, дунд оврын халаалтын зуухны байгууламжийн дахин бүртгэл тооллого явуулах удирдамжийн хүрээнд дүүргийн хэмжээнд 15-100 кВт /125м2-1000м2 талбайтай байшин халаах хүчин чадалтай/-ын зуухны судалгааг гарган ажиллаж байна.</p>		
--	--	--	--

5. ЖАРГАЛТАЙ ИРГЭН-НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ

5.1 НУТГИЙН УДИРДЛАГА

51	<p>5.1.1 Төрийн албан хаагчдын ажлын үр дүн, хариуцлага тооцох системийг оновчтой хэрэгжүүлж, тэдний ажиллах таатай орчинг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилгоор дүүргийн “Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>1. Ажилтан албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулна.</p>	ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		<p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан “Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-н хүрээнд 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу ажилтан албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан урт болон богино хугацааны мэргэшүүлэх сургалтад хамруулан ажиллаж байна. Тайлант хугацаанд дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, хороодын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа төрийн жинхэнэ албан тушаалд орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэлтэй иргэдээс сонгон шалгаруулан Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд нэр дэвшүүлж, дүгнэлтийн дагуу 10 албан хаагчийг томилж, сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгууллаа. Албан хаагчдын ур чадвар, үйл ажиллагааны үр дүнг харгалзан шатлан дэвших бодлого баримтлан ажиллаж ирсэн бөгөөд 2018 онд 1 албан хаагчийг дэвшүүлэн томилсон.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 1999 оны “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр” батлах тухай 96 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газар болон хороодын ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор 2018 оны эхний хагас жилийн байдлаар дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх, сургах, хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад 5 албан хаагч Төрийн удирдлагын мэргэшүүлэх чиглэлээр суралцаж байгаагаас Засгийн газрын тэтгэлгээр 2 албан хаагч хамрагдан суралцаж байна. Мөн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан тусгай шаардлагын дагуу бакалаврын зэргийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж суралцаж төгссөн. Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын хүрээнд Монголын Үндэсний их сургуультай санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулан мэргэжил</p>				100	100

	<p>дээшлүүлэх Магистр, докторын зэргийн сургалт мөн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдэд хөнгөлөлттэй сургах боломжийг бүрдүүлэн ажиллалаа. “Мэдээллийн цаг сургалт”-ыг 12 удаа зохион байгуулж сургалтад давхардсан тоогоор 800 гаруй албан хаагч хамрагдсан. Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар Төрийн албаны зөвлөл, Монголын нутгийн удирдлагын холбоо, Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн ЗДТГ-н Хууль, эрх зүйн тасаг зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран үе шаттайгаар зохион байгуулж давхардсан тоогоор 150 төрийн албан хаагч 7 удаагийн сургалтад хамрагдсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн ашиг албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан “Авлигын эсрэг сургалт”-нд Тамгын газар, хороодын нийт 76 албан хаагчдыг хамруулсан. ЗДТГ болон хороодод шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтад нийт 11 албан хаагч оролцож, дүүргийн үүсэл хөгжил, түүхэн замнал, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөр, бүтэц, зохион байгуулалт болон холбогдох дүрэм, журмыг танилцуулах, хүний нөөцийн бодлогын ил тод нээлттэй байдлыг хангах, ажиллах чадварыг өндөржүүлэх, хамт олныг төлөвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, мөн чанар мөн захирамжлалын баримт бичиг боловсруулалт, хяналт шинжилгээ үнэлгээ, архив албан хэрэг хөтлөлт зэрэг сэдвүүдээр сургалт хийж албан хаагчдад ажлын үнэмлэх олгон ажилласан. Албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоогоор хангаж шаардлагатай техник хэрэгсэл, албан ажлын хувцсаар жигдрүүлэх ажил хэрэгжүүлэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-н дагуу Тамгын газрын 65, хороодын 59 нийт 124 албан хаагчдыг албаны хувцсаар жигдрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалт, Засгийн газрын 2004 оны “Журам батлах тухай 112 дугаар тогтоол, байгууллагын дотоод журмын хүрээнд Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан албан хаагчдын гэр бүл, төрөл садны хүн нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнийг нь тэтгэхэд 11 албан хаагчид 11.320.000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Төрийн албан хаагчийн эхнэр нь амаржсан болон өөрөө амаржсан 4 албан хаагчдад нийт 2.176.448 төгрөгийн тусламж олгосон. Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, өвчлөлтийг эрт илрүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдыг томуу, томуу туст өвчний вакцинжуулалт, витаминжуулалт, элэгний Б, Ц вирусийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор</p>		
--	--	--	--

		<p>490 гаруй албан хаагчид хамрагдсан. Дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран сүрьеэ, ХДХВ, ДОХ, БЗДХ-ын үзлэг оношилгоонд нийт албан хаагчдыг хамруулах ажлыг 2018 оны 9 дүгээр сард зохион байгуулсан. Нийт дүүрэг, хорооны 95 албан хаагч хамрагдсан. Дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Тамгын нийт албан хаагчдын дунд 4 төрөлт уралдаан, тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 03-ны өдөр, хороодын албан хаагчдын тэмцээнийг 2018 оны 06 дугаар сарын 09-ны өдөр тус тус зохион байгуулсан. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр “Бүрэн хангалттай” үнэлэгдсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай нийслэлийн 8 дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид танилцаж туршлага солилцох үйл ажиллагааг 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, нийт 50 төрийн захиргааны албан хаагчид оролцсон.</p>					
		<p>2. Хороодын үйл ажиллагааг бэхжүүлж, бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.</p>	<p>ТЗУХ, СТСХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>		
		<p>Тайлант хугацаанд хороодын үйл ажиллагааг бэхжүүлж, бие даасан байдлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой өдөрлөгийн арга хэмжээг 1-19 хороодод-60, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилготой спорт тэмцээн уралдаан-43, Иргэд рүү чиглэсэн бүх төрлийн сургалт, зөвлөгөөн-171, нийтийг хамарсан арга хэмжээ-57 тус тус зохион байгуулсан. Мөн дүүргийн 1-19 дүгээр хорооны хэсгийн ахлагч нарын зөвлөгөөнийг 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж 196 хэсгийн ахлагч оролцсон. Хороодын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сар бүр 500.000 төгрөг зарцуулах эрхийг олгож, тогтмол түргэн шуурхай зохион байгуулан ажиллалаа.</p>			<p>100</p>	<p>100</p>	
		<p>3. Байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах хүрээнд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэнэ.</p>	<p>ТЗУХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>		
		<p>Төр захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлж буй төрийн алба, ажил үйлчилгээний талаар иргэдээс санал, хүсэлтийг авч бодлогын баримт, бичигт нийцүүлэн тусгаж хэрэгжүүлэхээр гуравдугаар улирлын байдлаар судалгааг</p>			<p>100</p>	<p>100</p>	

		дүүргийн Засаг даргын Тамгын газраар үйлчлүүлсэн болон “Нэг цэг”-ээр үйлчлүүлсэн иргэдээс авч нэгтгэн дүгнэлээ. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд иргэдийн сэтгэл ханамж ямар байгааг тодорхойлохоор авсан судалгаанд 500 иргэн хамрагдаж давхардсан тоогоор 3500 асуулгад өөрийн санал дүгнэлтээ өгчээ. Үүнд: Сайн үнэлгээ -1957, Дунд үнэлгээ – 860, Муу үнэлгээ – 323, Мэдэхгүй – 371 гэсэн үнэлгээг өгсөн байна.				
		Төрийн албан хаагчдын баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана.	ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд хороодын төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбогдолтой 4 удаагийн гомдол ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Төрийн албан хаагчийн “Эрхэмлэх есөн зүйл”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж тайлант хугацаанд ёс зүйн ноцтой зөрчил гаргасан ажилтан, албан хаагч байхгүй бөгөөд тайлант хугацаанд байгууллагын удирдлагын шийдвэрээр албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулаагүй байна. Дүүргийн ёс зүйн хороо 4 удаа хуралдаж байгууллагын удирдлагын шийдвэрээр 4 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэл ногдуулсан ба 1 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлсөн.			70	70
52	5.1.2 Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй, ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.	1. Нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллана.	ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
		Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Стар телевиз, UBS телевиз, www.zaluu.com , Нийслэлийн сэтгүүлчдийн холбоотой тус тус хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд дүүргийн цахим хуудсаар нийт 93 мэдээ, мэдээлэл, Стар телевиз 6, UBS телевизээр 5, цахим сайтуудаар нийт 104 мэдээ, мэдээлэл дамжуулан иргэд олон нийтэд хүргэн ажилласан.			100	100

		2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг үйл ажиллагааны гарын авлага, ном товхимлыг хэвлүүлж тараана.	ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчдад зориулсан сургалт зохион байгуулж дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын дарга нар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 21 албан тушаалтан хамрагдлаа. Сургалтаар мэдүүлэг гаргагч албан тушаалтны эрх, үүрэг, хариуцлага, ХАСХОМ мэдүүлэх, ХАСУМ гаргах талаар мэдээлэл өгсөн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 бүлэг 60 заалтаар боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6 зорилт хагас жилийн байдлаар 71.08%-тай биеллээ. Албан тушаалтнуудтай холбоотой 5 өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухайд мониторинг хийж ажилласан. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын хор уршиг, авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд таниулах, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 19 хорооноос Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2018 онд 5 удаагийн хууль зүйн зөвлөгөө өгч, 8 удаагийн сургалт зохион байгуулж 266 иргэн, 75 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан. Сургалтын үеэр Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн төвийн үйл ажиллагааны чиг үүрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хялбаржуулсан гарын авлагыг түгээж, иргэдтэй чөлөөт ярилцлага хэлбэрээр мэдээлэл хүргэн ажилласан байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор АТГ-с зохион байгуулсан сургалтад 111 удирдах албан тушаалтан болон мэргэжилтнүүд, Хороодын засаг дарга нар хамрагдсан. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор хөнөөлийг таниулах, шударга ёсыг төлөвшүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагаанд сурагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 49, 72 дугаар сургуулийн сурагчдын дунд “ Авлигагүй орчин-Миний ирээдүй ” эссэ бичлэг, гар зургийн уралдааныг зохион байгуулсан. Эссэ бичлэгийн уралдаанд 11 хүүхэд, гар зургийн уралдаанд 7 хүүхэд материал ирүүлж шилдэг эссе, гар зургийг			100	100	

	шалгаруулан, гар зургийн уралдаанд шалгарсан материалаар зурагт хуудас хэвлүүлэн тараахаар бэлтгэл ажлыг ханган, хэвлүүлэх компанийг сонгон шалгаруулсан.				
	3. Нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлаар ном, товхимол, гарын авлага хэвлүүлэн иргэдэд ажлаа тайлагнана.	ТЗУХ	Хэвлүүлсэн ном, гарын авлагын тоогоор	100%	
	Нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд Дүүргийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Чингэлтэй дүүргийн танилцуулга, “Чингэлтэй Фестиваль”, 25 жилийн ойн альбом, “Смарт чингэлтэй” гар утасны аппликейшны танилцуулга гарын авлага зэрэг ном, товхимлыг хэвлүүлэн иргэд, төрийн байгууллагуудад тарааж, нутгийн захиргааны байгууллагаас хийж хэрэгжүүлсэн ажлаа танилцуулсан. Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлуудаар видео танилцуулга хийж дүүргийн 15000 ахмадууд танилцуулсан.				100 100
	4. Нийслэлийн Архивын Газартай байгуулсан “Санамж бичиг”-ийн дагуу архивын нөхөн бүрдүүлэлт хийнэ.	ТЗУХ, НАГ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
	Нийслэлийн Архивын Газартай байгуулсан “Санамж бичиг”-ийн дагуу дараах 4 чиглэлээр архивын нөхөн бүрдүүлэлт хийж ажиллалаа. 2018 онд Архивын нөхөн бүрдүүлэлт хийх 41 байгууллага байгаагаас 16 байгууллага нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хийж, 2321 хадгаламжийн нэгжийг нэг бүрчлэн нягтлан шалгах ажлыг хийсэн. Шаардлагатай баримтад сэлбэн засалт хийх, хуудас буруу дугаарласан зэрэг зөрчилтэй баримтуудыг буцааж зөрчлүүдийг тухай бүр арилгуулан хүлээн авч хөмрөг үүсгэн, хөмрөгийн нэгдсэн жагсаалтад бүртгэв. Цахим нөхөн бүрдүүлэлтийн ажил 94 хувьтай. 2018 оны 03 дугаар улирлын байдлаар иргэд болон дүүргийн ажилтан, албан хаагчдаас 36 лавлагааны захиалга авч, цаасан суурьтай баримт болон цахим архиваас шүүж 134 хуудас баримтын лавлагаа олгосон. 134 хуудас лавлагаанаас 109 баримтад хуулбар үнэн тэмдэг дарж баталгаажуулж олгосон. Тамгын газрын албан хаагчдад 68 хадгаламжийн нэгж ашиглуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын архивын нөхөн бүрдүүлэлт 100 хувь хийгдэж нийт 7 хэлтсээс 755 баримтыг хадгаламжийн нэгж тус бүрээр нь шалгаж хуудасны тоо он цагийн хязгаарыг нь баримт хүлээлцэх акт болон хадгалах хугацааг нь батлагдсан				100 100

		хөтлөх хэргийн нэрийн жагсаалттай нь тулган хүлээн авсан.					
		5. Төрийн үйлчилгээний нэгдсэн сангийн төрлийг нэмэгдүүлж, дүүргийн вэб сайтыг хөгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудын дотуур холбоог шинэчлэн өргөжүүлнэ.	ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		Дүүргийн төрийн үйлчилгээний мэдээллийн цахим самбарыг шинэчлэн иргэд, олон нийтэд Засаг даргын Тамгын газрын нэг цэгийн үйлчилгээний танхим болон 19 хорооны нэг цэгийн үйлчилгээний танхимуудад байрлах ухаалаг дэлгэцээр төрийн үйлчилгээний мэдээллийг хүргэж байна. 2018 оны Хэлтэс, албадын хагас жилийн тайлан мэдээ болон ажлын байрны тодорхойлолтыг /Chingeltei.gov.mn/ сайтад байршуулан ажилласан. Смарт Чингэлтэй аппликейшны хөгжүүлэлт, идэвхжүүлэлт хийх ажлын хүрээнд төрийн үйлчилгээг сайжруулах талаар хэлтэс, албадаас санал авч, түүний дагуу Смарт Чингэлтэй аппликейшны ашиглалтыг идэвхжүүлэх 65 заалт төлөвлөгөө, хөгжүүлэлт хийх 18 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн нэгдсэн сүлжээний ашиглалт түүний засвар үйлчилгээний хүрээнд 9, 10 дугаар хорооны интернэт сүлжээний шилэн кабелин гэмтлийг мэргэжлийн байгууллагатай хамтран засвар үйлчилгээг суурилуулалтыг хийлгэж хэвийн ажиллагаанд оруулан ажилласан.			100	100	
53	5.1.3 Дүүргийн нэгдсэн сүлжээний ашиглалтын хүрээнд барилгажсан хэсэгт агаарын кабелийг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэн, сүлжээний найдвартай ажиллагааг бүрэн хангана.	1. Мэдээлэл холбооны сувагчлалын шинэчлэлийн ажлын хүрээнд агаараар явж байгаа трассыг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, гэмтлийг засварлан, сүлжээг өргөтгөнө.	ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		Мэдээлэл холбооны сувагчлал шинэчлэл, засварын ажлын хүрээнд дүүргийн 14, 17, 18 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж талбайн хяналтын камерын шилэн кабелиг засварлан шинээр татаж хайлаастын уулзварын шилэн кабелин худагд шилжүүлэн хэвийн ажиллагааг ханган ажилласан. Дүүргийн 12 дугаар хороо болон 61 дүгээр сургуулийн шилэн кабелин сүлжээ тасарсан байсан гэмтлийг тогтоон засварлаж хэвийн ажиллагаанд оруулан ажилласан.			100	100	
54	5.1.4 Захын болон алслагдсан гэр хороололд утасгүй Wi-Fi үйлчилгээг нэвтрүүлнэ.	1. Захын болон алслагдсан гэр хороололд утасгүй интернэт Wi Fi үйлчилгээний чанарыг сайжруулж хамрах хүрээг тэлнэ.	ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		

		Захын болон алслагдсан гэр хорооллын бүсэд утасгүй интернэт сүлжээ үүсгэх ажлын хүрээнд UB wifi утасгүй интернэтийн ажиллагааг Нийслэлийн Мэдээлэл технологийн газартай хамтран шалгасан. Ажлын үр дүнд шилэн кабелийн сүлжээгээр холбогдож буй утасгүй интернэт сүлжээний хурд болон түр ажиллахгүй байсан хороодын сүлжээг засварлан хэвийн ажиллагаанд оруулан ажилласан. 16, 17, 18, 19 дүгээр хороодын орчинд утасгүй интернэт сүлжээг шинээр өргөтгөн үүсгэх ажлын хүрээнд тоног төхөөрөмжийг худалдан авч, ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа. Тус ажлын хүрээнд дүүргийн 16, 17 дугаар хорооны ойр орчим утасгүй сүлжээний төхөөрөмж суурилуулан өргөтгөн ажиллалаа.			100	100	
55	5.1.5 Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлж, зөрчил дутагдлыг шуурхай арилгадаг, заавар зөвлөмжийг тогтмол өгдөг тогтолцоонд шилжүүлнэ.	1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй барилга угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдэд сургалт зохион байгуулна.	МХХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын хэлтсийн даргын 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдөр баталсан 02-01/28 тоот “Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга байгууламжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу барилгын үйл ажиллагаа явуулж буй Бармон ХХК, Ганхарш ХХК, Жи Жи ай ХХК, Рич констракшин ХХК-нуудад хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар Рич констракшин ХХК, Жи Жи ай ХХК-ууд нь 4.6 кодтой “Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”-аар “Бага” эрсдэлтэй, 4.1.2 кодтой “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар “Бага” эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Нийт 4 аж ахуй нэгжид 16 заалттай зөвлөмж өгч ажиллалаа. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй барилга угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдэд сургалт зохион байгуулахаар удирдамж төлөвлөгөө гарган, дүүрэгт барилгын салбараар үйл ажиллагаа явуулж буй 25 аж ахуй нэгжийн ажил олгогч болон ХАБ-н ажилтныг Барилгын талбайд “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, харилцан туршлага солилцох” сэдэвтэй сургалтад хамруулж, “Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуй” сэдэвт хичээл зааж, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар гарын авлага, зөвлөмжүүдийг өгч ажилласан.			100	100	
		2. Дүүргийн нутаг дэвсгэр дэх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудад гардаг халдварт өвчин,	МХХ, ЭМТ	Үйл ажиллагааны хэрэгжилт,	100%		

		<p>бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа явуулж, хяналт шалгалт хийнэ.</p>		хувиар			
		<p>Тайлант хугацаанд төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан төрийн өмчийн 4, төрийн бус өмчийн 2 цэцэрлэгийн эрхлэгч, багш, эмч нарт хүүхдийн байгууллагад цочмог халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, цочмог халдварт өвчин гарсан үед авч байгаа арга хэмжээний байдалд хяналт тавьж байгууллагын сургалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан. Дүүргийн ЭМН-тэй хамтран хүүхдийн байгууллагын эмч нарт улирлын шинжтэй гарч байгаа халдварт өвчнүүдийн мэдээлэл, эрт сэрэмжлүүлэг, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулан мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа. Дүүргийн ЭМН-тэй хамтран хүүхдийн байгууллагын багш, ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, шинжилгээний дүн эерэг үзүүлэлттэй гарсан ажиллагсдыг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцон ажиллалаа. МХЕГ-ын даргын баталсан 2018 оны 01/117 тоот “Бүх шатны сургалтын байгууллагын хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил, элсэлтийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 31 сургалт, хүмүүжлийн байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийж, тушаал шийдвэрийн хэрэгжилт, хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр шалгагдсан байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтын явцад шинээр ашиглалтад орсон болон, нэмэлт өргөтгөл баригдсан, хэсгийн болон зөөврийн усан хангамжтай 13 сургууль, цэцэрлэгийн , унд, ахуйн хэрэгцээний уснаас сорьц авч, шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж, ус нөөцлөх савны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хангаж ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажилласан. Дүүргийн хэмжээнд хүүхдийн байгууллагуудын ариутгал халдваргүйтгэлийг ханган ажиллаж байгаа Орхон овоот, Түвшинбилэг төгөлдөр ХХК-иудын халдваргүйтгэлийн бодисын чанар, хугацаа, баталгаажилтад хяналт тавьж ажиллахад чанарын баталгаажилттай, хадгалалтын хугацаандаа байна. Дүүргийн ЭМТ-өөс хүүхдийн байгууллагын багш ажиллагсдыг болон цэцэрлэгийн хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг зохион байгуулах удирдамж гарган, 2018 оны 08 дугаар сарын 24-нөөс 31-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд, гүйцэтгэлийн хяналт хийхэд хүүхдийн байгууллагууд шинжилгээний дүн эерэг гарсан хүүхдүүдийг эрүүлжүүлэх арга хэмжээг авч</p>	100	100			

		<p>цэцэрлэгтээ авсан байна. Удирдамжийн хүрээнд цэцэрлэгүүдийг хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээр хангадаг Багачууд хүнс ОНӨУҮГ, 5,17, 57, 39, 117, 138, 24, 23-р сургуулиудын цайны газар, үдийн цай хэрэгжүүлэгч ААН-ийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүний баталгаажилт, цайны газрын эрүүл ахуйн нөхцөл, цэвэрлэгээ үйлчилгээ, Үдийн цайны чанар аюулгүй байдалд шалгалт хийж, мөрдөж ажиллах тушаал шийдвэрийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>				
	<p>3. Дүүргийн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагаас үүдэн гардаг халдварт өвчнийг бууруулах талаар сургалт сурталчилгаа явуулж, хяналт шалгалт хийнэ.</p>	<p>МХХ, ЭМТ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100%</p>		
		<p>Дүүргийн Эрүүл мэндийн төв, 16 Өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ор бүхий эмнэлгүүдийн 40 эмч, эмнэлгийн ажилтнуудад “ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИХ ӨВЧНИЙ ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ” сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтын зорилго нь Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээг сайжруулах, ЭМС-ын 2017 оны А/328 тоот тушаалыг таниулах, анхан шатны тусламжийн чанар, оношилгоо эмчилгээний чадавхыг дээшлүүлэх, Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгэгдсэн алдааны мэдээлэлтэй танилцах, бусдын алдаанаас суралцаж, мэдлэг, мэдээллээ баяжуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний “Алдаа” гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдлээ. Сургалтын үр дүнд эмнэлгийн мэргэжилтнүүд хоолны халдвар гарсан үед бэлэн байдлыг хэрхэн хангаж ажиллах, бүтээгдэхүүнээс дээж авах арга, эрүүл мэндийн байгууллагын ажиллах зарчим, дээд шатны байгууллагад яаралтай хэрхэн мэдээлэх талаар мэдлэгтэй болсон. Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудад сэрэмжлүүлэх хуудас тарааж ажилласан. “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ” сэдэвт сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Эрүүл мэндийн төвийн сургалтын танхимд зохион байгууллаа. Сургалтын зорилго нь ӨЭМТ-үүдэд үзүүлж байгаа тусламж үйлчилгээг сайжруулах, ажиллаж байгаа эмч ажилчдыг мэдээллээр хангах, чадавхжуулах, мэдлэг, чадвар, дадал олгох, тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгоход чиглэгдлээ. Сургалтаар жирэмслэлттэй холбоотой хяналтын асуудал, сүүлийн үед эрүүл мэндийн байгууллагад хэрэглэгдэж байгаа ариутгал халдваргүйжлийн бодисын тухай, эмнэлгийн тусгай хог хаягдлын тухай мэдээлэл өгөв.</p>			<p>100</p>	<p>100</p>
	<p>4. Үйлчилгээний салбарт стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах зорилгоор</p>	<p>МХХ, ХХҮХ, ЦХ,</p>	<p>Үйл ажиллагааны</p>	<p>100%</p>		

		хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ.	Хороод	хэрэгжилт хувиар			
		<p>НМХГ-ын даргын баталсан 02-01/68 тоот “Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулахаар гурилан бүтээгдэхүүний 5, нөөшилсөн бүтээгдэхүүний 4, нийт 9 үйлдвэрийг 100% хамруулан 1.7.1, 1.7.2, 1.8.1, 1.8.2 кодтой хяналтын хуудсуудаар шалгалтыг хийхэд 3 бага, 6 дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Шалгалтын явцад ажлын байрны цэвэрлэгээ, угаалга, үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагаатай холбоотой 75 зөрчил илэрснээс 56 буюу 75%-ийг арилгуулж, 28 заалт бүхий албан шаардлага, 8 заалт бүхий албан даалгавар өгч, 9 байгууллагын 26 ажилтанд байгууллагын сургалтыг зохион байгуулсан тухай Хяналт шалгалтын ажлыг фэсебүүк хуудсаар 4 удаа олон нийтэд мэдээлж, 5 төрлийн зөвлөмжийг боловсруулж хүргүүлсэн. Шилэн хяналтын цахим мэдээллийн санд 100% оруулсан нэгдсэн танилцуулгыг бичиж, хавсралт хүснэгтүүдийн хамт ХАБХААХ-ын хэлтэст хүргүүлсэн. НМХГ-ын даргын баталсан 02-01/89 тоот “Савласан цэвэр ус, рашаан, ундаа шүүсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулахаар 1.20.1 кодтой Ус, рашааны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудасны дагуу төлөвлөгөөт шалгалтаар зарлагдсан Бест ноолиж ХХК-ийн усны үйлдвэрт шалгалтыг хийхэд “Дунд” эрсдэлтэй дүгнэгдсэн. Шалгалтын явцад Ус савлах технологийн дамжлагын схемийг гаргасан боловч жор орц, технологийн зааврыг гаргаагүй, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлүүдийг хөтлөөгүй байсан тул шалгалтын явцад ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн 10 төрлийн хүснэгтийг хүргүүлснээр 6 төрлийн бүртгэл хөтлөлтүүдийг хийж эхэлсэн. Танилцуулгыг бичиж, хэлтсийн удирдлагуудад танилцуулан, хавсралт хүснэгтүүдийн хамт ЭМБСХ-ын хэлтэст хүргүүлсэн. МХЕГ-ын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу НМХГ-ын даргын баталсан 02-01/72 тоот удирдамжийн хүрээнд нийт 61 газар зарлагдсанаас 58 аж ахуйн нэгж байгууллага иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 1.10.1,2,3,4 кодтой хяналтын хуудсаар үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Шалгалтын явцад 1.10.1 кодтой “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд 11 буюу 23 хувь нь бага эрсдэлтэй, 37 буюу 77 хувь нь дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтаар зөрчил дутагдал гаргасан 2 байгууллага, иргэнд нийт 2500.0 төгрөгийн шийтгэл ногдуулж, 62 заалт бүхий 13 улсын байцаагчийн хамтарсан албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллав. Шалгалтаар холбогдох хууль</p>			70	70	

		<p>дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. НМХГ-ын даргын баталсан 02-01/133 тоот “Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийх тухай”, 02-01/71 тоот “Хүнсний худалдааны газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 2018 онд төлөвлөгөөт шалгалтад хамрагдахаар 7 иргэн, 2 худалдааны төв, дэлгүүр зарлагдаж хяналт шалгалтад хамрагдсан. Шалгалтад хамрагдсан 9 аж ахуйн нэгжийн ногооны агуулах, худалдааны төв, хүнсний дэлгүүрт эрсдэлийн үнэлгээг хяналтын хуудсаар хийж 1.18 кодтой хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд ногооны 7 агуулах эрсдэлийн түвшин дунд эрсдэлтэй 5, бага эрсдэлтэй 2, худалдааны төв их эрсдэлтэй 1, хүнсний дэлгүүр дунд эрсдэлтэй 1 үнэлэгдлээ. Шалгалтын явцад давхардсан тоогоор 68 зөрчил илрүүлж 36 буюу 52.94 хувийг газар дээр нь арилгуулж, 48 заалт бүхий 9 албан шаардлага, 16 нэр төрлийн ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээс 37 дээж авч 156 үзүүлэлтээр лабораторийн шинжилгээнд хамруулж шинжилгээний хариуг үндэслэн улсын байцаагчийн 7 дүгнэлт бичсэн. Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 7 иргэн, 2 аж ахуйн нэгжид хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, шалтгаан нөхцөл, зөрчлийг хэрхэн арилгах болон шинэчлэн батлагдсан Тариалангийн тухай хууль, Ургамал хамгааллын тухай хуулийг дагаж гарсан “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журам”-ийг мөрдөж ажиллах талаар байгууллагын сургалт хийж зөвлөгөө өгч ажилласан.</p>				
	<p>5. Дүүргийн худалдаа, үйлчилгээний газруудын нэгдсэн мэдээллийн санг бий болгож, бүртгэлжүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч сургалт хийнэ.</p>	<p>МХХ, ХХҮХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100%</p>		
		<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Үйлчилгээ эрхлэх гэрээ” байгуулахад шаардлагатай хүнс, худалдааны чиглэлээр 7 төрлийн, сунгахад 3 төрлийн нийтийн хоол, үйлдвэрлэлийн чиглэлээр 10 төрлийн, ахуйн үйлчилгээний чиглэлээр 10 төрлийн, авто үйлчилгээний чиглэлээр 10 төрлийн, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний чиглэлээр 12 төрлийн, ЖДҮ-ийн чиглэлээр 7 төрлийн баримт бичгийн жагсаалтыг гаргаж, гарган www.chingeltei.gov.mn цахим сайтад байршуулан иргэдэд мэдээллийг ил тод, нээлттэй хүргэсэн. 2018 оны 9 дүгээр сарын байдлаар худалдааны чиглэлээр 250, ахуйн үйлчилгээний чиглэлээр 197, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр 230, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр 9, нийт 686 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулан мэдээллийг санд бүртгэсэн.</p>			<p>100</p>	<p>100</p>

56	5.1.6 Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	1. Дүүргийн хэрэгцээнд нийцүүлэн үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг 1-19 дүгээр хороонд бүртгэлийн 2-4 төрлийн үйлчилгээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	УБХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		<p>Дүүргийн 19 хорооны иргэний бүртгэлийн үйл ажиллагааг онлайн сангаас үзүүлж байгаа бөгөөд онлайн санг түшиглэн хороо бүрд шинэчилсэн бүртгэлийг хийх боломжийн талаарх судалгааг Иргэний бүртгэлийн ерөнхий газар, нийслэл дүүргийн нөхцөл байдалтай уялдуулан хийж байна. Нийслэлийн Улсын бүртгэлийн газарт туршилтаар 1 дүгээр хороон дээрээс шинэчилсэн бүртгэлийг хөтлөн явуулахаар саналыг хүргүүлсэн. Азийн хөгжлийн сангаас тус дүүргийн 16 дугаар хороог сонгож бүртгэлийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх талаар НЗД-тай хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хороонд иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай компьютер, принтер, скайнер, хуруу уншигч, зургийн аппарат, пос машин тус бүр нэгийг хүлээлгэн өгсөн. 2018.07.06-ны өдрөөс тус хорооны нэг цонхны үйлчилгээнд байршуулан үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ба туршилтын хугацаанд нийт 97 иргэнд үйлчилсэн байна. Одоогийн байдлаар Нийслэлийн Архивын газраас:</p> <ul style="list-style-type: none"> • Ажилласан жил тодорхойлох лавлагаа • Орон сууц эзэмших эрхийн бичгийн лавлагаа • Нотариатын лавлагаа <p>Улсын Бүртгэлийн Ерөнхий газраас:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэний үнэмлэх шинээр авах • Иргэний үнэмлэх шинэчлэх • Иргэний үнэмлэх дахин авах зэрэг 6 төрлийн үйлчилгээг хороодоор дамжуулан авч болох боломж бүрдсэн. 			100	100	
57	5.1.7 Гэр хорооллын гудамжны хаягжилтыг эрэмбэ дараатай цэгцлэн, иргэний бүртгэлийн хаягийн зөрчил давхардлыг арилгана.	1. Гэр хорооллын гудамжны хаягийн зөрчлийн судалгааг 2017 онтой харьцуулан гаргаж, зөрчлийг арилгах болзолт ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	УБХ, ГА	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
		Иргэний бүртгэлийн мэдээллийн сан болон ХАӨМС программын хаягийн зөрүүг арилгах ажлын хүрээнд тус дүүргийн 19 хорооны 12222 өрхийн 47536 иргэний мэдээллийг тулган ажиллаж байна. Мөн хаягандаа амьдардаггүй 839 иргэнийг шилжүүлэн ажиллалаа. Мөн зорилтод бүлгийн 17 иргэнийг бичиг баримтжуулан			100	100	

		ажилласан.Мөн дүүргийн объектын хаягийн судалгааг гаргаж, ИБГ-ын мэдээллийн сангийн хаягтай тулгалтыг хийж ажилласан.				
58	5.1.8 Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангуулан ажиллана.	1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэд, байгууллага аж ахуйн нэгжид сурталчилж, хяналт тавина.	ЦШ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Дүүргийн Засаг даргын 2018 оны А/44 дүгээр захирамж, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, дүүргийн Засаг даргатай хамтарсан удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 12 байгууллага, аж ахуйн нэгжид Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шалган туслах ажлыг зохион байгуулахаас төрийн 3, төрийн бус 9, нийт 12 аж ахуй нэгж, байгууллагын 783 цэргийн бэлтгэл үүрэгтнийг хамруулан, 219 иргэдийн зөрчлийг илрүүлж, цэрэг татлага, тоо бүртгэлээс завсардсан иргэдэд хуулиа биелүүлж, үүргээ ухамсарлах, шинээр батлагдсан Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах талаар яриа, таниулга хийж, зөвлөгөө өгч ажилласан. Цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн иргэдийг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 115 иргэнээр 46.987.276 төгрөгийн мөнгөн төлбөр төлүүлж нийслэлийн төрийн санд төвлөрүүлэн ажилласан.			100	100
		2. Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулна.	ЦШ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 97 жилийн ойн үйл ажиллагааны хүрээнд 03 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн ерөнхий боловсролын 12 сургуулиудын дунд цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж, ахлах ангийн 300 гаруй сурагчид авхаалж самбаа, оюун ухаан, тэсвэр хатуужил, ур чадвараа дайчлан уралдаж, тэмцээний багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд 39 дүгээр дунд сургууль, дэд байранд 23 дугаар дунд сургууль, гуравдугаар байранд 117 дугаар дунд сургууль тус тус байр эзэлж тэргүүлсэн. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 97 жилийн ойн баярын хурал, Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах өдөрлөгт иргэд болон бэлтгэл офицер, ахмад дайчин 380, оюутан сурагчид 100 бүгд 480 иргэнийг оролцуулан, дүүргүүдийн ЗДТГ-ын цэргийн штабууд үйл ажиллагаагаа нээлттэй сурталчилж ажилласан. Өрхийн хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 97 жилийн ажлын хүрээнд дүүрэгт оршин суудаг амьжиргааны түвшин доогуур 19 бэлтгэл офицер, ахлагч			100	100

	<p>нарт 100.000 төгрөг, хугацаат цэргийн албаа үлгэр жишээ хааж буй 6 байлдагчийн ар гэрт 500.000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн. “Мөрдөстэй залуу нас” сэдэвт алдаршуулах гурван үеийн уулзалт өдөрлөгийг хороодод зохион байгуулж нийт 1200 гаруй иргэн хамрагдаж, 80 гаруй ахмад дайчин, бэлтгэл офицер, хурандаа нарыг алдаршуулсан байна. Зэвсэгт хүчний 013, 015 дугаар ангийн хугацаат цэргийн алба хааж байгаа цэрэг дайчдыг эргэх, дүүргийн Засаг даргын мэндчилгээг хүргэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 97 жилийн ой тэмдэглэх тухай Нийслэлийн Засаг даргын А/141, дүүргийн Засаг даргын А/113 дугаар захирамжийн дагуу 03 дугаар сарын 20-ны өдөр Тусгаар тогтнолын талбайд “Эх орон тусгаар тогтнолын эзэд” андгай өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулсан. “Дөл” цогцолбор тэмцээний удирдамжид заасны дагуу 1, 2 дугаар байр эзэлсэн дүүргийн 39, 23 дугаар дунд сургуулийн сурагчдыг 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл ОХУ-ын Улан-Үд хотоор аялуулж, цэрэг спортын үйл ажиллагаа, батлан хамгаалах үйл ажиллагааг хөрш ОХУ-ын Советский дүүрэгт сурталчилсан нь үйл ажиллагаа орон нутаг төдийгүй хөрш зэргэлдээ хотуудад явагдсанаараа онцлогтой боллоо. Аяллын үеэр сурагчид Дархан-Уул аймаг дахь Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцаж, ангиас бэлтгэсэн жагсаалын үзүүлэх тоглолт болон зэвсэг техникийн үзэсгэлэн, урлагийн тоглолтыг үзэж сонирхсоны зэрэгцээ Сэлэнгэ аймаг дахь Хилийн цэргийн 0243 дүгээр ангитай танилцсан нь сурагчдын цэрэг эх оронч үзлийг бэхжүүлэх үр дүнтэй ажил болсон. Батлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлах болон хүүхэд залуучуудын цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллаж буй тус ангиудын материаллаг баазыг бэхжүүлэхэд зориулж Засаг даргын Тамгын газраас 3 үйлдэлтэй принтерийг тус 2 ангид гардуулан өгсөн. Дүүрэгт бэлтгэл болон чөлөөнд байгаа 400 офицер, ахлагч нарт Дуурь бүжгийн эрдмийн театртэй хамтран дуулалт жүжгийг үзүүлж оролцоогоо нэмэгдүүллээ. Батлан хамгаалах салбар ба эх оронч үндэсний үзэл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, иргэд, хүүхэд, залуучуудад Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа болон энхийг дэмжих ажиллагаанд цэргийн албан хаагчдын гүйцэтгэж байгаа үүргийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад сурталчлах, цэрэг эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас НҮБ-ын Энхийг сахиулагчдын өдрийг угтаж, дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран сурталчилгааны ажлыг Зэвсэгт хүчний 017, 284, 310, 337, 353 дугаар ангийн Энхийг</p>		
--	---	--	--

		сахиулагчидтай харилцан хамтран дүүргийн 5, 23, 24, 37, 39, 49, 50, 57, 61, 72, 117 дугаар сургуулиудад өдөрлөг уулзалтуудыг 2018 оны 5 дугаар сарын 9-нөөс 15-ны өдрүүдэд тус тус зохион байгууллаа. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб 14 дүгээр хорооны Засаг даргын ажлын алба, Зэвсэг хүчний 013 дугаар ангитай хамтран “Эх орны цэрэг” сэдэвт үйл ажиллагааг зохион байгуулж, цэргийн насны алба хаасан, хаагаагүй 50 иргэн оролцож, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн алба хаах хэлбэр, ашиглагдаж байгаа зэвсэг, техникийн талаар мэдээлэл өгч ажилласан. Цэргийн штаб нь ойн болон үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлуудаа нийслэл, дүүргийн цахим хуудсанд болон “MN-25”, “TV-5”, “TV-8”, “ETV”, UBS, “Эх орон”, ТМ, МНС, БХЯ-ны “Дуулга” зэрэг мэдээллийн хэрэгслүүдээр мэдээ, сурвалжилга өгч, Батлан хамгаалах бодлого, шинээр батлагдсан хууль тогтоомжуудыг сурталчлан ажилласан.					
59	5.1.9 Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлт, удирдлагын нэгдмэл байдлыг ханган ажиллана.	1. Дайчилгааны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилтийг ханган сургалтуудыг чанаржуулна.	ЦШ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		Аймаг, Нийслэл, дүүргийн Цэргийн штабын дарга, сургалтын офицеруудын заах арга зүйн цугларалт 2018 оны 01 дүгээр сарын 15-аас 18-ны хооронд дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, Төлөвлөлт сургалтын офицер ахлах дэслэгч нар хамрагдлаа. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хууль эрхзүйн шинэчлэлүүд, сургалт бэлтгэлийн өнөөгийн байдал, цэргийн бэлтгэл албаны сургалтыг орон нутагт зохион байгуулж байгаа байдал, хугацаат цэргийн албаны халалт, татлага зохион байгуулахад анхаарах асуудал, хугацаат цэргийн албанд татагдсан иргэдийн эрүүл мэндийн байдал, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн төсөл зэрэг олон сэдвээр өргөн хүрээг хамруулсан сургалтад хамрагдсан. Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсэгт заасны дагуу хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалт 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Батлан хамгаалах яамны хурлын танхимд явагдсан. Сургалтад Чингэлтэй дүүргийн хороодын Засаг дарга нар сахилга зохион байгуулалт сайн оролцсон. Зарлан мэдээллийн дохиогоор дүүргийн дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, хороодод зарлан мэдээлэх бүдүүвчийг 3-аас доошгүй сувгаар явуулахаар боловсруулан гүйцэтгэх үүргийг нь тодотгон 1, 2, 3 дугаар улиралд 1 удаа, нийт 3 удаа дайчилгааны зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, томилгоот бие бүрэлдэхүүнүүд мэдлэг, дадлагаа батжуулан ажиллалаа.			100	100	

	<p>Дүүрэгт Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах цэргийн штабын даргын шийдвэр боловсруулж, орон нутгийн цэргийн отрядуудын томилгоот бүрэлдэхүүн, отряд, суман, салаа, бүлгийн дарга нарыг тодотгож, дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа онц чухал объектуудын судалгааг гаргаж, сургалтад ашиглаж байна. Орон нутгийн цэргийн томилгоот бүрэлдэхүүнийг зэвсэглэхэд шаардлагатай галт хэрэглэлийн тооцоог хороодын татан нийлүүлэх төлөвлөгөөнд тодотгол хийж, хороодоос татан нийлүүлэх зэвсэг, галт хэрэглэлийн тооцоотой уялдуулан урьдчилан гаргасан. Дүүргийн цугларах болон шилжүүлэх байруудыг дэлгэх төлөвлөгөө, хавсралтуудад тодотгол хийж, байр, тасгуудад ажиллах бүрэлдэхүүнийг орон тооны дагуу байрын дарга нарын тушаалаар томилгоожуулан, үүрэг хүлээхэд бэлнээр ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын А/01 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2018 оны А/06 дугаар тушаалын дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг Цэргийн төв эмнэлгийн материаллаг баазыг түшиглэн 2018 оны 04 дүгээр сарын 11-нээс 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 58 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/398 дугаар, дүүргийн Засаг даргын 2018 оны А/304 дүгээр захирамжийн дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан 8 иргэнийг хуулийн дагуу элсүүлж, цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл шатны, II зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн анхан шатны сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/819 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/348 дугаар тушаалын дагуу цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс Үндэсний аврах бригадын материаллаг баазыг түшиглэн зохион байгууллаа. Тус сургалтаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнд орон нутгийн хамгаалалтад оролцох, гамшгаас хамгаалах болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, улсын болон орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох мэдлэг, дадлага эзэмшүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн томилгоот үүргээ биелүүлэх бэлтгэлийг олгох зорилготой юм. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/819 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/348 дугаар тушаалын дагуу цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 09 дүгээр сарын 27-ны өдрүүдэд ОБЕГ-ын харьяа</p>		
--	--	--	--

		<p>Үндэсний аврах бригадын материаллаг баазыг түшиглэн явагдлаа. Сургалтын хөтөлбөрийн дагуу орон нутгийн хамгаалалтад оролцох, гамшгаас хамгаалах болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, улсын болон орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох, хичээлүүдээр онол, дадлагын ур чадвар эзэмшиж, хууль тогтоомжоор хүлээсэн томилгоот үүргээ биелүүлэх бэлтгэлийг хангасан төгсөгчдөд гэрчилгээ гардуулах ёслолын ажиллагаа боллоо. Мөн хороодын Ажлын албаны дарга, зохион байгуулагч нарт батлан хамгаалах хууль, тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа байдал, Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, анги байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор цэргийн бэлтгэл сургалтыг 9 дүгээр сарын 28-ны өдөр Зэвсэгт хүчний 350 дугаар ангид зохион байгууллаа. Сургалтын явцад бэлэн байдлын зэргүүдэд шилжих үед хорооны татан нийлүүлэх төлөвлөгөөний дагуу улсын болон цэргийн дайчилгааны даалгаврын биелүүлэх боломж, хүн хүч, эд материалын тооцоог эдийн засгийн үндэслэлтэйгээр гаргах дадлага сургууль хийлээ. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2018 оны А/18 дугаар тушаалын дагуу бэлтгэл офицерын сургалтыг ҮБХИС-ийн материаллаг баазыг түшиглэн 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн зохион байгууллаа. Дүүргийн 1-19 дүгээр хорооны Засаг дарга нарын сургалтыг Зэвсэгт хүчний дугаар, Хилийн цэргийн дугаар ангиудын материаллаг баазыг түшиглэн 11 дүгээр сарын 1-2-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтаар батлан хамгаалах хууль, тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлж, Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа байдал, Хилийн анги байгууллагын хил хамгаалалтын үйл ажиллагаа, орон нутгийн иргэдийн хил хамгаалалтад оролцох явц, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, аймаг, дүүргүүдийн дайчилгааны даалгаврын онцлог, биелүүлэх боломж, анги байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцлаа.</p>				
	2. Цэргийн бүртгэлийг чанаржуулан 2018 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг халалт, татлага, ажлын байр, сургалт дамжаанд зуучилна.	ЦШ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		<p>Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/932 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын А/809 дүгээр захирамжийг гаргаж, 2018 оны цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын бүртгэлийг 1 дүгээр сарын 04-ний өдрөөс 1 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал зохион байгуулж явуулсан бөгөөд 100 хувьтай бүртгэгдсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт</p>			100	100

		<p>үйл ажиллагаагаа явуулдаг 8 байгууллагад хяналтын бүртгэл явуулж, алба хаагчдын судалгааг гаргуулан, бусад дүүргүүдийн цэргийн үүрэгтнүүдийн судалгааг Цэргийн штабуудад хүргүүлж ажилласан. Цэргийн бүртгэлийн мэдээ, судалгааг нэр, төрлөөр гаргаж, Нийслэлийн Цэргийн штабт тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргын тушаал, Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжуудыг үндэслэн 2018 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг 2018 оны 05 дугаар сарын 04, 05, 06-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, цэргийн жинхэнэ албанд татагдагчдын эрүүл мэндийн үзлэгийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор баталсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг баримтлан явууллаа. 2018 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/520 дугаар захирамжаар цэрэг татлагын байраар ерөнхий боловсролын 5 дугаар бүрэн дунд сургуулийг томилгоожууллаа. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/860 дугаар захирамжийн дагуу 2018 оны 2 дугаар ээлжийн цэрэг халах, татлагын бэлтгэл ажлыг ханган, дүүргийн 1-19 дүгээр хороодод цэргийн албанд татагдах зарлан дуудах мэдэгдлийг нэрсийн хамт хүрүүлэн ажиллаж байна. Цэргийн албаны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 7.7, 7.8, 7.9 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан журам, Батлан Хамгаалахын сайдын 2018 оны А/10 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/103, дүүргийн Засаг даргын 2018 оны А/107 дугаар захирамжийн дагуу 2018 онд зохион байгуулагдах “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад сайн дураар хамрагдах оюутнуудын судалгааг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн 5 их, дээд сургуулиас гаргуулан авч, болзол шаардлага хангасан 24 оюутныг эрүүл мэндийн үзлэгт оруулснаас 11 оюутан чөлөөлөгдөж, 13 оюутан эрүүл мэнд, биеийн тамирын шалгалтад бүрэн тэнцэж онолын сургалт, цэргийн ерөнхий бэлтгэлийн сургалтуудад хамрагдаж сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаснаар 2018 оны 08 дугаар сарын 16-ны өдөр ҮБХИС-ийн хээрийн сургалтын төвд цэргийн тангараг өргөсөн.</p>					
5.2 ГЭМТ ХЭРЭГ, ГАМШИГ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ							
60	5.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг	1. Иргэдийн аюулгүй, тайван орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах хууль, эрх	ЦХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		

<p>зохион байгуулж, үйлдэгдэж буй гэмт хэрэг, захиргааны зөрчлийг бууруулна.</p>	<p>зүйн мэдлэг олгох ажлыг зохион байгуулна.</p>				<p>100</p>	<p>100</p>
<p>Иргэдийн аюулгүй тайван орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах хууль эрх зүйн мэдлэг олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 13 дугаар тогтоолоор “Хэв журмын урамшилт эргүүл” ажиллах журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт, гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт 1 дүгээр улиралд нийт 23 иргэн хэв журмын урамшилт эргүүлээр ажилласан. Хэв журмын урамшуулалт эргүүлүүд хариуцсан хороодын нутаг дэвсгэртээ өдөр бүр 4-5 цагийн явган эргүүлийн үүргийг гүйцэтгэж гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй хүн ихээр цуглардаг эмзэг цэг, газруудад эргүүлийн үүргийг гүйцэтгэх хугацаандаа олон нийтийн цагдаа, хороо хариуцсан цагдаа нарын хамт Зөрчлийн тухай хуулийг 8 удаа иргэд олон нийтэд сурталчлан ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 115 аж ахуйн нэгж, 45 сурагчдад гэмт хэрэг зөрчилд өртөж хохирохгүй байх талаар зөвлөмж өгсөн. Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд хяналт тавьж хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, хангалтаар олгосон техник хэрэгслийн ашиглалтад 2 удаа үзлэг тооллого хийж, мэргэжил арга зүйгээр хангаж, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр 1 удаа баталгаа авч, 2 удаа зөвлөмж, зааварчилгааг өгч үр дүнг тооцсон. Цагдаагийн байгууллагаас цэргийн байнгын тэтгэвэрт гарсан иргэдийн судалгааг нийслэлийн цагдаагийн газраас авч хариуцсан дүүргийн гэмт хэрэг зөрчил үйлдэгдэх магадлалтай газруудад нэмэгдлээр эргүүл жижүүр ажиллуулах, сэрэмжлүүлэг тараах, яриа таниулга хийх ажилд татан оролцуулж, сар шинийн баяраар эргүүл зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийн судалгааг сар бүр гаргаж, онцлог шинж тэмдэг, гарын хурууны хээ, үс, хумс зэргээс авч хорооны хэсгийн байцаагч нарт бүртгэлээр хадгалуулж, хойшид хэн болох нь тогтоогдохгүй байдлаар нас барсан осол аваарт орсон тохиолдолд таньж олуулахад хялбар болгох зэрэг ажлуудыг давхар зохион байгуулсан. Нийслэлийн цагдаагийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/03 дугаар тушаалаар “Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, аж ахуй нэгж байгууллагын гадна орчин, гудамж талбайд үйлдэгдэж</p>						

	<p>буй хулгайн гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох” зорилгоор зохион байгуулагдсан “Камержуулалт-2” аян зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэргийн илрүүлэлт сайжирсан. 2017-2018 оны хичээлийн жилд 2113 суралцагчтай Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран сургуулийн анги, коридор, ариун цэврийн өрөө, цайны газар, сургуулийн гадна орчинд “TGNM systems” ХХК-наас нийт 8984000 төгрөгийн өртөг бүхий IP теле камер 45 ширхгийг байршуулж сургуулийн орчин бүрэн камержуулснаар сургуулийн орчинд сурагчдын аюулгүй орчин бүрдэж эцэг, эхчүүд гар утсандаа “IP PRO” аппликейшн суулган хүүхдээ гар утаснаасаа хянах боломж бүрдэж сургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэрэг буурч 2018 оны 1 дүгээр улиралд энэ төрлийн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 37,3 хувь буурсан. Мөн дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Космолайн ХХК 45 хоногийн бичлэг хадгалдаг 12 ширхэг теле камерыг “Лимон 25” урт цагаан салбар дэлгүүрт 190 метр квадрат талбайд 20 сая төгрөгөөр, Лимон 25 дэлгүүрийн 50.0-т салбарт дотор талд 7, гадна талд 1 ширхэг теле камерыг тус тус байршуулан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Мөн дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байнгын ажиллагаатай хяналтын камерыг Амар-Од ХХК-ны Авто засварын баруун талд, Баруун тасганы а-18 тоотод 1 ширхэг теле камер, Naru гэрэл зургийн студийн урдуур явсан төв замын гэрлэн дохионы шонгийн модон дээр, Халлелүяа сүмийн баруун хойд талд төв зам дээр, Дунд тасганы 2 дугаар гудамж 11 тоотын баруун үзүүрийн шон дээр, Зүүн тасганы 12 дугаар гудамж 219 тоотын зүүн хойд талын шон дээр тус бүр 2 ширхэг/нийт 9/ теле камерыг Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр суурилуулсан. Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 15 сургуулийн орчныг камержуулах ажлыг өргөжүүлэх, “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн сурагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох, тэднийг болзошгүй эрсдэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн сурагчдын анхдугаар чуулганыг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн 57 дугаар дунд сургуульд зохион байгуулж, иргэд олон нийтэд сурталчилсан. Дүүргийн 3 дугаар хороо Камержуулалт аяны хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх зорилгоор 6 аж ахуйн нэгж байгууллага, 3 сууц өмчлөгчдийн холбоо, 1 иргэн орон нутгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж талбайд шинээр камер суурилуулж, гадна талд 26, дотор талд 74 ширхэг нийт 100 ширхэг камерыг тавьж, Камержуулалт-2 аянд “Хороо” номинацид шалгарахаар материалаа</p>		
--	--	--	--

	<p>хүргүүлээд байна. Нийслэлийн цагдаагийн газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр “Хамтарсан баг”-аар ажиллах төлөвлөгөө боловсруулан 1-9 дүгээр хорооны Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын дарга, хороодын хэв журмын урамшилт эргүүл, урамшуулалтай эргүүл, нийтийн эргүүлийн 186 иргэдтэй уулзалт зохион байгуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөршийн хяналтын бүлгийн талаар, гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиар сургалт, нөлөөллийн ажлыг хороодын иргэний танхимд зохион байгуулан тэдний санал хүсэлтийг сонсож иргэдийг идэвхжүүлэн ажилласан.</p>				
	<p>2. Урамшилт эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, гэмт хэрэг ихээр үйлдэгддэг цэгийн судалгааг шинэчлэн боловсруулж, байнгын хяналт тавьж ажиллана.</p>	<p>ЦХ, ЗЦХ, ГХУСАЗС 3</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>	
	<p>Иргэдийн амгалан тайван байдлыг хангах, хулгайлах болон гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Сар шинэ, Хуулийн хэрэгжилт, Хяналт, Нээлт-Хаалт, Сэрэмжилье-нэгдье, Саун массаж, Илрүүлэлт-Оргодол, Эмзэг цэг, хяналт шалгалт зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж гэмт хэрэг ихээр үйлдэгддэг эмзэг цэгийн судалгааг шинэчлэн гаргаж байнгын хяналт тавьж ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт МУ-ын Замын хөдөлгөөний дүрмийн 11.5 дах “Түр буюу удаан зогсохыг хориглоно” заалтыг ихээр зөрчигддөг гудамж, замуудын судалгааг гаргаж урамшуулалт эргүүлийн хуваарийг Хуульчдын гудамж, Төмөрчний гудамж, Жуулчны гудамж, Лааганы гудамж, Их тойруу зэрэг гудамж замуудад өдрийн ээлжээр байнгын хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 126 дугаар тогтоолоор батлагдсан “Хөршийн хяналт” хөтөлбөр, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Чингэлтэй дүүргийн хороодын гудамж, байранд нийтийн эргүүлийг ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг тус тус хангах чиглэлээр Хөршийн хяналтын 16 бүлгийн 95 гишүүдтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрсдийн хариуцсан гудамж, талбай, амьдарч буй орчин, айл хөршийн өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, сэжигтэй хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйлийн талаарх 15 мэдээ мэдээллийг цагдаагийн байгууллагад тухай бүрд нь өгч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд</p>			<p>100</p>	<p>100</p>

		<p>туслалцаа үзүүлэн тухайн зөрчлүүдийг газар дээр нь цагдаагийн алба хаагчаар шалгуулсан. Мөн гудамж талбайд архидах, танхайрах зэрэг 20 зөрчлийг илрүүлж шийдвэрлүүлсэн. Дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Соёл урлагийн их сургууль”, “Хөдөлмөр нийгмийн харилцааны дээд сургууль”, “Улаанбаатар Эрдэм-Судлал”, “Шинэ иргэншил”, “Улаанбаатар Эрдэм-Оюу”, “Соёлын дээд” сургууль, ерөнхий боловсролын 5, 50, 23, 24 дүгээр дунд сургууль, 9, 18, 33, 39, 70, 74, 108, 245, “Басархан”, “Маамуу нааш ир”, “Гэрэл”, “Алунгоо” зэрэг цэцэрлэгийн 2018-2019 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээ зохион байгуулагдах үед 2018 оны 09 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд хэсгийн байцаагч, хороон цагдаа нарын хамт хэв журмын урамшилт эргүүлүүд хэв журам сахиулан ажилласан.</p>					
		<p>3. "Иргэдийн оролцоотой-Хяналттай орчин" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг ГХУСАЗСЗ-тэй хамтран хэрэгжүүлнэ.</p>	<p>ЦХ, ЗЦХ, МХХ, ОБХ, ГБХЗХХ, ГХУСАЗС 3</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>		
		<p>"Иргэдийн оролцоотой-Хяналттай орчин" хөтөлбөрийн хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын 50 дугаар сургууль дотоод нөөц бололцоогоо ашиглан нийт 45 анги танхим, урлаг заал, цайны газар, гадна орчныг сүүлийн үеийн TP PRO технологийн теле камераар бүрэн камержуулснаар сургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэрэг 5 хувиар буурсан байна. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газар, дүүргийн Замын Цагдаагийн хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний түгжрэл саатлыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ААНБ, Төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангах, хамтран ажиллах зорилгоор “замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа” нэгдсэн зөвлөгөөнийг анх удаа зохион байгуулсан. Дүүргийн ГХУСАЗСЗ, Боловсролын хэлтэс, Цагдаагийн 1, 2 хэлтэс, Дэлхийн зөн ОУБ-ын Хайлааст ОНХХ, Чингэлтэй ОНХХ, дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн сурагчдын анхдугаар чуулганыг амжилттай зохион байгуулсан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газар хамтран “Олон нийтийн оролцоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа” нэгдсэн сургалт зөвлөгөөнийг олон улсын хүүхдийн</p>		<p>70</p>	<p>70</p>		

		Найрамдал төвд 10 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж 600 гаруй гудамж байрны нийтийн эргүүл, жижүүр, хэв журмын урамшилтай эргүүлүүд оролцсон.				
61	5.2.2 Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай техник хэрэгслээр хангана.	1. Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай техник хэрэгслээр хангана.	ЗДТГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Цагдаагийн ерөнхий газрын замын цагдаагийн албанаас дүүргийн замын цагдаагийн хэлтсийн 8 автомашинд замын хөдөлгөөнийг хянах боломжтой хар хайрцгийг суурилуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах зам руу харсан аж ахуй нэгж байгууллага, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс болон дүүргийн хөрөнгөөр шинээр суурилуулсан камеруудыг хянах зорилгоор теле хяналтын төвтэй болгох саналыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд хүргүүлснээр 64,6 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж теле хяналтын төвийн байрны засварын ажлыг дуусгаж, шилэн кабелийг хэлтсийн байртай холбож, серверийн өрөөг тохижуулсан. Нийслэлийн цагдаагийн газраас дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэст иж бүрэн 5 компьютер хүлээлгэн өгч, алба хаагчдыг техник хэрэгслэлээр хангаж ажилласан. Мөн тус хэлтсийн Төв байрны хаалганы баруун талд байрлах унадаг дугуйн зогсоол, зогсоолын ард ил тод байдлыг хангах чиглэлээр 12 метр урттай 2,7 метр өндөртэй зурагт самбарыг “Би Би Икс Эл” компаниар хийж гүйцэтгүүлэн мэдээллүүдийг бэлтгэн иргэд, болон алба хаагчдад танилцуулан ажиллаж байна.			100	100
62	5.2.3 Замын хөдөлгөөний зохицуулалтыг оновчтой болгож, зам тээврийн осол, хэргийн гаралтыг бууруулна.	1. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гудамж, замуудад хяналтын камер, зөрчил илрүүлэгч камер, зуслангийн замд хурд хэмжигч, мэдээлэх төхөөрөмж суурилуулна.	ЗЦХ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		Зам тээврийн хэрэг, ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор ЧД-ийн 19 дүгээр хороо “Тэс петролиум ШТС”-ын хажууд хурдны мэдээлэх самбар, Яргайтын уулзварын урд талын “МТ ШТС”-ын хажууд маяк байрлуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлуулсан 96 цэгийн 102 ширхэг теле камерыг хянах зорилгоор хэлтсийн байранд камерын хяналтын өрөөг тохижуулан камеруудын холболтын ажлыг гүйцэтгэсэн. Зуслангийн замд зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд Зуслангийн замд хурдны мэдээлэх электрон самбар 2 ширхгийг байрлуулах саналыг хүргүүлснээр 800.000 төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж 19-р хорооны			100	100

		<p>нутаг дэвсгэрт байрлуулсан. Чингэлтэй дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хөрөнгийг шийдвэрлүүлж авсан тус хэлтэст бүртгэлтэй зөөврийн хурд хэмжигчийг стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулан авч, Зуслангийн замд байрлуулан тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлсэн 968 зөрчил илрүүлж, Замын хөдөлгөөний удирдлагын төвөөр баталгаажуулан тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрийн хаягаар торгуулийн хуудас хүргүүлэх ажлыг зохион байгуулан гарч болзошгүй зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Мөн дүүргийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар гарсан зам тээврийн хэрэг, ослын судалгааг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдлаар гаргаж, зам тээврийн хэрэг, осол ихээр гардаг авто замуудад буюу Тасганы овооны уулзвараас Баянбүрдийн тойрог хүртэлх замд, Зуслангийн зам МТ шатахуун түгээгүүрийн хажууд, Хайлаастын замд тус бүр 1 ширхэг байнгын ажиллагаатай “Маяк” байрлуулж зам тээврийн хэрэг осол гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.</p>					
63	5.2.4 Дүүргийн гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.	1. Гэр хороолол, зуслангийн бүсийн айл өрхүүдэд шуурхай албаны автомашин очих боломжгүй мухар гудамжийг чөлөөлж, гарц гаргана.	ОБХ, ГА, Хороод	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%		
		<p>Нарийн болон мухар гудамж, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын зурваст суурьшсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгаанд тодотгол хийсэн. Тус судалгаагаар зам гарцыг хааж мухар гудамж гаргасан 210 өрх, өндөрлөг болон гуу жалганы ирмэг дээр буусан, шуурхай албаны машин хүрэлцэн очих боломжгүй 354 өрх, үерийн аман дээр буусан шар усны үерт өртөх магадлалтай 640 өрх, өндөр хүчдэлийн дор буусан 144 өрх, нийт 1204 өрх эрсдэлтэй бүсэд оршин сууж байна. Үүнээс 354 айл өрхийн гал унтраах тусгай зориулалтын автомашин хүрэлцэн очих боломжгүй, мухар гудамж, өндөрлөг газрын судалгааг айл өрх тус бүр дээр “Google ear” болон фото зургаар баталгаажуулан ажилласан. Мөн дүүргийн 7-19-р хороодын зөрчил заагдсан айл өрхүүдэд “Аюулт үзэгдэл техникийн холбогдолтой ослын үед шуурхай албаны автомашин хүрэлцэн очих боломжийг хязгаарлаж, зөвшөөрөлгүй барьж сунгасан хашаа, хаалт, хайс, гарааш, өргөтгөлийг чөлөөлөн шуурхай албаны автомашин орох, гарах боломжоор хангах” тухай улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлэн ажилласан. Мөн Улсын Онцгой комиссын хурлын 01 дүгээр тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/471 дүгээр албадан чөлөөлөх захирамжаар үерийн</p>				100	100

		<p>аюултай бүсэд зөвшөөрөлгүй суурьшсан иргэдийг яаралтай нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Албадан чөлөөлөх үйл ажиллагааны хүрээнд үерийн аюултай бүсэд зөвшөөрөлгүй суурьшсан нэгж талбарын судалгааг хороодтой хамтран гаргаж 7, 12, 16 дугаар хороонд 13 нэгж талбарыг чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэлээ. Дүүргийн 16 дугаар хороонд нүүлгэн шилжүүлэх байршлыг тогтоон 14 нэгж талбарт “Рэд Лайн оф Ланд” ХХК-иар эргэлтийн цэг тэмдэгтийг тогтоолгож судалгаанд хамрагдсан иргэн тус бүр 400м2 талбайг олгож, шилжүүлэн суурьшуулж ажиллалаа.</p>				
	<p>2. Мал амьтныг вакцинжуулалтад хамруулах, дүүргийн нутаг дэвсгэрээс нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>МЭҮА, ХХҮХ, ОБХ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>100%</p>		
		<p>Дүүргийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын үүрэг болгосноор дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс хамтран Анко ХХК-ний Нарантуул-2 худалдааны төвд хамтарсан шалгалт хийж, 4 албан тушаалтан, 8 махны худалдаа эрхлэгч иргэдэд ажлын байр дээрх зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 20 нэр төрлийн мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, НМХГ, МХЕГ, ЧД дэх МХХ-ээс гаргасан эрсдэлээс сэргийлэх, дотоод хяналт шалгалтаа сайжруулах, ариутгал халдваргүйжүүлэлтийг чанартай хийх, 50 метр ойр орчны цэвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөдөө орон нутгаас орж ирж малын гаралтай түүхий эд тээвэрлэсэн машинд гарал үүслийн гэрчилгээг шалган, тайван бүсээс нийлүүлэх, аливаа эрсдэлээс сэргийлж ажиллах талаар зөвлөгөө өгч ажиллалаа. Түүнчлэн дүүргийн нутаг дэвсгэрээс буюу мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал бүхий өрхүүдийг гаргах ажлын хэсгийг Дүүргийн Засаг даргын 2018 оны А/148 дугаар захирамжаар байгуулж, ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулсан бөгөөд дүүргийн 12, 16, 17, 19 дүгээр хороодын нийт 47 мал бүхий өрхийг Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд нүүлгэн шилжүүлж, 1 өрхийн 19 толгой мал үлдээд байна. Нүүлгэн шилжүүлсэн малын хашаа саравчийг буулгах ажлыг Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах 10 дугаар ангийн 60 албан хаагчид гүйцэтгэж, дүүргийн Тохижилт үйлчилгээний компани ХХК 1 ковш, 10 хог ачих машинаар өтөг бууцыг ачих, дүүргийн мал эмнэлэг Содхан ХХК-ниас 3 малын эмч ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг тус тус хариуцаж, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.3 сая төгрөг зарцуулсан байна. Нэг өрхөөс дунджаар 3-4 машин өтөг бууц гарч байгаа бөгөөд нийт 98 машин өтөг бууцыг хогийн төвлөрсөн цэгт буулгасан байна. Мал эмнэлэг Сод хан ХХК-иас 49 өрхийн</p>			<p>100</p>	<p>100</p>

		6190 мкв талбайг һисор уусмал болон хлорын шохойгоор ариутгах ажлыг хийсэн.					
		1. Дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	ОБХ, ТЗУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%		
64	5.2.5 Дүүргийн нутаг дэвсгэрт “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	<p>Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ахлагч, ажилтнуудтай 2018 онд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, 2018 онд хийж гүйцэтгэх ажлыг хэсгийн хурлаар хэлэлцэн, үүрэг даалгавар өглөө. Дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Улаан загалмайн хороотой хамтран 2018 онд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хороод, аж ахуйн нэгж байгууллагуудад хийх гамшгаас хамгаалах сургалтын хамтарсан төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Гамшгаас хамгаалах “Сайн дурын хэсэг”-ийн “Лого” билэгдэл, таних тэмдгийн загварыг хийх ажлыг эх бэлтгэлд өгөөд байна. Сайн дурын хэсгээс хийж гүйцэтгэсэн ажил, сургалт зохион байгуулсан илтгэх хуудсыг цаг тухай бүрд нь дүүргийн цахим хуудсаар мэдээлэн ажиллаж байна. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, гамшиг аюул, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр, дүүргийн Засаг даргын “Бид аварна, тусална” сэдэвт тэмцээн зохион байгуулах удирдамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 19 хороонд Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг байгуулан 3200 гаруй хүнийг бүртгэлжүүлэн нэгдсэн зохион байгуулалтад оруулж хороо тус бүр дээр 3-8 удаагийн онолын сургалт, дадлагыг зохион байгууллаа. Дүүргийн 39, 50 дугаар сургуулийн 2000 сурагч “Нийслэлийн гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв”-тэй танилцаж, гамшиг осол гарсан үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах талаар мэдэгдэхүүнтэй боллоо. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Гамшиг, онцгой байдлын үед ажиллах сайн дурын идэвхтэн” бэлтгэх, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх арга зүйн заавар зөвлөгөө өгөх сургалтыг 8 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгууллаа. Дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Дэлхийн зөн Чингэлтэй, Хайлааст орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Улаан загалмайн нийгэмлэг, Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгтэй хамтран 8,9,10,11,12 дугаар хорооны 1000 иргэнд гамшиг ослын талаар цэгцтэй мэдлэг олгох, өрхийн түвшинд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилготой “Бэлэн бай” сургалтыг 2018 оны 04 дүгээр</p>				100	100

		сарын 24-өөс 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хороодтой хамтарсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар галын тоогоор өндөр үзүүлэлттэй гарсан 19 дүгээр хороонд Галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, айл өрх болон объект хоорондын аюулгүй зай хэмжээ зөрчигдсөн, үнс нурмаа ил задгай асгасан, үнсний сав таггүй, цахилгааны холболт, ашиглалт, угсралтын аюулгүй байдал алдагдсан, пийшин зуухны гэмтэлтэй, яндангийн хамгаалалт хийгээгүй, залгаас буруу, бага насны хүүхдийг гэртээ цоожилж орхидог, шуурхай албаны автомашин очих боломжгүй мухар гудамж, өндөрлөг газар, өндөр хүчдэлийн шугаман дор буусан айл өрхөд мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, иргэд олон нийтэд санамж сэрэмжлүүлэг тарааж, 12 хэсгийн 59 зөрчилтэй айлыг илрүүлж, “Гал түймэр”, “Газар хөдлөлт” сэдвээр 112 иргэнд танхимын сургалт зохион байгууллаа.					
	2. Дүүргийн хэмжээнд гамшгийн нөөц бүрдүүлнэ.	ОБХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%			
		Дүүргийн Засаг даргын 2018 оны “Хөрөнгө гаргах тухай” А/100 дугаар захирамжаар 3.280.0 мянган төгрөг, Мөн дүүргийн Засаг даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, ариутгал халдваргүйтгэл, хяналтын байнгын пост ажиллуулах тухай” А/167, “Онцгой комиссын бүрэлдэхүүнд сургалт, дадлага зохион байгуулах тухай” А/168 дугаар захирамжаар 2.307.0 мянган төгрөг, 2018 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн А/234 дүгээр захирамж “ Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” –аар 3.124.5 мянган төгрөг, 2018 оны 06 сарын 08-ний өдрийн А/350 дугаар захирамжаар 9.226.6 мянган төгрөг, “ Хөрөнгө гаргах тухай” А/372 дугаар захирамжаар 1.200.0 мянган төгрөг, “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж үүрэг гүйцэтгэх тухай” А/397 дугаар захирамжаар 1.526.450 мянган төгрөг, “Хашаа хороо буулгах, ариутгал хийж тухай” А/428 дүгээр захирамжаар 696.0 мянган төгрөг “Гамшгаас хамгаалах тактикийн сургалт зохион байгуулах тухай” А/455 дугаар захирамжаар 2.763.0 мянган төгрөг, “Албадан нүүлгэх тухай” А/471 дүгээр захирамжаар 2.450.0 мянган төгрөг нийт 24.036.553 мянган төгрөгийг шийдүүлж зориулалтын дагуу зарцуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.				100	100
	3. Дүүргийн хэмжээнд гамшиг ослын цагийн байдлын тухай мэдээллийг	ОБХ	Үйл ажиллагааны	100%			

	цуглуулж үнэлэх, эрсдэлийн зураглал хийж судалгаа гаргах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.		хэрэгжилт, хувиар		
	Гал түймэр унтраах, аврах 10 дугаар анги нь 92 удаагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гал түймрийн дуудлагаар 145 удаа гарснаас 105 гал түймэр дээр байлдааны тархалт хийж, 33 гал түймрийг иргэд унтрааж, худал дуудлага-5 удаа, өөрөө унтарсан 2 удаа нийт 24 цаг 05 минут ажиллаж 108,2 тн ус, шатах тослох материал дизель түлш 6416,4л 13,795,260 төгрөгийг зарцуулан 90 иргэн, 53 байшин барилга, иргэдийн 686 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна. Дүүргийн хэмжээнд 2015-2017 онд тохиолдсон гамшиг ослын судалгааг гаргаж, нийслэлийн Онцгой байдлын газарт хүргүүлснээс гадна дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгтэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт тохиолдсон үер, гал түймэр, ой хээрийн түймэр, гамшигт өртсөн хүн, хүүхэд зэрэг гамшгийн судалгааг сүүлийн 10 жилээр шүүн гарган бүртгэлжүүлсэн.			100	100
	4. Дүүргийн нутаг дэвсгэрт “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд хүн малын гоц халдварт өвчний үед онцгой комиссын болон онцгой байдлын бүрэлдэхүүнд хөдөлгөөнт штабын байр, хийлдэг майхнаар хангана.	ОБХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	
	Онцгой байдлын ерөнхий газар, дүүргийн Засаг дарга нарын уулзалтаар байгуулсан санамж бичгийн дагуу дүүргийн 19 дүгээр хороо Гүнтийн давааны орчимд зуслангийн бүсэд байнгын хяналтын постын барилга барих ажлын зургийг гэрээний дагуу “Ногоон хөгжлийн гүүр” ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/816 дугаар захирамжаар 684 м2 газрыг баталгаажуулсан. Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас барилга барих, эхлүүлэх зөвшөөрөл А даалгавар, цахилгааны техникийн нөхцөл, хөрсний геологийн дүгнэлт гарч, бэлэн болсон. Барилга хөгжлийн төвөөр ерөнхий магадлал хийгдэж байна. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/167 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулахаар дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр Ар гүнтийн даваанд 24 цагийн байнгын ажиллагаатай хяналтын цэгийг 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ажиллуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллалаа. Тус хяналтын цэгт Онцгой			70	70

		байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс, Мал эмнэлэг үржлийн алба хамтран ажилласан бөгөөд нийт 20 албан хаагч ээлжийн үүрэг гүйцэтгэж ажилласан.		
--	--	---	--	--

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР